



# ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Компанийн загвар,  
бүтэц, дүрэм, журам,  
гэрээний төслүүд



2023 он  
ДАВАА ФАЙНКОН ХХК

## Агуулга

<b>Нэг. УДИРТГАЛ</b> .....	2
<b>1.1 Зөвлөх үйлчилгээний ажлын зорилго</b> .....	2
<b>1.2 Зөвлөх үйлчилгээний тайлангийн хураангуй</b> .....	3
<b>Хоёр. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ТӨРӨЛ ХЭЛБЭР, БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ</b> .....	4
<b>2.1 Хуулийн этгээдийн төрөл хэлбэр</b> .....	4
<b>2.2 “Компани”-ийн тухай ойлголт</b> .....	5
<b>2.3 Компанийн загвар, бүтэц зохион байгуулалт</b> .....	6
<b>Гурав. ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧГҮҮД</b> .....	9
<b>3.1 Компанийн дүрэм</b> .....	9
3.1.1 Компанийн тухай хуулийн дагуу дүрэмд заавал тусгах зохицуулалтууд .....	10
3.1.2 Компанийн засаглалын кодексийн зарчмуудыг хангах зохицуулалтууд .....	11
3.1.3 Компанийн дүрэмд өөрөөр зааж болох зохицуулалтууд .....	11
3.1.4 Хуулиар хориглоогүй нэмэлт зохицуулалтууд .....	12
3.1.5 Байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-тай холбоотой зохицуулалтууд .....	12
<b>3.2 Хувьцаа худалдах худалдан авах гэрээ</b> .....	13
<b>3.3 Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам</b> .....	15
<b>3.4 Опцион эрх хэрэгжүүлэх журам</b> .....	15
<b>3.5 Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах журам</b> .....	16
<b>3.6 Ногдол ашгийн бодлого</b> .....	16
<b>3.7 Гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээ</b> .....	17
<b>Дөрөв. ХАВСРАЛТУУД</b> .....	19
<b>Хавсралт 1. Компанийн бүтэц зохион байгуулалтын функциональ загвар</b> .....	19
<b>Хавсралт 2. Компанийн дүрмийн төсөл</b> .....	20
<b>Хавсралт 3. Компанийн тухай хуулийн зохицуулалтууд</b> .....	36
<b>Хавсралт 4. Компанийн засаглалын кодексийн зохицуулалтууд</b> .....	39
<b>Хавсралт 5. Компанийн дүрмийн зохицуулалтууд</b> .....	42
<b>Хавсралт 6. Хууль тогтоомжтой зөрчилдөөгүй зохицуулалтууд</b> .....	51
<b>Хавсралт 7. Хувьцаа худалдах худалдан авах гэрээний төсөл</b> .....	52
<b>Хавсралт 8. ТУЗ-ийн үйл ажиллагааны журам</b> .....	64
<b>Хавсралт 9. Опцион эрхийг хэрэгжүүлэх журам</b> .....	78
<b>Хавсралт 10. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах журам</b> .....	79
<b>Хавсралт 11. Ногдол ашгийн бодлого</b> .....	82
<b>Хавсралт 12. Гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээний төсөл</b> .....	84
<b>Хавсралт 13. Зөвлөх үйлчилгээний компани, зөвлөхийн тухай мэдээлэл</b> .....	92
<b>Ашигласан материалын жагсаалт</b> .....	94

## Нэг. УДИРТГАЛ

### 1.1 Зөвлөх үйлчилгээний ажлын зорилго

Монгол Улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооноос чөлөөт зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжээд гуч гаруй жил өнгөрсөн боловч мал аж ахуйн гаралтай бараа бүтээгдэхүүн, түүхий эдийг бэлтгэх, худалдан борлуулах, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, гадаад дотоодын зах зээлд худалдан борлуулж ашиг хүртэх сайн дэд бүтэц, зөв зохистой тогтолцоо өнөөдрийг хүртэл бий болж чадсангүй. Тухайлбал Говь-Алтай аймгийн 8000 гаруй малчин өрхийн орлогын гол эх үүсвэр болох 1.2 сая толгой ямаан сүргээс нэг жилд самнах 700 гаруй тонн ноолуурын ихэнх хэсгийг ченжүүд буюу дунд шатны зуучлагчид худалдан авч дундаас нь тодорхой хэмжээний ашиг олдгоос гадна сүүлийн жилүүдэд хонины нэхий, үхрийн шир үнэгүйдэхийн зэрэгцээ, малын дайвар бүтээгдэхүүнийг хэрэглээнд ашиглах нь эрс багасаж хаягдал болсоор байна.

Иймд Говь-Алтай аймгийн Засаг дарга О.Амгаланбаатар иргэдийн санал хүсэлт, статистик тоо баримт, бодит судалгаа шинжилгээнд үндэслэн малын гаралтай бараа бүтээгдэхүүн, түүхий эдийг боловсруулах үйлдвэр, аж ахуйн нэгжийг малчдын өөрсдийнх нь хөрөнгө оруулалтаар орон нутагтаа байгуулж, нэгдсэн бодлого, зохистой удирдлагаар ханган, иргэд үйлдвэрийнхээ эзэн болох, түүхий эдээ нийлүүлэх, үр хүүхдээ ажиллуулах, хяналтаа тогтмол тавих, харилцан ашигтай хамтын бизнес эхлүүлэх чухал санаачилга гаргажээ. Өнгөрсөн оны 12 дугаар сард Есөнбулаг сумд зохион байгуулагдсан 3000 гаруй малчин өрхийн чуулга уулзалт дээр Засаг дарга энэхүү үзэл баримтлалаа танилцуулж, улмаар өөрийн санал санаачилгыг ажил хэрэг болгохын тулд Говь-Алтай аймгийн 19 сумын 88 баг тус бүрээс нэг төлөөлөл оролцуулсан ажлын хэсэг байгуулан Улаанбаатар хот, Өвөрхангай, Төв аймгийн нутаг дахь үндэсний үйлдвэрийн газруудтай танилцах аяллыг амжилттай зохион байгуулж, малчин өрх, олон мянган иргэдийн дэмжлэгийг аваад байна.

Энэхүү зөвлөх үйлчилгээний ажлын зорилго нь малчин өрхүүд хөрөнгөө нийлүүлэн малын гаралтай бараа бүтээгдэхүүн түүхий эдийг орон нутагтаа боловсруулах орчин үеийн шилдэг технологи бүхий үйлдвэр аж ахуйн газрыг байгуулахад ашиглах хуулийн этгээдийн төрөл хэлбэр, бүтэц зохион байгуулалт, удирдлага хяналтын тогтолцоо, оролцогч талуудын эрх үүргийг тодорхойлох, холбогдох дүрэм журам, гэрээний төслийг боловсруулах явдал юм.

## **1.2 Зөвлөх үйлчилгээний тайлангийн хураангуй**

Энэхүү зөвлөх үйлчилгээний тайлан 3 бүлэг, хавсралт хэсгүүдээс бүрдэнэ.

Нэгдүгээр бүлэгт зөвлөх үйлчилгээний ажлын зорилго, энэхүү төслийг эхлүүлэх болсон шалтгаан үндэслэлийг тайлбарлалаа.

Хоёрдугаар бүлэгт шинээр байгуулах хуулийн этгээдийн төрөл хэлбэрийг Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, эрх зүйн баримтын хүрээнд судлан эхний шатанд хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрээр үйл ажиллагаа эрхлэх үндэслэлийг тодорхойлж, тухайн компанийн үйл ажиллагааны чиглэл, ирээдүйн хөгжил төлөвлөлттэй уялдуулан бүтэц зохион байгуулалтын загваруудыг товчхон танилцуулав.

Гуравдугаар бүлэгт эрх зүйн баримт бичгүүд, тухайлбал "компанийн дүрэм", компанийн хувьцаа эзэмшигчтэй байгуулах "хувьцаа худалдах худалдан авах гэрээ", Компанийн тухай хууль болон компанийн дүрмээр олгогдсон эрхийн хүрээнд ажиллах "Төлөөлөөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам", удирдлагын багийг урамшуулах зорилго бүхий "опцион эрх хэрэгжүүлэх журам", олон мянган хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалахад зайлшгүй шаардлагатай "хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах журам", компанийн баримтлах "ногдол ашгийн бодлого", "гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээ"-ний төслүүдийн үндэслэл, тайлбарыг оруулав.

Дөрөвдүгээр бүлэг буюу хавсралт хэсэгт өмнөх бүлэгт танилцуулсан дүрэм журмын төслүүд болон зөвлөх үйлчилгээний компанийн мэдээллийг хавсаргасан болно.

## **Хоёр. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ТӨРӨЛ ХЭЛБЭР, БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

### **2.1 Хуулийн этгээдийн төрөл хэлбэр**

Монгол Улсын Иргэний хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 болон 33.2 дахь хэсэгт хуулийн этгээдийн төрлүүдийг тодорхойлсон бөгөөд ашгийн төлөө хуулийн этгээдийг нөхөрлөл компанийн хэлбэрээр, ашгийн төлөө бус хуулийн этгээдийг холбоо, сан, хоршооны хэлбэрээр байгуулахаар тусгажээ.

Малчин өрхүүд хамтран үйлдвэр аж ахуйн газар байгуулах гол зорилго нь малын гаралтай бараа бүтээгдэхүүн, түүхий эдийг боловсруулан ашиг олох явдал учраас шинээр байгуулагдах хуулийн этгээдийн төрөл хэлбэр нь ашгийн төлөө буюу "нөхөрлөл" эсвэл "компани"-ийн хэлбэртэй байх шаардлагатай болж байна.

Иргэний хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэгт *"хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь тодорхой тооны хувьцаанд хуваагддаг, өөрийн тусгайлсан хөрөнгөтэй, ашгийн төлөө үндсэн зорилготой хуулийн этгээдийг компани гэнэ"* гэж, 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэгт *"гишүүдийн оруулсан хувь хөрөнгөөс бүрдэх эд хөрөнгөтэй, хүлээсэн үүргээ уг эд хөрөнгө болон гишүүдийн хувийн өмчийн эд хөрөнгөөр хуульд заасны дагуу хариуцдаг хуулийн этгээдийг нөхөрлөл гэнэ"* гэж тус тус заасан бөгөөд

Дээрх тодорхойлолтоос харахад нөхөрлөлийн гишүүн нь нөхөрлөлд оруулсан эд хөрөнгөөсөө гадна хувийн өмчийн эд хөрөнгөөр нөхөрлөлийг төлөөлж бусад этгээдийн өмнө хариуцлага хүлээдэг тул олон мянган хөрөнгө оруулагчтай хуулийн этгээдийн хувьд нөхөрлөл хэлбэрээр ажиллах нь тохиромжтой шийдэл биш юм.

Харин Компанийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсэгт *"компани нь хязгаарлагдмал хариуцлагатай болон хувьцаат компани гэсэн хэлбэртэй байна"* гэж, 3.5 дахь хэсэгт *"хязгаарлагдмал хариуцлагатай компани гэж хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, түүнийг захиран зарцуулах эрх нь хууль болон компанийн дүрмээр хязгаарлагддаг компанийг хэлнэ"* гэж, 3.6 дахь хэсэгт *"хувьцаат компани нь нээлттэй болон хаалттай гэсэн төрөлтэй байна"* гэж, 3.7 дахь хэсэгт *"нээлттэй хувьцаат компани гэж хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, хувьцаа нь үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэгдэж, нийтэд чөлөөтэй арилжаалагддаг компанийг хэлнэ"* гэж, 3.8 дахь хэсэгт *"хаалттай хувьцаат компани гэж хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, хувьцаа нь үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагад бүртгэгдэж, үнэт цаасны арилжаа эрхлэх"*

байгууллагаас гадуур зах зээлд хаалттай хүрээнд арилжаалагддаг компанийг хэлнэ” гэж тус тус тодорхойлсон байна.

Дээрх хуулиудын агуулга, зохицуулалтаас харахад шинээр байгуулагдах хуулийн этгээдийг “компани”-ийн хэлбэрээр байгуулах нь оновчтой байгаа тул “компани”-ийн тухай ойлголт, түүний мөн чанар, агуулга, загвар, бүтэц зохион байгуулалтын талаар дэлгэрэнгүй авч үзье.

## 2.2 “Компани”-ийн тухай ойлголт

Хүн төрөлхтөний түүхэнд хэсэг бүлгээрээ нэгдэн хамтын хөдөлмөр эрхлэхдээ зөвхөн өөрийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээгээр ашиг хүртэхээс гадна мөн тэр хэмжээгээр хариуцлагаа хүлээх хэлбэр буюу “компани”-ийн тухай ойлголт 17 дугаар зууны эхээр бий болсон нь шинжлэх ухааны ололт амжилт, хөгжил дэвшлийг урьд өмнө байгаагүйгээр хурдасгах боломжийг эхлүүлсэн бөгөөд одоо ч энэ эрч хүчээ алдахгүй улам хурдаа авсаар байна. Dutch East India хэмээх анхны хязгаарлагдмал хариуцлагатай компани 1602 онд Голланд улсад байгуулагдан хувьцаагаа Амстердамын хөрөнгийн бирж дээр олон нийтэд санал болгосноор түүхэнд тодоор тэмдэглэгдэн үлдсэн гайхамшигт нэгэн компани төдийгүй нийгэм эдийн засгийн цоо шинэ харилцаа үүсэн бий болж, орчин үеийн өндөр хөгжлийн анхны суурийг тавьсан гэж зарим судлаачид<sup>1</sup> үздэг. Улмаар 19 дүгээр зууны Америк тивийн баруун зүүн эргийг холбосон төмөр замын хүчирхэг компаниас эхлэн өнөөдрийн үндэстэн дамнасан үйлдвэрлэл технологийн аварга корпорацууд бүгдээрээ баялгийн шударга хуваарилалтыг дэмжигч “компани” хэмээх хуулийн этгээдийн хэлбэрээр хүн төрөлхтөний хөгжлийн түүхэнд онцгой үүрэг гүйцэтгэж иржээ.

Алдарт Элон Маскийн үндэслэсэн, дэлхийд цахилгаан машин үйлдвэрлэлээр тэргүүлэгч **Тесла компанийн хувьцаа** 2023 он гарсаар зөвхөн нэг өдөрт дунджаар 170 сая гаруй ширхэг буюу 30 гаруй тэрбум америк долларын үнийн дүнгээр хөрөнгийн биржүүд дээр арилжигдаж байгаа нь Монгол Улсын 2022 оны Дотоодын нийт бүтээгдэхүүнээс даруй 2.5 дахин өндөр дүнтэй үзүүлэлт юм.

Товчхондоо зөв бодлого, оновчтой стратеги, сайн менежмент, шилдэг технологийг хослуулж чадсан “компани” нь “бүтээмжийн машин” бөгөөд хөрөнгө оруулагч, удирдлага, ажилтан, бэлтгэн нийлүүлэгч, зуучлагч, худалдан авагч бүрт ашиг орлого хүртээх, цаашлаад орон нутаг, тухайн салбар, улс орон, бүс нутаг, тив дэлхийг донсолгохуйц гайхамшигтай амжилтын хамгийн хүчирхэг суурь загвар болж чадсан байна.

<sup>1</sup> De Jongh. M., *Shareholder activism at the Dutch East India Company 1622-1625*, 2010

Өмнөх дэд бүлэгт дурдсанчлан Монгол Улсын Компанийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4-3.8 дахь заалтуудаар компанийн хэлбэрийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болон хувьцаат компани гэж ангилсан нь энгийн иргэдийн хувьд агуулгын томоохон төөрөгдөл үүсгэж болохуйц алдаатай тодорхойлолт юм. Тухайлбал дээрх ангиллыг харахад нэг талаас зөвхөн "хязгаарлагдмал хариуцлагатай компани"-ийн хувьцаа эзэмшигч хязгаарлагдмал хариуцлага хүлээж "хувьцаат компани"-ийн хувьцаа эзэмшигч өөр байдлаар хариуцлага хүлээх мэт ойлголт төрүүлэх, нөгөө талаас зөвхөн "хувьцаат компани" хувьцаатай буюу "хязгаарлагдмал хариуцлагатай компани" хувьцаа гаргахгүй гэж тайлбарлаж болохоор ойлголтын асар их зөрүүтэй буруу томъёолол гэж зөвлөх миний бие үздэг бөгөөд дээрх хоёр төрлийг олон улсын нэршлээр "нээлтэй" болон "хаалттай" компани гэж томъёолдог билээ.

Малчин өрхүүд өмч хөрөнгөө нийлүүлэн хуулийн этгээд байгуулсны дараа бизнесийн үйл ажиллагаа тогтворжих хүртэл зөвхөн Говь-Алтай аймгийн иргэд энэхүү аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулагч байх бодлогын хүрээнд, мөн нээлтэй компанийн шалгуур шаардлага, хөрөнгийн бирж, үнэт цаасны брокер, хадгаламжийн төв зэрэг мэргэжлийн байгууллагын шимтгэл хураамжийн зардлыг хэмнэх зорилгоор шинээр байгуулагдах хуулийн этгээдийг эхний шатанд Компанийн тухай хуулийн 3.5-д тодорхойлсон "хязгаарлагдмал хариуцлагатай компани"-ийн хэлбэрээр байгуулах, улмаар компани үйл ажиллагаагаа амжилттай эхлүүлэн, үйлдвэрлэл, борлуулалт, ашиг орлого тогтворжсоны (доод тал нь 3-5 жил) дараа зөвхөн компанийг үүсгэн байгуулагч Говь-Алтай аймгийн иргэд ашиг хүртээд зогсохгүй компанийн ирээдүйн өсөлтийг харж чадсан Монгол Улсын иргэн, хөрөнгө оруулагч бүрт компанийн хувьцааг бирж дээрээс худалдан авч баялгийн шударга хуваарилалтаас өгөөж хүртэх боломжийг олгох зорилгоор Компанийн тухай хуулийн 3.6-д заасан "хувьцаат компани" буюу "нээлтэй" хэлбэрт шилжих нь оновчтой зөв шийдэл гэж үзэж байна.

### **2.3 Компанийн загвар, бүтэц зохион байгуулалт**

Компанийг бүтэц зохион байгуулалт талаас нь авч үзвэл ихэнх компаниуд анх байгуулагдахдаа энгийн цомхон бүтэцтэй, удирдлага нь цөөн албан тушаалтанд төвлөрсөн чиг үүргийн хэлбэртэй байдаг бол бизнесийн үйл ажиллагаа өргөжин компани томрох тусам бүтэц зохион байгуулалт нь өөрчлөгдөн илүү боловсронгуй хэлбэрт шилждэг байна. Компани нь эрх мэдлийн хувьд төвлөрсөн буюу цөөн тооны этгээдэд удирдлага нь төвлөрсөн загвараас эрх мэдэл удирдлагад шууд төвлөрөөгүй буюу энэ нь тодорхой сувгаар бусад оролцогчдод харилцан адилгүй

тархсан загвар, түүнчлэн салбарласан, матрицан, сүлжээний, багт суурилсан зэрэг загварууд байдаг бөгөөд тэдгээр нь өөр өөрийн онцлог, давуу сул талуудтай учраас бизнесийн онцлог, цар хүрээ, үйлдвэрлэх бүтээгдэхүүний төрөл, ажиллагсдын тоо зэргээс хамааран өөрт тохирсон загварыг хэрэгжүүлэх шаардлагатай болдог.

Манай улсын хувьд чөлөөт зах зээлийн харилцаанд шилжээд харьцангуй цөөхөн жил өнгөрсөн, компани байгуулан ажиллуулсан туршлага багатай тул ихэнх компанийн бүтэц цөөн удирдлага дээр эрх мэдэл төвлөрсөн чиг үүргийн буюу функциональ бүтэцтэй байна.<sup>2</sup>

Чиг үүргийн буюу функциональ (functional) бүтэц нь зөвхөн өөрийн хариуцсан нэгжийн үйл ажиллагаанд анхаарлаа төвлөрүүлэн ажилладаг, тухайн хариуцсан ажил үүргийн хүрээнд ажлаа бүрэн мэддэг туршлагатай цомхон баг ажилладаг, цөөн хүнтэй жижиг бизнесийн байгууллагад тохиромжтой загвар боловч сул тал нь тухайн нэгжийн удирдлага болон ажилтан зөвхөн өөрийн чиг үүргийн хүрээнд асуудалд ханддаг, бусад нэгжүүдтэй харилцан ойлголцол багатайгаас компанийн үндсэн зорилго болсон ашиг буюу бүтээмжид нөлөөлөх бизнесийн дамжлага процессууд удааширч, өөрсдөө олж харж чадахааргүй олон алдаа, гажуудал хуримтлагдах шалтгаан болдог байна.

Салбарласан (divisional) бүтэц нь ихэнхдээ бүс нутгийн хэмжээнд тархсан үйл ажиллагаа эрхэлдэг, салбарласан олон жижиг байгууллагуудын нэгдэл эсвэл групп хэлбэрээр ажилладаг томоохон компаниудад тохиромжтой загвар бөгөөд давуу тал нь салбар нэгж хоорондын уялдаа холбоо сайтай, хурдан маневрлах боломжтой, аль нэг салбар нэгж бие даан эсвэл бусадтайгаа хамтран ажиллах аль хэлбэрийг сонгох боломжтой юм. Гэхдээ энэхүү загварын сул тал нь өртөг өндөр, хэт томрох үедээ өөрийн давуу байдлаа хадгалах боломжгүй болдог байна.

Түүнчлэн салбарласан загварыг дотор нь бүтээгдэхүүнд суурилсан, зах зээлд суурилсан, газарзүйн байрлалд суурилсан гэж хуваан авч үзэж болно.

Матрицан (matrix) бүтэц нь чиг үүргийн болон салбарласан бүтцийн хосолмол загвар бөгөөд бизнесийн үйл ажиллагаа өргөжиж олон салбарт үйлдвэрлэл эрхлэх, өөр бүс нутаг, гадаадын улс оронд салбараа нээх зэрэг тохиолдолд ашигладаг байна. Мөн л компани өсөж томрохын хэрээр шийдвэрлэх шаардлагатай асуудлууд нэмэгдэж, цаг хугацаанд нь зохих арга хэмжээг аваагүй тохиолдолд байгууллагын бүтээмж, ашгийн үзүүлэлтэд сөргөөр нөлөөлөх нэг гол шалтгаан болдог байна.

---

<sup>2</sup> М.Наранхүү, Процессын хүч, 2021



Дүгнэж үзвэл аливаа компани бизнесийн цар хүрээ, онцлог шинж чанараасаа хамааран өөрт тохирсон бүтэц загварыг бий болгох, шаардлагатай тохиолдолд боловсронгуй болгон сайжруулах нь зүйтэй боловч өнөөдрийн 21 дүгээр зууны өндөрлөгөөс авч үзэхэд компанийн бүтцээс илүүтэй тухайн бизнесийн шат дамжлага буюу процессын менежментийг анхнаасаа зөв зохион байгуулах, удирдах нь хамгийн чухал асуудал болоод байна.

Иймд шинээр байгуулагдах компанийг эхний шатанд уламжлалт чиг үүргийн буюу функциональ бүтэцтэй байгуулах, хөгжлийн дараагийн шатанд хэд хэдэн үйлдвэр байгуулагдан, төрөлжих явцад бүтээгдэхүүнд суурилсан салбарласан бүтцэд, бүс нутаг, олон улсын зах зээлд нэвтрэх тохиолдолд матрицан бүтцэд шилжих боломжтой. Байгууллагын хөгжлийн эхний шатанд ашиглаж болох бүтэц зохион байгуулалтын жишиг загварыг хавсралт 1-д харуулав.

Аливаа бизнесийн байгууллагын захирал удирдлагууд менежментийн орчин үеийн мэдлэгүүдийг эзэмшин үйл ажиллагаандаа нэвтрүүлэх замаар бүтэц зохион байгуулалтыг шаардлагатай үед нь өөрчлөн сайжруулах, бизнес процесс менежментийг анхнаас нь зөв хэрэгжүүлэх, ирээдүйн зохистой бүтэц, сайн менежмент бүхий компанийн суурийг бий болгох нь чухал ач холбогдолтой юм.

## Гурав. ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧГҮҮД

Иргэний хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт *“хуулийн этгээдийн эрх зүйн чадвар улсын бүртгэлд бүртгүүлснээр үүсэж ...”* гэж, Компанийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт *“компани байгуулах тухай шийдвэр гарснаас хойш 30 хоногийн дотор компанийг улсын бүртгэлд бүртгүүлэхээр холбогдох баримт бичгийг бүртгэх байгууллагад өгнө”* гэж, мөн хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт *“компанийн дүрэм нь түүнийг үүсгэн байгуулах үндсэн баримт бичиг мөн”* гэж тус тус заасан тул компани үүсгэн байгуулах төдийгүй цаашид тухайн компанийн үйл ажиллагааг эрх зүйн хүрээнд тодорхойлох үндсэн баримт бичиг нь *“компанийн дүрэм”* байх болно.

Түүнчлэн Компанийн тухай хууль, компанийн дүрмийн хүрээнд тухайн хуулийн этгээдийн төрөл хэлбэр, бүтэц зохион байгуулалт, засаглалын онцлогоос хамааран оролцогч талуудын эрх үүрэг хариуцлагыг тодорхойлсон хувьцаа худалдах худалдан авах гэрээ, хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулах процесс, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын ажиллах журам, гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээ, бодлогын баримт бичгүүд, үндсэн үйл ажиллагааны журмууд, хөдөлмөрийн дотоод журам, дотоод хяналтын журам, бусад шаардлагатай баримт бичгүүд Компанийн эрх зүйн баримт бичигт багтана.

### 3.1 Компанийн дүрэм

Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэгт *“дүрэмд заавал тусгах шаардлагатай асуудлууд”*-ыг тодорхойлсон бол 16.3 дахь хэсэгт *“компанийн дүрэмд Иргэний хууль болон бусад хууль тогтоомжтой зөрчилдөөгүй зүйлийг тусгаж болно”* гэж заасан байна.

Түүнчлэн Компанийн тухай хуулиар компани үүсгэн байгуулах, бүртгүүлэх, өөрчлөн байгуулах, компанийн удирдлага, зохион байгуулалт, хяналтын бүтэц, хувьцаа эзэмшигчийн эрх, үүргийг тогтоох, компани татан буулгахтай холбогдсон ерөнхий харилцааг зохицуулахын зэрэгцээ зарим нарийвчилсан харилцааг компани өөрийн дүрмээр зохицуулахаар буюу *“компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол ...”* Компанийн тухай хуулийг мөрдөх тухай олон зохицуулалтыг тусгасан тул *“Компанийн дүрэм”* нь тухайн хуулийн этгээдийн цаашдын үйл ажиллагаа, харилцаанд нэн чухал ач холбогдолтой онцгой баримт бичиг юм.

Иймд шинээр байгуулагдах хуулийн этгээдийн үндсэн баримт бичиг буюу дүрмийн төслийг боловсруулахдаа дараах зарчмуудыг баримтална. Үүнд:

1. Компанийн тухай хуульд *“хязгаарлагдмал хариуцлагатай компани”*-ийн дүрэмд тусгахаар заасан зохицуулалтуудыг бүрэн тусгах;

2. Санхүүгийн зохицуулах хорооны танилцуулсан “Компанийн засаглалын кодекс”-ийн үндсэн зарчмуудыг баримтлахыг эрмэлзэх;
3. Компанийн тухай хуулиар олгосон “компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол ...” (энэ нь нөгөө талаас “компанийн дүрэмд өөрөөр зааж болно” гэсэн утга агуулга юм) агуулгын хүрээнд шаардлагатай нэмэлт зохицуулалтыг бүрэн тусгах;
4. Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсэгт заасан эрхийн дагуу хуулиар хориглоогүй бөгөөд дүрэмд тусгах шаардлагатай нэмэлт зохицуулалтыг тусгах;
5. Сүүлийн жилүүдэд дэлхий даяар анхаарал хандуулж Нэгдсэн үндэсний байгууллагаас улс орон бүр хэрэгжүүлэхийг уриалсан Тогтвортой хөгжлийн зорилтууд (SDG), Байгаль орчин, нийгэм, засаглал (ESG)<sup>3</sup>-ын зарчмуудыг хэрэгжүүлэхэд анхаарах;

Зөвлөхийн зүгээс дээрх зарчмуудыг харгалзан “компанийн дүрэм”-ийн төсөл (хавсралт 2)-ийн анхны хувилбарыг боловсруулсан бөгөөд компани үүсгэн байгуулах ажлын хэсэг эсвэл үүсгэн байгуулах хурлын үеэр дүрмийн төслийг олон талаас нь нухацтай хэлэлцэх замаар шаардлагатай нэмэлт өөрчлөлтүүдийн оруулах боломжтой.

### **3.1.1 Компанийн тухай хуулийн дагуу дүрэмд заавал тусгах зохицуулалтууд**

Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1 дэх хэсэгт заасан “компанийн бүрэн болон товчилсон оноосон нэр, түүний хэлбэрийг тодорхойлсон товчилсон ялгах тэмдэглэгээ”-г дүрмийн төслийн 2.1-д; 16.2.2 дахь хэсэгт заасан “компанийн зарласан болон гаргасан хувьцааны тоо, тэдгээрийн төрөл, нэрлэсэн үнэ, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ”-г дүрмийн төслийн 7.2 болон 7.3-д; 16.2.3 дахь хэсэгт заасан “компанийн дүрмээр давуу эрхийн хувьцааг зарласан нөхцөлд давуу эрхийн хувьцааны зарласан тоо, түүний эзэмшигчийн эрх”-ийн тухай зохицуулалтыг зөвхөн “давуу эрхийн хувьцаа гаргаж болно” хэлбэрээр дүрмийн төслийн 7.4-д; 16.2.4 дэх хэсэгт заасан “хэрэв төлөөлөн удирдах зөвлөлтэй байхаар шийдвэрлэсэн бол төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоо”-ны тухай зохицуулалтыг дүрмийн төслийн 11.1-д; 16.2.5 дахь хэсэгт заасан “хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөлийн энэ хуулиар тодорхойлсноос бусад бүрэн эрх”-ийн асуудлыг дүрмийн төслийн 11.8.1-11.8.9-д; 16.2.6 дахь хэсэгт заасан “компанийн үйл ажиллагааны чиглэл”-ийг дүрмийн төслийн 3.3.1-3.3.3-д (хавсралт 3) тус тус тусгалаа.

<sup>3</sup> Environmental, Social and Governance – Байгаль орчин, Нийгэм, Засаглал

### **3.1.2 Компанийн засаглалын кодексийн зарчмуудыг хангах зохицуулалтууд**

Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 145 тоот тогтоолоор шинэчлэн баталсан “Компанийн засаглалын кодекс” баримт бичгийн үндсэн зорилго нь засаглалын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмууд, сайн туршлагыг үндэсний компаниудад нэвтрүүлэх замаар хөрөнгө оруулагч, компанийн бизнесийн үйл ажиллагаанд хамааралтай бүх оролцогч талууд (stakeholder)-ын эрх ашгийг хамгаалах, урт хугацаанд хамтдаа тогтвортой үнэ цэнийг бүтээхэд нь дэмжлэг үзүүлэх явдал бөгөөд хөрөнгийн биржид бүртгэлтэй нээлттэй хувьцаат компани, даатгагч, банк бус санхүүгийн итгэлцлийн үйлчилгээ үзүүлэгч болон хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэгч компаниуд заавал дагаж мөрдөхийг үүрэг болгон, бусад компаниудад хэрэгжүүлэхийг зөвлөсөн байна.

Алтайн малчдын түншлэл төслийн хүрээнд шинээр байгуулагдах компанид олон мянган малчин өрх хөрөнгө оруулалт хийснээр харьцангуй олон хувьцаа эзэмшигчтэй компани үүсэх, тэдний эрх ашгийг хамгаалах, ирээдүйд бирж дээр хувьцаагаа санал болгон IPO (Initial public offering - Олон нийтэд анх удаа санал болгох) хийх алсын зорилготой тул анхнаасаа олон нийтийн буюу “нээлттэй компани”-ийн хувьд зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай “Компанийн засаглалын кодекс”-ийн зарчмуудыг мөрдөхийг эрмэлзэн, засаглалын сайн туршлагыг нэвтрүүлэхээр зорьж ажиллана.

“Компанийн засаглалын кодекс” нь оршил хэсэг, үндсэн 9 зарчим, 36 зүйл, 86 тайлбараас бүрдэх томоохон баримт бичиг бөгөөд Компанийн ТУЗ, гүйцэтгэх удирдлагын зүгээс дүрмийн зохицуулалтын хүрээнд эхний шатанд зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзсэн 6 зарчимд хамаарах 12 заалтыг Компанийн дүрмийн төсөлд тусгахын зэрэгцээ дүрмийн заалт бүрийн дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгт (хавсралт 4)-ээр харьцуулан танилцуулав. Энэхүү кодексоор компанийн ТУЗ-д илүү өндөр хариуцлага хүлээлгэсэн тул ТУЗ-ийн үйл ажиллагаатай холбоотой Компанийн хууль болон Компанийн дүрэмд тусгагдаагүй нарийвчилсан зохицуулалтыг Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журамд тусгах нь зүйтэй юм.

### **3.1.3 Компанийн дүрэмд өөрөөр зааж болох зохицуулалтууд**

Компанийн тухай хууль нь 14 бүлэг, 100 зүйлээс бүрдсэн томоохон хууль бөгөөд энэ хууль дотор “компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол ...” буюу компани өөрийн дүрэмд өөрчлөн зохицуулж болох 31 заалт багтсан байна. Энэхүү 31 заалтаас Компанийн тухай хуулиар зохицуулахаар буюу дүрэмд өөрөөр заах шаардлагагүй гэж үзсэн 21 заалт, Компанийн тухай хуулийн зохицуулалтаас өөр байдлаар буюу дүрэмд нэмэлтээр тусгах байдлаар шийдвэрлэсэн 9 заалт, хязгаарлагдмал хариуцлагатай компанид хамааралгүй 1 заалт (хавсралт 5) байна.

### **3.1.4 Хуулиар хориглоогүй нэмэлт зохицуулалтууд**

Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсэгт “Компанийн дүрэмд Иргэний хууль болон бусад хууль тогтоомжтой зөрчилдөөгүй зүйлийг тусгаж болно” гэж заасан тул энэхүү эрхийн хүрээнд Компанийн онцлог хамаарах зайлшгүй шаардлагатай зарим зохицуулалтыг Компанийн дүрмийн төсөлд тусгалаа. Аливаа бизнесийг амжилттай зохион байгуулахад технологи, санхүү болон хүний нөөцийг чухалчлан авч үздэг бөгөөд орчин үед эдгээр үндсэн нөөцүүдээс хүнийн нөөцийг сайн бүрдүүлж чадсан тохиолдолд энэхүү мэдлэг туршлагатай баг нь бусад нөөцүүдээ амжилттай бүрдүүлэх боломжтой гэж үзэх болсон.

Иймд шинээр байгуулагдах Компанийн хүний нөөц, ялангуяа өндөр ур чадвартай гүйцэтгэх удирдлага буюу менежментийн баг бүрдүүлэхийн тулд тухайн багийн үйл ажиллагааг дүгнэх, урамшуулах оновчтой тогтолцоо чухал гэж үзээд менежментийн багийг урамшуулах зорилго бүхий опцион гэрээний зохицуулалтыг дүрмийн төслийн 5.5, 5.6-д тусгалаа.

Компанийн хувьцаа эзэмшигч, ялангуяа жижиг хувьцаа эзэмшигчийн эрхийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд бүрэн хамгаалсан байх, мэдээлэл авах боломжийг хангах зорилгоор Компанийн дүрэмд “хувьцаа эзэмшигчийн тархалт, байршлыг харгалзан Говь-Алтай аймгийн баг тус бүрт Компанийн төлөөлөгчийг ажиллуулах, төлөөлөгчийн үүргийг Компанийн хувьцаа эзэмшигч, тухайн багийн аль нэг иргэн хариуцан гүйцэтгэх” тухай заалт (дүрмийн төслийн 3.7) оруулав.

Компанийн тухай хуульд тодорхой заагаагүй боловч ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэх шаардлагатай асуудлууд практикт цөөнгүй тохиолддог тул ТУЗ-ийн эрх мэдэл дотор зарим заалтуудыг нэмж тусгалаа (хавсралт 6).

### **3.1.5 Байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-тай холбоотой зохицуулалтууд**

Шинжлэх ухааны нээлтүүд, техник технологийн үсрэнгүй хөгжил нь хөдөлмөрийг хөнгөвчлөх, хэрэглээг нэмэгдүүлэх, бүтээмжийг дээшлүүлэх олон давуу талыг бий болгож байгаа боловч хүрээлэн буй байгаль орчныг устгах, нийгмийн ухамсар доройтох, засаглалын тогтворгүй байдал үүсгэх зэрэг олон сөрөг үр дагаврыг үүсгэсээр байгаа тул Нэгдсэн үндэсний байгууллагаас 17 заалт бүхий “Тогтвортой хөгжлийн зорилтууд”-ыг 2015 онд тунхаглан зарлаж, даган хэрэгжүүлэхийг дэлхийн улс орнуудад уриалсан билээ.

Дэлхийн соёлт нийгмийн нэгээхэн хэсэг болох Монгол Улсын хувьд энэхүү тунхаглал, зорилтуудыг “Алсын хараа-2050” үндэсний баримт бичигтээ тусган шат дараатай хэрэгжүүлэхээр зорин ажиллаж байгаагийн нэг нь Байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ буюу ESG)-ын зарчмуудыг төрийн болон хувийн хэвшил, бизнесийн байгууллага үйл ажиллагаандаа даган мөрдөх шаардлагыг бий болгож байна.

Бидний бүтээн байгуулахаар төлөвлөж буй үйлдвэрүүдийн үйл ажиллагаа энэхүү зарчмын зорилтуудтай зайлшгүй холбогдох бөгөөд энэхүү компаниа алсын хараа, эрхэм зорилго, стратегийн бодлого төлөвлөлтөд үндэслэн амжилттай ажиллуулснаар урт хугацаанд компанийн ирээдүйн бизнест эерэг үр дүн үзүүлэх юм. Тухайлбал хүлэмжийн хийнээс шалтгаалсан дэлхийн дулаарал нь цөлжилтийг ихэсгэж бэлчээрийн доройтлыг нэмэгдүүлсээр байгаагийн улмаас усны нөөц, өвс тэжээлийн хомсдол үүсэх, зөвхөн ноолуур авахын төлөө ямаан сүргийн тоог хэт өсгөснөөр үржил шимтэй хөрс устаж үгүй болох, экологийн тэнцвэрт байдлыг алдагдуулах зэргээр байгаль орчин, цаашлаад нийгэм эдийн засгийн сөрөг үр дагавар, болзошгүй хямралд түлхсээр байгаа билээ.

Иймд дүрмийн төслийн 5.4 дэх заалтад “Компани нь төрийн эрх бүхий байгууллагын баталсан “Компанийн засаглалын кодекс”, “Тогтвортой хөгжлийн зарчмууд” баримт бичгийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэхийн төлөө хүчин чармайлт гаргана.” гэж тусгалаа.

### **3.2 Хувьцаа худалдах худалдан авах гэрээ**

Компанийн тухай хууль, Компанийн дүрмээр хувьцаа эзэмшигчийн үндсэн эрх үүргийг тодорхойлсон боловч зарим нарийвчилсан харилцааг зохицуулах зорилгоор “Хувьцаа худалдах худалдан авах гэрээ” байгуулах шаардлагатай.

Энэхүү гэрээний зорилго нь Компанийн гаргасан хувьцаанаас өөрийн худалдан авч буй тодорхой тоо хэмжээний хувьцааны төлбөрийг Компанид төлөх, Компани төлбөрийн баримт болон гэрээг үндэслэн худалдан авагч этгээдийг Компанийн хувьцаа эзэмшигчийн бүртгэл буюу Компанийн дүрэмд тусгах, дүрмийг Улсын бүртгэлийн байгууллагад албан ёсоор бүртгүүлэх, Компанийн тухай хууль болон Компанийн дүрмээр зохицуулагдаагүй Компани болон хувьцаа эзэмшигчийн хооронд үүсэх зарим нарийвчилсан харилцааг зохицуулах явдал юм. Тухайлбал энэхүү гэрээгээр хувьцааны төлбөр хийх хугацаа, арга хэлбэр, талуудын нийтлэг болон тал тус бүрийн хүлээх нэмэлт үүрэг, худалдан авагчийн татгалзал буюу гэрээний үүргээ хэрэгжүүлэх зорилгоор хуулиар олгогдсон зарих эрхээсээ татгалзах тухай бичгээр гаргаж буй амлалт, талуудын мэдэгдэл баталгаа, гэрээ биелэгдэх урьдчилсан нөхцөл, хариуцлага, үйлчлэх хугацааг тодорхойлно (хавсралт 7).

Компанийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “хязгаарлагдмал хариуцлагатай компанийг байгуулах үеийн хувьцаа эзэмшигчдийн тоо 50-иас дээшгүй байна” гэж заасан тул эхлээд 50 хүртэл хувьцаа эзэмшигчтэйгээр компаниа байгуулж улсын бүртгэлд бүртгүүлнэ.

Дараагийн шатанд олон мянган хувьцаа эзэмшигч компанид хөрөнгө оруулах учраас Компанийн шинээр гаргаж буй хувьцаанаас өөрийн эзэмшиж буй хувьцааны хувь хэмжээгээр хувь тэнцүүлэн худалдан авах эрх нь нээлттэй байна. Энэ нь

компанийн 1 хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч нэмж гаргаж буй хувьцааны 1 хувийг худалдан авах давуу эрхтэй гэсэн үг юм.

Гэвч зарим тохиолдолд тухайлбал стратегийн хөрөнгө оруулагч орж ирэх эсвэл гүйцэтгэх удирдлага буюу менежментийн багийн ажлын үр дүнг урамшуулах зорилгоор тэдэнд олгож буй опцион эрх (хувьцааг тодорхой үнээр худалдан авах эрх буюу ирээдүйд хувьцаанд хөрвөх эрхийн гэрчлэх үнэт цаас)-ийг худалдан авах эрхээсээ татгалзах шаардлага үүсэх тул энэхүү харилцааг зохицуулах зорилгоор хувьцаа худалдах хуалдан авах гэрээнд холбогдогдох заалтуудыг Гэрээний төслийн 7.1, 7.1.1, 7.1.3 дэх заалтууд, Гэрээний хавсралт 2, хавсралт 4-д тусгасан болно.

Мөн компанийн үйл ажиллагааг жигдрэх хүртэл буюу доод тал нь 3 жилийн хугацаанд хувьцаагаа зарахгүй, хөрөнгө оруулалтаа татан авахгүй байх нь Компанийн үйл ажиллагааг тогтвортой, тасралтгүй үргэлжлэхэд чухал нөлөө үзүүлэх учраас 2023 онд компанийн хувьцаа худалдан авсан бүх хөрөнгө оруулагч гэрээ байгуулснаас хойш 3 жилийн хугацаанд хувьцаагаа зарахгүй түгжих (lock-up) нөхцлийг гэрээний төслийн 7.1, 7.1.2 дахь заалтууд болон Гэрээний хавсралт 3-д оруулав.

Гэрээний төслийн 8 дугаар бүлэгт гэрээ биелэгдэх урьдчилсан нөхцлүүдийг тодорхойлов. Тухайлбал гэрээ байгуулахаас өмнө Компани ямар урьдчилсан нөхцлийг хангасан байх, ямар баримт бичгүүдийг бэлтгэх, худалдан авагч тал Гэрээ байгуулахын тулд ямар бичиг баримтуудтай ирэх, ямар баримтуудтай танилцсан байх зэргийг энэ бүлгээр нарийвчлан зохицуулсан болно.

Гэрээний 9 дүгээр бүлэгт мэдэгдэл баталгаа буюу энэхүү гэрээг байгуулах эрх зүйн үндэслэлүүдийг Компанийн зүгээс нотолж буйг тусгав. Тухайлбал гэрээ байгуулах үед Компани нь Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан, аливаа шүүхийн маргаангүй, хэн нэгний өмнө хүлээсэн аливаа үүрэг хариуцлагаас зайлсхийгээгүй, хууль тогтоомж, дүрэм журам зөрчөөгүйг баталсан мэдэгдлийг Компани баталгаажуулж байгаа юм.

Гэрээний төслийн 10, 11 дүгээр бүлэгт нэмэлт тохиролцоо буюу гэрээнд гарын үсэг зурснаас хойш гэрээ хүчин төгөлдөр болох хүртэл буюу Улсын бүртгэлд бүртгүүлэх хүртэл хугацаанд талуудад хориглох үйл ажиллагаа, гэрээний төлбөрийг хоцроосон тохиолдолд хүлээх хариуцлага буюу алдангийн талаар нарийвчилсан харилцааг тусгав.

Гэрээний төслийн 12 дугаар бүлэгт гэрээг цуцлах болон дуусгавар болгох нарийвчилсан харилцааг танилцуулсан болно.

### 3.3 Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам

Компанийн тухай хуулийн 9 дүгээр бүлгийн 75-82 дугаар зүйлээр Төлөөлөн удирдах зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, эрх үүрэг, үйл ажиллагааны хэлбэр, ажиллах журмыг тодорхойлсон бөгөөд дээрх хууль болон Компанийн дүрмийн холбогдох зохицуулалтын хүрээнд Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны нарийвчилсан харилцааг энэ журам (хавсралт 8)-аар зохицуулах юм.

Олон мянган хөрөнгө оруулагчтай компанийн хувьд хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулахад цаг хугацаа, зардал мөнгө ихээхэн шаардагдах учраас хувьцаа эзэмшигчдийн хурлын хооронд ТУЗ нь Компанийн тухай хууль болон Компанийн дүрмээр олгогдсон эрхийн хүрээнд онцгой үүрэг гүйцэтгэнэ.

Компанийн засаглалын кодексийн дагуу ТУЗ-ийн дэргэд хороод байгуулагдах бөгөөд хороодын үйл ажиллаганы журмыг тус тусад нь батлахгүйгээр энэхүү ТУЗ-ийн үйл ажиллагааны журам дотор багтаан боловсруулав.

### 3.4 Опцион эрх хэрэгжүүлэх журам

Компанийг үүсгэн байгуулж, бүтээн босгох, Компанийн эрхэм зорилго, алсын хараа, дунд хугацааны стратегийн зорилго, зорилтуудыг амжилттай хэрэгжүүлэхэд гол үүрэг гүйцэтгэх менежментийн баг буюу гүйцэтгэх удирдлагаар мэдлэг боловсрол, авьяас чадвар, дадлага туршлага, сэтгэл зүтгэлтэй мэргэжилтнүүдийг олж томилох нь Компанийн ирээдүйн ололт амжилт, алдаа оноонд онцгой чухал нөлөө үзүүлэх учраас олон улсад түгээмэл ашиглагддаг опцион эрх буюу Компанийг амжилттай удирдан ашиг орлого, хөрөнгийг нэмэгдүүлж, хувьцааны үнэ цэнийг өсгөсөн тохиолдолд тодорхой хэмжээний хувьцааг анхны үнээр нь худалдан авах эрхийг олгодог урамшууллын аргыг танилцуулж байна.

Энэ нь шинээр байгуулах компанийн энгийн хувьцааны нэг бүрийн үнэ 1000 төгрөг гэж үзээд 3 жилийн дотор амжилттай ажиллаж нэгж хувьцаанд ноогдох хөрөнгө 2500 төгрөг буюу компанийн хөрөнгө 2 дахин өссөн тохиолдолд менежментийн багт тодорхой хэмжээний хувьцааг анхны хэрлэсэн үнээр нь буюу 1000 төгрөгөөр худалдан авах эрх олгоно.

Компанийн дүрмийн төслийн 5.6-д *"Компани нь энгийн хувьцааг заавал гаргах үүрэг хүлээхээс гадна давуу эрхийн хувьцаа, опцион болон хуульд заасан бусад үнэт цаасыг гаргаж болно"* гэж, 5.7-д *"Компани нь гүйцэтгэх удирдлагын буюу менежментийн багийн ажлын үр дүнг урамшуулах, компанийн бүтээмжийг сайжруулах зорилгоор тодорхой нөхцөл бүхий опцион гаргаж болно."* гэж тус тус заасан тул Хувьцаа эзэмшигчдийн хурлаар опцион гаргах асуудлыг хэлэлцэн ТУЗ-д эрхийг нь өгөх бөгөөд ТУЗ менежментийн багт олгох опцион гэрээний нөхцлийг хэлэлцэн шийдвэр гаргах юм. "Опцион эрхийг хэрэгжүүлэх журам"-ын төслийг хавсралт 9-д оруулав.



### **3.5 Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах журам**

Компанийн тухай хууль болон Компанийн дүрэмд заасны дагуу Компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал бөгөөд энэхүү хурлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах, ялангуяа сум бүрт тархан байрласан олон мянган хувьцаа эзэмшигч хурлын зарыг хугацаанд нь хүлээн авах, хуралдаа оролцох боломжийг бүрдүүлэх нь чухал ач холбогдолтой юм.

Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу хувьцаат компанийн хэлбэртэй хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулахтай холбоотой төрийн зохицуулах байгууллагын дүрэм журмыг батлан хэрэгжүүлдэг бөгөөд шинээр байгуулагдах компанийн хувьд хувьцаа эзэмшигчийн тоо олон, ирээдүйд хувьцаат компанийн хэлбэрт шилжих зорилготой тул үүсгэн байгуулах үеэсээ хувьцаа эзэмшигчдийн хурлыг зөв зохион байгуулах шаардлагатай гэж үзэж байна.

Иймд “Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулах журам”-ын төсөл (хавсралт 10)-ийг боловсруулсан бөгөөд Компанийн дүрэмд тусгасан “төлөөлөгч”-өөр дамжуулан хурлын зарыг хурдан шуурхай хүргэх, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор цахим хэлбэрээр хурал зохион байгуулах боломжийг журамд тусгах, саналын хуудсаар саналаа өгч болох зэрэг зохицуулалтуудыг тусгалаа.

### **3.6 Ногдол ашгийн бодлого**

Компанийн тухай хуулийн 6 дугаар бүлгийн 46-47 дугаар зүйлд ногдол ашиг хуваарилахтай холбоотой зохицуулалтыг тусгасан байна. Хуулийн 46 дугаар зүйлийн 46.1-д заасны дагуу ногдол ашиг хуваарилах шийдвэрийг ТУЗ гаргах бөгөөд уг шийдвэрт хувьцаа бүрд ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдөр болоз ногдол ашиг төлөх өдөр зэргийг заана. Хуулийн 46 дугаар зүйлийн 46.3-д заасны дагуу хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьд ногдол ашиг хуваарилах шийдвэр гаргасан өдөр компанийн хувьцааг эзэмшигч буй хувьцаа эзэмшигч ногдол ашиг авах эрхтэй. Хуулийн 46 дугаар зүйлийн 46.8д заасны дагуу ногдол ашгийг компанийн татвар төлсний дараах цэвэр ашгаас хуваарилна. Түүнчлэн Компанийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1-д заасны дагуу ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх, ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, түүний татан буулгалтын үнэ зэргийн нийлбэрээс их байх, компани эргүүлэн худалдаж авах үүрэгтэй үнэт цаасаа бүрэн авсан байх ёстой.

Иймд ногдол ашгийн бодлогыг боловсруулахдаа Компанийн тухай хуулийн дээрх заалтуудад нийцүүлэх бөгөөд Компани ногдол ашиг хуваарилахдаа баримтлах үндсэн зарчим бодлогыг тодорхойлох юм. Аливаа компани тухайн жилийн үйл ажиллагааны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах учраас хязгаарлагдмал

хариуцлагатай компанийн хувьд энэхүү ашгийн талаар баримтлах бодлого хөрөнгө оруулагчдад чухал ач холбогдолтой.

Ногдол ашиг хуваарилахдаа тогтмол үнээр хуваарилах, ашгийн тогтмол хувиар хуваарилах, тогтмол өсөлттэй хувиар хуваарилах гэх мэт олон загварууд байдаг.

Тогтмол үнээр хуваарилах загвар нь жил бүр хуваарилах ногдол ашгийг тогтмол мөнгөн дүнгээр заах бөгөөд үйл ажиллагааны ашиг жил бүр харилцан адилгүй байх, инфляцаас хамааран тогтмол дүнтэй ашгийн бодит өгөөж буурах зэрэг сул талуудтай.

Тухай жилийн ашгийн тогтмол хувиар тооцон ногдол ашиг хуваарилах бодлого нь компанид ашигтай боловч цэвэр ашгийн хэмжээ буурсан тохиолдолд хувьцаа эзэмшигчид бага хэмжээний ногдол ашиг ногдох сөрөг талыг бий болгоно.

Тогтвортой өсөлттэй компаниудын хувьд жил бүрийн ногдол ашгийн хувь хэмжээг өмнөх оноос тодорхой хувиар өсгөн хуваарилах бодлогыг баримтлах боломжтой бөгөөд компанийн цэвэр ашгийн хэмжээ буурсан тохиолдолд энэ арга нь компанийн цаашдын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх сул талтай юм.

Иймд ногдол ашиг хуваарилахдаа Компанийн тухай хуулийн холбогдох зохицуулалтыг хангасан тохиолдолд жил бүр ашгийн тодорхой хувиар тооцон ногдол ашиг хуваарилах бодлого баримтлах нь зүйтэй гэж үзэн ногдол ашгийн бодлогыг тодорхойллоо (хавсралт 11).

### **3.7 Гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээ**

Иргэний хуулийн 32 дугаар бүлэг, Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8, 76.1.9, Компанийн дүрмийн 11 дүгээр бүлгийн 11.8.4, 14 дүгээр бүлгийн 14.2, 14.3 дэх заалтуудыг үндэслэн Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс Гүйцэтгэх захиралтай байгуулах "Контракт"-ын төслийг боловсрууллаа.

Иргэний хуулийн 32 дугаар бүлгийн 359 дүгээр зүйлд тодорхойлсон "хөлсөөр ажиллах гэрээ"-ний хувилбарыг Монгол Улсын томоохон аж ахуйн нэгжүүд "контракт" нэрээр ашиглаж байна. Хөдөлмөрийн гэрээг байгуулахдаа хөдөлмөрийн эрх зүйн харилцааг үндэслэх бол хөлсөөр ажиллах гэрээг байгуулахдаа иргэний эрх зүйн харилцааг сууль болгон хэрэглэдэгт энэхүү хоёр гэрээний гол ялгаа оршино.

Энэхүү гэрээний төслийг боловсруулахдаа Компани болон Гүйцэтгэх захирлын хооронд үүсдэг "agency problem" буюу гүйцэтгэх захирлын зүгээс компанийн стратегийн зорилго зорилтыг хэрэгжүүлэхээс илүүтэй тухайн үеийн үр дүн, үр ашгийг илүү өндөр байлгах замаар өндөр урамшуулал авах сонирхлыг хязгаарлах, тухайлбал урамшууллыг хувьцааны үнэтэй уялдуулсан опцион эрх олгох заалтыг тусгах, гүйцэтгэх захирлын зүгээс заавал ТУЗ-ийн нэмэлт зөвшөөрөлтэйгөөр хэрэгжүүлэх үйл ажиллагааг нарийвчлан тусгах, хууль тогтоомж, дүрэм журамд

тусгагдаагүй боловч практикт тохиолддог асуудлуудын эрх үүргийг илүү тодорхой болгох чиглэлийг баримталсан болно (хавсралт 12).

**Дөрөв. ХАВСРАЛТУУД**

**Хавсралт 1. Компанийн бүтэц зохион байгуулалтын функциональ загвар**



## Хавсралт 2. Компанийн дүрмийн төсөл

[.....] хязгаарлагдмал

хариуцлагатай компанийн дүрэм

### Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү дүрмээр [.....] хязгаарлагдмал хариуцлагатай компани (цаашид "Компани" гэх)-ийн зорилго, оноосон нэр, үйл ажиллагааны чиглэл, Компанийн эрх зүйн байдал, Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид "ТУЗ" гэх), Гүйцэтгэх удирдлагын эрх үүргийг тодорхойлох, Компанийн зарласан болон гаргасан хувьцааны тоо, хувь нийлүүлсэн хөрөнгийг хэмжээг тогтоох, Компанийн санхүүгийн жил, нягтлан бодох бүртгэл, хяналт, Компанийг өөрчлөн байгуулах, татан буулгахтай холбогдсон харилцааг зохицуулна.
- 1.2. Компани нь Монгол Улсын Иргэний хууль, Компанийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа удирдлага болгон энэ дүрмийн хүрээнд ашгийн төлөө үйл ажиллагаа явуулна.

### Хоёр. КОМПАНИЙН ОНООСОН НЭР, ХАЯГ

- 2.1. Компанийн оноосон нэрийг кирилл үсгээр [.....] ХХК, латин үсгээр [.....] LLC гэх бөгөөд оноосон нэрийг үгийн утгын хувьд цаашид дэлгэрүүлж тайлбарлахгүй, орчуулахгүй, салгаж бичихгүй болно.
- 2.2. Компанийн албан ёсны хаяг, шуудангийн хаяг: [.....]
- 2.3. Утас: [.....]
- 2.4. Цахим шуудан: [.....]

### Гурав. КОМПАНИЙН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

- 3.1. Компанийн зорилго нь малын гаралтай бараа бүтээгдэхүүн, түүхий эдийг боловсруулах чиглэлийн байгальд ээлтэй, орчин үеийн дэвшилтэт технологи бүхий үйлдвэр байгуулах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, гадаад дотоодын зах зээлд худалдах, бизнесээ өргөтгөн ашиг олох замаар

хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийн үр өгөөжийг байнга өсгөн нэмэгдүүлэхэд оршино.

- 3.2. Компани нь бие даасан тайлан тэнцэлтэй, харилцах данстай, өөрийн нэрийн өмнөөс эрх эдлэн, үүрэг хариуцлага хүлээх ба хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, түүнийг захиран зарцуулах эрх нь Иргэний хууль болон Компанийн тухай хууль, энэхүү дүрмээр хязгаарлагдах хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрээр ажиллана.
- 3.3. Компани нь дараах чиглэлээр үйл ажиллагаа эрхэлнэ. Үүнд:
  - 3.3.1. Малын гаралтай бараа бүтээгдэхүүн, түүхий эдийг боловсруулах;
  - 3.3.2. Нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх;
  - 3.3.3. Гадаад дотоод худалдаа эрхлэх;
- 3.4. Компани нь тусгай зөвшөөрөл шаардагдах бусад үйл ажиллагааг хуульд заасны дагуу холбогдох эрх бүхий байгууллагын зөвшөөрлийн үндсэн дээр явуулж болох ба энэ тохиолдолд дүрэмдээ өөрчлөлт оруулан бүртгэх байгууллагад бүртгүүлнэ.
- 3.5. Компани нь үйл ажиллагаагаа хугацаагүй явуулна.
- 3.6. Компани нь Монгол Улсад болон гадаад улсад өөрийн салбар, төлөөлөгчийн газартай байж болно. Компанийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу салбар, төлөөлөгчийн газраа байгуулан, бүртгэх байгууллагад бүртгүүлж, үйл ажиллагаагаа явуулна.
- 3.7. Компанийн хувьцаа эзэмшигчдийн тархалт, байршлыг харгалзан Говь-Алтай аймгийн баг тус бүрт Компанийн төлөөлөгчийг ажиллуулна. Төлөөлөгчийн үүргийг Компанийн хувьцаа эзэмшигч, тухайн багийн аль нэг иргэн хариуцан гүйцэтгэнэ.

#### **Дөрөв. Компанийн эрх**

- 4.1. Компанийн эрх зүйн чадамж нь Компанийг улсын бүртгэлд бүртгүүлснээр үүсэх ба дүрэмд заасан үйл ажиллагаагаа Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд, хараат бусаар бие даан явуулна.
- 4.2. Компани нь өөрийн үйл ажиллагааны хүрээнд аливаа гадаад, дотоодын байгууллага, хувь хүмүүстэй хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажиллах эрхтэй.

- 4.3. Компани нь өөрийн нэр бүхий тамга, бэлгэдэл (эмблем), албан бичгийн хэвлэмэл хуудас (бланк)-тай байх бөгөөд Компанийн тамгыг гүйцэтгэх захирал зохих журмын дагуу эзэмшиж, хадгална.
- 4.4. Компани нь Компанийн тухай хуулийн 6.1-6.8 дахь хэсэгт заасны дагуу хараат болон охин компани байгуулж болно.
- 4.5. Компани нь үндсэн ба туслах үйл ажиллагаагаа хэвийн явуулах зорилгоор мэргэжил, ур чадвар, дадлага туршлагатай хүмүүсийг хөлсөөр болон хөдөлмөрийн гэрээгээр авч ажиллуулах эрхтэй ба тэдгээрийн ажиллах нөхцөл, цалин хөлс, урамшууллын хэмжээг зохих журмын дагуу тогтооно.

#### **Тав. Компанийн үүрэг**

- 5.1. Компани нь үйл ажиллагаагаа Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн явуулах үүрэгтэй.
- 5.2. Компани нь төрийн эрх бүхий байгууллагын баталсан "Компанийн засаглалын кодекс", "Тогтвортой хөгжлийн зарчмууд" баримт бичгүүдийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэхийн төлөө хүчин чармайлт гаргана.
- 5.3. Компани нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Аудитын тухай хууль болон Компанийн тухай хуулийн 96 дугаар зүйлд заасны дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөн, санхүүгийн тайлан гаргана.
- 5.4. Компани нь Монгол Улсын татварын хууль тогтоомжийн дагуу орлого, зарлагаа өөрөө тодорхойлж, албан татвараа сайн дураар төлнө.
- 5.5. Компани нь хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсадын өмнө хүлээсэн үүргээ биелүүлж холбогдох журмын дагуу нийгмийн даатгалд хамруулна.
- 5.6. Компани нь энгийн хувьцааг заавал гаргах үүрэг хүлээхээс гадна давуу эрхийн хувьцаа, опцион болон хуульд заасан бусад үнэт цаасыг гаргаж болно.
- 5.7. Компани нь гүйцэтгэх удирдлагын буюу менежментийн багийн ажлын үр дүнг урамшуулах, компанийн бүтээмжийг сайжруулах зорилгоор тодорхой нөхцөл бүхий опцион гаргаж болно.
- 5.8. Компани нь Компанийн тухай хуулийн 97 дугаар зүйлд заасан баримт бичгүүдийг хадгалах үүрэгтэй ба Компанитай холбоотой баримт бичгийн нууцыг хадгалах үүрэгтэй.

- 5.9. Компани нь үүсгэн байгуулах баримт бичигт болон Улсын бүртгэлийн жагсаалтад агуулагдаж байгаа бусад мэдээлэлд оруулсан өөрчлөлтүүдээ хуульд заасан хугацаанд бүртгэх байгууллагад бүртгүүлнэ.

#### **Зургаа. КОМПАНИЙН ХАРИУЦЛАГА, ХОРИГЛОХ ЗҮЙЛ**

- 6.1. Компани нь өөрийн хувь нийлүүлсэн хөрөнгөд бүртгэгдсэн хөрөнгийн хэмжээгээр хариуцлага хүлээнэ.
- 6.2. Компани нь хувьцаа эзэмшигчийн гуравдагч этгээдийн өмнө хүлээх аливаа үүрэг хариуцлагаас ангид байна.
- 6.3. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь Компанийн тухай хуулийн 84, 85 дугаар зүйлд заасан хариуцлагыг хүлээнэ.
- 6.4. Компани, хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан болон Компанийн ажиллагсад дараах зүйлийг хориглоно. Үүнд:
- 6.4.1. Хуулиар хориглосон арга хэрэгслийг ашиглаж, шударга бусаар давуу байдал бий болгоход чиглэсэн үйл ажиллагаа явуулах,
  - 6.4.2. Компанийн үйл ажиллагааны талаар буруу ташаа, худал мэдээллийг олон нийтэд тараах,
  - 6.4.3. Хууль болон Компанийн холбогдох журмуудаар нууцалсан Компанийн нууц мэдээллийг задруулах.

#### **Долоо. КОМПАНИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ, ӨӨРИЙН ХӨРӨНГӨ**

- 7.1. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг Компанийн тухай хуулийн 30.1, өөрийн хөрөнгийн хэмжээг Компанийн тухай хуулийн 30.2-т заасны дагуу тодорхойлно.
- 7.2. Компанийн зарласан хувьцаа нь нэг бүр нь 1000 (нэг мянган) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 300,000,000 (гурван зуун сая) ширхэг энгийн хувьцаа байна.
- 7.3. Компани нь нийт зарласан энгийн хувьцаанаас [.....] ([.....]) ширхэг энгийн хувьцааг гаргасан бөгөөд Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь [.....] ([.....]) төгрөгтэй тэнцүү байна.
- 7.4. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөхдөө Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасныг баримтална.



### **Найм. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ**

- 8.1. Компанийн гаргасан хувьцаанаас худалдан авч, Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгөд хөрөнгө оруулсан хувь хүн, хуулийн этгээдийг Компанийн хувьцаа эзэмшигч гэнэ.
- 8.2. Компанийн гаргасан нэг бүр нь 1000 (нэг мянган) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий [.....] ([.....]) ширхэг энгийн хувьцааг энэхүү дүрмийн хавсралтад заасан нэр бүхий хувьцаа эзэмшигчид эзэмшинэ.
- 8.3. Компани нь хуульд заасан журмын дагуу нэмж хувьцаа гаргах замаар хувьцаа эзэмшигчдийн тоог нэмэгдүүлэх эрхтэй ба гадаад дотоодын хувь хүн болон хуулийн этгээд Компанийн хувьцаа эзэмшигч байж болно.
- 8.4. Компани хувьцаа эзэмшигчтэй "Хувьцаа худалдах худалдан авах гэрээ" байгуулна.
- 8.5. Хувьцаа эзэмшигч нь Компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү эзэмшиж байгаа хувьцааны хэмжээгээр хариуцлага хүлээнэ.
- 8.6. Хувьцаа бүр саналын нэг эрхтэй байна.
- 8.7. Хувьцаа эзэмшигч нь дараах эрхийг эдэлж, үүрэг хүлээнэ. Үүнд:
  - 8.7.1. Заасан хугацааны дотор Компанид бэлэн мөнгөөр болон "Хувьцаа худалдах худалдан авах гэрээ"-нд заасан эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн хэлбэрээр хөрөнгө оруулалт хийх,
  - 8.7.2. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож санал өгөх,
  - 8.7.3. Хуульд заасан журмын дагуу ногдол ашиг хүртэх,
  - 8.7.4. Холбогдох журмын дагуу Компанийн баримт бичигтэй танилцах,
  - 8.7.5. Компанийн тухай хуульд заасан бусад эрх, үүрэг.

### **Ес. ХУВЬЦАА НЭМЖ ГАРГАХ, ШИЛЖҮҮЛЭХ**

- 9.1. Хувьцаа нэмж зарлах асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурал, зарласан хувьцааны тоонд багтааж хувьцаа нэмж гаргах асуудлыг ТУЗ тус тус шийдвэрлэнэ.
- 9.2. Компанийн энгийн хувьцаа эзэмшигч нь Компаниас нэмж гаргаж байгаа хувьцаа болон Компанийн хувьцааг худалдан авах эрхийн опционыг өөрийн

энгийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн тэргүүн ээлжинд худалдан авах эрхтэй ба уг эрх нь дараах тохиолдлуудад үл хэрэгжинэ. Үүнд:

9.2.1. Тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ хувьцаа эзэмшигч хэрэгжүүлэхээс татгалзсан тохиолдолд;

9.2.2. Стратегийн хөрөнгө оруулалт татахаар ТУЗ-өөс шийдвэрлэсний үндсэн дээр нэмж хувьцаа гаргаж байгаа тохиолдолд;

9.2.3. Гүйцэтгэх удирдлага буюу менежментийн багт олгох зорилгоор опцион гаргах тохиолдолд;

9.3. Хувьцаа эзэмшигчийн оруулах хөрөнгө оруулалтыг Дүрмийн 9.2.2-т заасан стратегийн хөрөнгө оруулалтад тооцох эсэхийг тухайн үеийн Компанийн санхүүгийн нөхцөл байдал, хөрөнгө оруулалтын хэмжээ, хэрэгцээ шаардлагыг харгалзан ТУЗ шийдвэрлэнэ.

9.4. Компанийн хувьцаа эзэмшигч нь нэмж гаргаж буй хувьцаанаас тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ "Хувьцаа худалдах худалдан авах гэрээ"-нд заасан нөхцөлийн дагуу хэсэгчлэн эсхүл бүхэлд нь гуравдагч этгээдэд худалдах буюу шилжүүлж болно.

9.5. "Хувьцаа худалдах худалдан авах гэрээ"-нд заасан тохиолдолд Компанийн хувьцаа эзэмшигч өөрийн эзэмшиж буй хувьцааг тодорхой хугацаанд худалдахаас татгалзах үүрэг хүлээнэ.

9.6. Хувьцаа эзэмшигч нь хувьцаагаа гуравдагч этгээдэд худалдах, шилжүүлэх тохиолдолд Компанийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан журмын дагуу Компани болон бусад хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэж бусад хувьцаа эзэмшигчийн тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг хангана.

### **Арав. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ**

10.1. Компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байна. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь ээлжит болон ээлжит бус хэлбэртэй байна.

10.2. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийг эдэлнэ.

10.3. Компанийн саналын эрх бүхий хувьцааны 50-иас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд оролцоноор тухайн хурал хүчин төгөлдөр болно.

- 10.4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах, зар болон хэлэлцэх асуудлыг хүргэх, энэ талаар шийдвэр гаргах, хуралд оролцох эрх, хурлыг зохион байгуулах, хурлын тооллого явуулах, санал авах, хувьцаа эзэмшигчид эчнээ санал хураалтаар шийдвэр гаргахад Компанийн тухай хуулийн холбогдох заалтууд, энэхүү дүрэм, Компанийн ТУЗ-ийн баталсан "Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах журам"-ыг баримтална.
- 10.5. Компанийн тухай хуулийн 59.4-т заасан хугацааны дотор хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах шийдвэр гаргаагүй тохиолдолд ТУЗ-ийн өмнө гаргасан хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэрээр хурлыг зарласанд тооцно.
- 10.6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулахад хурал хуралдуулах шийдвэр гарснаас хойш 15-аас доошгүй хоногийн дараа, ээлжит бус хурлыг зарлан хуралдуулахад хурал хуралдуулах шийдвэр гарснаас хойш 5-аас доошгүй хоногийн дараа хурлыг хуралдуулна.
- 10.7. Дараах асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонх (2/3 ба түүнээс дээш)-ийн саналаар шийдвэрлэнэ. Үүнд:
  - 10.7.1. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах,
  - 10.7.2. Компанийг нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах зэргээр Компанийг өөрчлөн байгуулах,
  - 10.7.3. Компанийн өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох,
  - 10.7.4. Компанийн хэлбэрийг өөрчлөх,
  - 10.7.5. Компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох,
  - 10.7.6. Хувьцааг хуваах буюу нэгтгэх.
- 10.8. Дүрмийн 10.7-д зааснаас бусад асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсон саналын эрхтэй "50 хувийн хувьцаа эзэмшигч+1 хувьцаа" гэсэн зарчмын дагуу шийдвэрлэнэ.
- 10.9. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас шийдвэрлэсэн бүх асуудлаар тогтоол гаргана. Тогтоолд Хурал даргалагч болон хурлын явц, хэлэлцсэн асуудлын талаар

хурлын тэмдэглэл бичсэн ажилтан гарын үсэг зурна. Хэлэлцсэн асуудлын жагсаалт, тэмдэглэл, тогтоолуудыг Компанийн бүртгэлд бүртгэж хадгална.

- 10.10. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг эчнээ санал хураалт болон цахим хэлбэрээр зохион байгуулж болно.
- 10.11. Компани нь хувьцаа эзэмшигч болон олон нийтэд Компанийн тухай үнэн зөв мэдээллийг цаг хугацаанд нь хүргэх зорилгоор Компанийн цахим хуудас нээн ажиллуулна.
- 10.12. Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, шаардлагатай тохиолдолд саналын хуудас бөглүүлэн хуралд ирүүлэх үүргийг Говь-Алтай аймгийн баг тус бүрт ажиллах Компанийн төлөөлөгч бүрэн хариуцна.
- 10.13. Энэ дүрмийн 10.3-т заасан ирц хүрээгүйн улмаас хойшлогдсон хурлыг 5 хоногийн дотор дахин зарлан хуралдуулах өгөөд хойшлүгдсон хурлын ирцийг Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.4 дэх хэсгийн дагуу саналын эрхийн 20 буюу түүнээс дээш хувьийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд оролцсоноор хойшлогдсон хувьцаа эзэмшигчдийн хурал хүчин төгөлдөр болно.

#### **Арван нэг. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ**

- 11.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт Компанийн эрх барих байгууллага нь 5 (таван) хүний бүрэлдэхүүнтэй ТУЗ байна. ТУЗ-ийн үйл ажиллагаагаа явуулах хэлбэр нь ТУЗ-ийн хуралдаан байна.
- 11.2. ТУЗ нь Компанийн тухай хуулийн 82 дугаар зүйлд заасан ТУЗ-ийн нарийн бичгийн даргатай байна.
- 11.3. ТУЗ-ийн нарийн бичгийн даргын ажлын чиг үүрэгт ТУЗ болон түүний дэргэдэх хороодын засаглалын асуудлаар зөвөлгөө, мэдээлэл өгөх, дүрэм журмын хэрэгжилтэд хяналт тавих, ТУЗ-ийн бичиг хэрэг, хуралдааны тэмдэглэл хөтлөх, хуралдаан болон гишүүдийн сургалтыг тогтмол зохион байгуулах асуудал багтана.
- 11.4. ТУЗ-ийн гишүүдийн олонх нь буюу 3 (гурав)-аас доошгүй нь хараат бус гишүүн байна.

- 11.5. ТУЗ-ийн гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн хурлаас 2 (хоёр) жилийн хугацаагаар сонгож томилох ба бүрэн эрхийн хугацаа дууссаны дараа улираан сонгож болно.
- 11.6. ТУЗ-ийн даргыг ТУЗ-ийн хуралд оролцсон гишүүдийн энгийн олонхын саналаар сонгоно.
- 11.7. Гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн гишүүн байж болох бөгөөд Гүйцэтгэх захирлыг томилох, чөлөөлөх, түүний үйл ажиллагааны үр дүнг хэлэлцэх зэрэг Гүйцэтгэх захиралтай холбоотой аливаа асуудлыг ТУЗ шийдвэрлэхэд Гүйцэтгэх захирал саналын эрхгүй оролцоно.
- 11.8. ТУЗ нь Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлд зааснаас гадна дараах бүрэн эрхийг эдэлнэ. Үүнд:
  - 11.8.1. Компанийн бүтэц, зохион байгуулалтыг хэлэлцэн батлах,
  - 11.8.2. Компанийн жил бүрийн бизнес төлөвлөгөө, төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг хэлэлцэн батлах,
  - 11.8.3. Шаардлагатай тохиолдолд Компанийн үндсэн үйл ажиллагаанд хамаарах дүрэм, журмыг хэлэлцэн батлах,
  - 11.8.4. Компанийн охин, хараат компани, салбар, төлөөлөгчийн газрыг байгуулах болон тэдгээрийг өөрчлөн байгуулах шийдвэр гаргах, дүрмийг батлах, ТУЗ-ийн гишүүдийг томилох, гүйцэтгэх захирлыг томилж, түүний эрх хэмжээг тогтоох,
  - 11.8.5. Компанийн охин, хараат компанийн хувьцааг нэмж гаргах, түүний тоог тогтоох, ногдол ашгийн хэмжээг батлах, хувьцаа эзэмшигчийг төлөөлж хуралд оролцох, хувьцаа эзэмшигчийн нэрийн өмнөөс шийдвэр гаргах,
  - 11.8.6. Компанийн тухай хуулийн 6 дугаар бүлэгт заасан журмын дагуу ногдол ашгийн хэмжээ, түүнийг төлөх журмыг тодорхойлж хуваарилах,
  - 11.8.7. ТУЗ-ийн үйл ажиллагааны журам батлан хэрэгжүүлэх,
  - 11.8.8. ТУЗ-ийн дэргэд Аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороо, Эрсдэлийн хороо байгуулан ажиллуулах,

- 11.8.9. ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогыг батлах,
- 11.9. ТУЗ-ийн хурлаар хэлэлцэж гаргасан хүчин төгөлдөр шийдвэргүйгээр ТУЗ-ийн дарга нь дангаараа эсхүл аль нэг гишүүн болон хэд хэдэн гишүүд хамтран ТУЗ-ийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх, бүрэн эрхэд нь хамаарах асуудлаар шийдвэр гаргах буюу ТУЗ-ийг төлөөлөх эрхгүй. ТУЗ-ийн гишүүн нь ТУЗ-ийн тусгайлсан зөвшөөрөлгүйгээр ТУЗ-ийн байр суурийг төлөөлөх эрхгүй.
- 11.10. ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн хорооны чиг үүргийг Аудитын хороонд хариуцуулж болно.
- 11.11. ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны гишүүдийн олонх, түүнчлэн Аудитын хорооны дарга хараат бус гишүүн байна.
- 11.12. Компанийн тухай хууль, энэ дүрэм, хувьцаа эзэмшигчдийн гэрээгээр тогтоогоогүй ТУЗ болон түүний үйл ажиллагаатай холбоотой аливаа асуудлыг ТУЗ өөрөө тогтоож болно.

#### **Арван хоёр. ТУЗ-ИЙН ХУРАЛДААН, ШИЙДВЭР ГАРГАХ ЖУРАМ**

- 12.1. ТУЗ-ийн ээлжит хурлыг сар бүр хуралдуулна.
- 12.2. ТУЗ-ийн дарга эсхүл ТУЗ-ийн 2 ба түүнээс дээш тооны гишүүн ТУЗ-ийн хурал хуралдуулах хүсэлтээ ТУЗ-д гаргаж, хурлаар хэлэлцэх асуудлаа тодорхой ирүүлсэн тохиолдолд хурлыг ТУЗ-ийн дарга зарлан хуралдуулна. Энэ зүйлд заасан журмаар хүсэлт гаргаснаас хойш ажлын 10 хоногийн дотор ТУЗ-ийн дарга хурлыг зарлан хуралдуулаагүй бол хүсэлт гаргасан гишүүд энэ дүрэмд заасан журмын дагуу хурлыг зарлан хуралдуулах эрхтэй.
- 12.3. ТУЗ-ийн хурлын зарыг захидал, гишүүний Компанид бүртгүүлсэн цахим хаягийн аль нэгээр хурлаас 2-аас доошгүй хоногийн өмнө гишүүн бүрт хүргүүлнэ. Хурлын зард хурал хуралдах огноо, цаг, газрыг заахаас гадна тухайн хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт болон түүнтэй холбоотой баримт, материал, танилцуулга зэргийг хавсаргана. Яаралтай тохиолдолд ТУЗ-ийн дарга дээрх хугацааг богиносгож энэ тухай хурлын зард тусгана.
- 12.4. ТУЗ-ийн хурал нь нийт гишүүдийн олонх буюу 3 болон түүнээс дээш тооны гишүүн оролцсоноор хүчин төгөлдөр болно.

- 12.5. Хурлын ирц бүрдээгүй тохиолдолд хурлыг 7 хүртэл хоногоор хойшлуулж хурлын зарыг бүх гишүүдэд дахин мэдэгдэнэ. Хурал хойшилсон нь хурлын хэлэлцэх асуудалд өөрчлөлт орох үндэслэл болохгүй.
- 12.6. ТУЗ-ийн аль нэг гишүүн хуралд биечлэн оролцох боломжгүй тохиолдолд түүний хүсэлтийг үндэслэн хурлыг онлайн буюу цахим хэлбэрээр явуулж болох ба ийнхүү оролцсон гишүүнийг хуралд биечлэн оролцсонд тооцно.
- 12.7. Хурлаар шийдвэрлэж байгаа асуудлаар саналын эрхтэй гишүүдийн энгийн олонхийн саналаар шийдвэр гаргана. Гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд ТУЗ-ийн даргын саналаар шийдвэрлэнэ.
- 12.8. ТУЗ шийдвэрээ тогтоол хэлбэрээр гаргана. Уг тогтоолд ТУЗ-ийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.
- 12.9. Хурлын үйл явцыг дуу хураагуураар бичиж баталгаажуулж болно. Хурал болсноос хойш ажлын 5 өдрийн дотор ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хуралдааны тэмдэглэлийг Компанийн тухай хуулийн 80.11-т заасан журмын дагуу гаргах ба хуралд оролцсон гишүүд тэмдэглэлд гарын үсэг зурна. Хурлын тэмдэглэл дэх үг үсгийн талаар гишүүд өөр саналтай бол энэ талаар санал гаргах эрхтэй ба тэдгээр саналыг хурлын тэмдэглэлд хавсаргана.
- 12.10. ТУЗ-ийн бүх гишүүд зөвшөөрсөн тохиолдолд ТУЗ-ийн хурал хуралдахгүй, эчнээ санал хураалтаар асуудлыг шийдвэрлэж болно.

### **Арван гурав. ТУЗ ДЭХ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ**

- 13.1. ТУЗ-ийн гишүүн нь ТУЗ-өөр шийдвэрлэгдэх гэж байгаа аливаа асуудлын талаар шууд болон шууд бус сонирхлын зөрчилтэй байх тохиолдолд энэ тухайгаа ТУЗ-ийн даргад асуудлыг хурлаар хэлэлцэхээс өмнө мэдэгдэх үүрэгтэй.
- 13.2. Сонирхлын зөрчилтэй ТУЗ-ийн гишүүнийг тухайн асуудлыг хэлэлцүүлэхэд байлцуулах эсэхийг ТУЗ-ийн дарга шийдвэрлэх ба санал хураалтад оролцуулахгүй.
- 13.3. ТУЗ-ийн аль нэг гишүүн нь сонирхлын зөрчилтэй гэсэн үндэслэлээр санал хураалтад оролцоогүй нь тухайн хурлын ирцэд нөлөөлөхгүй.
- 13.4. Сонирхлын зөрчилтэй ТУЗ-ийн гишүүн түүнийгээ мэдэгдэхгүйгээр хуралд оролцож санал өгсөн нь хурлын дараа нь мэдэгдэж улмаар сонирхлын зөрчилтэй гишүүний өгсөн санал нь санал хураалтын үр дүнд нөлөөлсөн бол

ТУЗ-ийн даргын шийдвэрээр тухайн асуудлыг шийдсэн ТУЗ-ийн тогтоолыг хүчингүй болгож дахин саналт хураалт явуулна.

### **Арван дөрөв. ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА**

- 14.1. Компанийн гүйцэтгэх дээд албан тушаалтан нь Гүйцэтгэх захирал байх бөгөөд Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан явуулна.
- 14.1. Гүйцэтгэх удирдлагыг менежментийн багаар удирдуулах шийдвэрийг ТУЗ-өөс гаргасан тохиолдолд менежментийн багийн ахлагч нь Компанийн гүйцэтгэх захирал байна.
- 14.2. Гүйцэтгэх захирлын эрх хэмжээг энэ Дүрмийн холбогдох заалт болон ТУЗ-ийн даргатай байгуулсан гэрээгээр тодорхойлно.
- 14.3. Гүйцэтгэх захирал дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ. Дор дурдсанаас бусад асуудлыг ТУЗ шийдвэрлэнэ. Үүнд:
  - 14.3.1. Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдах,
  - 14.3.2. ТУЗ-ийн даргатай байгуулсан гэрээний хүрээнд Компанийг төлөөлөн үйл ажиллагаа явуулах, гэрээ хэлцэл байгуулах, ТУЗ-өөс тусгайлан эрх олгогдоогүй асуудлаар ТУЗ-өөс зөвшөөрөл авсны үндсэн дээр үйл ажиллагаа явуулах,
  - 14.3.3. Компанийн бүтэц, үйл ажиллагааны хэрэгцээ шаардлагад нийцүүлэн ажилтан сонгох, томилох, ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээ байгуулах, удирдах, урамшуулах, хариуцлага тооцох,
  - 14.3.4. Компанийн үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай аливаа материал хангалт, тоног төхөөрөмж, ус, байр, тээвэр үйлчилгээ, тусгай зөвшөөрөл зэргийг тухайн нөхцөл байдлыг харгалзан үзсэний үндсэн дээр хамгийн боломжтой нөхцөлөөр худалдан авах буюу олж авах,
  - 14.3.5. Үйл ажиллагаа явуулахад шаардагдах бүх зөвшөөрөл, лицензийг олж авах болон хугацаанд нь сунгуулах; хууль дүрмийг ноцтой зөрчсөн сэжиг бүхий асуудлыг ТУЗ-д яаралтай мэдэгдэх; Компанийн үйл ажиллагаанд шаардагдах болон үр дүнгийн талаар тайлан бэлтгэх, танилцуулах,
  - 14.3.6. Говь-Алтай аймгийн баг бүрт Компанийн төлөөлөгчийг томилох, чөлөөлөх,



- 14.3.7. Төрийн байгууллага, хууль хяналтын байгууллагад Компанийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх,
  - 14.3.8. ТУЗ-өөс тухайн цаг бүрт нь тодорхойлсны дагуу шаардлагатай даатгалд хамруулах,
  - 14.3.9. Холбогдох дүрэм журмын дагуу нягтлан бодох болон санхүүгийн тайлан тооцоог гаргах,
  - 14.3.10. Компанийн арилжааны банканд дахь гадаад валют болон төгрөгийн данстай холбоотой бичиг баримтад гарын үсэг зурах,
  - 14.3.11. Компанийн болон өөрийн албан үүргийг гүйцэтгэх явцдаа олж авсан нууц мэдээллийг хадгалах,
  - 14.3.12. Сонирхлын зөрчил бүхий хэлцлийг мэдсэн даруй ТУЗ-д мэдэгдэх,
  - 14.3.13. Компанийн оролцогч талуудын ашиг сонирхол, хэрэгцээ шаардлагыг зөв тодорхойлж, харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх,
  - 14.3.14. ТУЗ-ийн даргатай байгуулсан гэрээгээр олгогдсон бусад эрх үүрэг.
- 14.4. Гүйцэтгэх захирал нь Компанийн охин, хараат компани, салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагаанд ТУЗ-ийн зөвшөөрөл олгосноос бусад хэлбэрээр оролцохыг хориглоно.
- 14.5. Гүйцэтгэх захирал нь их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг ТУЗ-ийн шийдвэргүйгээр хийхийг хориглоно.
- 14.6. Гүйцэтгэх захирлын шууд удирдлагад байгууллагын дотоод үйл ажиллагаанд бүхэлд нь хяналт тавих чиг үүрэг бүхий дотоод хяналтын нэгж эсвэл ажилтанг томилон ажиллуулна.

#### **Арван тав. КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН**

- 15.1. Доор дурдсан этгээдүүд нь Компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцогдоно. Үүнд:
- 15.1.1. ТУЗ-ийн дарга, гишүүн, нарийн бичгийн дарга,
  - 15.1.2. Гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, гүйцэтгэх захирал,
  - 15.1.3. Ерөнхий нягтлан бодогч.

- 15.2. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь Компанийн тухай хуулийн 89.1.1-89.1.4-т заасан сонирхлын зөрчилтэй хэлцлийг хийхдээ Компанийн тухай хуульд заасан сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журмыг баримтална.
- 15.3. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх, аливаа улс төрийн намын эрх ашигт үйлчлэхгүй байх үүрэгтэй.

### **Арван зургаа. ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЭЛ**

- 16.1. Жил бүрийн эхний сард ТУЗ-өөс Компанийн тухайн жилийн бизнес төлөвлөгөөг батлах (цаашид "Бизнес төлөвлөгөө" гэх) ба уг төлөвлөгөөнд тухайн жилд худалдан авах их хэмжээний хэлцлийн жагсаалтыг тусгана.
- 16.2. Бизнес төлөвлөгөөнд заасан их хэмжээний хэлцлийн жагсаалтыг ТУЗ-ийн гишүүд санал нэгтгэйгээр батална.
- 16.3. Бизнес төлөвлөгөөнд заасан их хэмжээний хэлцлийн жагсаалтын хүрээнд хийгдсэн хэлцлийг Компанийн тухай хуульд заасан журмын дагуу хийгдсэн хэлцэл гэж үзэх ба харин уг төлөвлөгөөнд тусгагдаагүй Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн дагуу их хэмжээний хэлцэлд тооцогдох бусад хэлцлийг хийхэд Компанийн тухай хуулийн 88 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

### **Арван долоо. ТАТВАР БА ХЯНАЛТ, САНХҮҮГИЙН ТАЙЛАН, АУДИТ**

- 17.1. Компанийн санхүүгийн жил нь жил бүрийн 1 дүгээр сарын 1-нээс эхэлж 12 дугаар сарын 31-нд дуусна.
- 17.2. Санхүүгийн болон нягтлан бодох бүртгэл тооцоо нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомж болон нягтлан бодох бүртгэлийн олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн зарчим, практикийн дагуу хэрэгжинэ.
- 17.3. ТУЗ-ийн шийдвэрээр сонгогдсон аудитын байгууллагаар Компани аудит хийлгэж болно. Нэг аудитын байгууллагын ажиллах дээд хугацаа 3 жил байна.
- 17.4. Компани Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн аливаа хураамж, газар ашигласны төлбөр зэргийг оролцуулан орлогын болон бусад төрлийн татварыг төлнө. Татварыг дотоодын мөнгөн тэмдэгтээр төлнө.
- 17.5. Компани нь өөрийн ашгаас улсын төсөвт төлөх татварыг төлсний дараа Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн өөрийн санхүүгийн байдлыг

харгалзан үзсэний үндсэн дээр Хувьцаа эзэмшигчээс тогтоосон хэмжээгээр нөөцийн болон бусад сан байгуулж болно.

- 17.6. Компани нь санхүүгийн үзүүлэлтээ улирал болон жилээр түүнчлэн орлого, зарлагын мэдээллээ холбогдох Татварын болон Аудитын байгууллагад гаргаж өгнө. Компанийн жилийн санхүүгийн бүртгэл тайланд хараат бус хөндлөнгийн аудитораар хяналт шалгалт хийлгэх бөгөөд аудитын тайланг Хувьцаа эзэмшигч, Монгол Улсын эрх бүхий байгууллага болон Хувьцаа эзэмшигчээс томилсон аливаа этгээдэд танилцуулна.
- 17.7. Компани нь дотоодын төгрөгийн болон чөлөөт хөрвөх гадаад мөнгөн тэмдэгтийн дансыг Монгол Улсын болон гадаадын аливаа банканд нээж болно.
- 17.8. Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ. Үүнд:
  - 17.8.1. Компанийн хөрөнгө, ашиг, зарлагын бүртгэлийг нягт нямбай бөгөөд бүрэн хөтлөх,
  - 17.8.2. Компанийн санхүүгийн тайлан бүртгэл тооцоог Монгол Улсын нягтлан бодох, санхүү, бүртгэлийн тухай холбогдох хууль тогтоомж, олон улсын стандартад нийцүүлэн хуульд заасан журмын дагуу тогтмол бэлтгэх,
  - 17.8.3. ТУЗ-өөс зөвшөөрөгдсөн хэмжээнд Компанийн зарлагыг гаргах,
  - 17.8.4. Гүйцэтгэх захирал болон ТУЗ-ийн өмнө санхүүгийн бүх хэлцэл болон компанийн санхүүгийн байдлын талаар хариуцлага хүлээх, тайлагнах.

**Арван найм. КОМПАНИЙГ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ,  
ТАТАН БУУЛГАХ**

- 18.1. Компанийг хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол болон шүүхийн шийдвэрээр өөрчлөгдөн байгуулах буюу татан буулгана.
- 18.2. Компанийг татан буулгасан тохиолдолд Компанийн төлөх ёстой бүх өр төлбөрийг барагдуулсны дараа үлдсэн хөрөнгийг хувьцаа эзэмшигчдэд шилжүүлнэ.
- 18.3. Компанийг өөрчлөн байгуулах болон татан буулгах асуудлыг Компанийн тухай хуулийн 26-29 дүгээр зүйлд заасан журмын дагуу гүйцэтгэнэ.

**Арван ес. ХЭРЭГЛЭГДЭХ ХУУЛЬ ТОГТООМЖ**

19.1. Энэхүү Дүрмийг батлах, хүчин төгөлдөр болгох, хэрэгжүүлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох, тайлбарлахад Монгол Улсын хууль тогтоомжийг баримтална.

**Хорь. ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ**

20.1. Энэхүү Дүрэм нь 2023 оны ... дугаар сарын ...-ний өдөр батлагдсан бөгөөд Улсын бүртгэлийн албанд бүртгүүлснээр хүчин төгөлдөр болно.

----ooOoo----

**Хавсралт 3. Компанийн тухай хуулийн зохицуулалтууд**

Д/Д	Компанийн тухай хууль	Дүрэмд тусгасан хувилбар, тайлбар
1	<p><b>Хуулийн 16 дугаар зүйл</b></p> <p>16.2 Компанийн дүрэмд дараах зүйлийг заавал тусгана.</p> <p>16.2.1. компанийн бүрэн болон товчилсон оноосон нэр, түүний хэлбэрийг тодорхойлсон товчилсон ялгах тэмдэглэгээ;</p>	<p><b>Дүрмийн 2.1 дүгээр заалт</b></p> <p>2.1 Компанийн оноосон нэрийг крилл үсгээр [.....] ХХК, латин үсгээр [.....] LLC гэх бөгөөд оноосон нэрийг үгийн утгын хувьд цаашид дэлгэрүүлж тайлбарлахгүй, орчуулахгүй, салгаж бичихгүй болно.</p>
	<p><b>Хуулийн 16 дугаар зүйл</b></p> <p>16.2 Компанийн дүрэмд дараах зүйлийг заавал тусгана.</p> <p>16.2.2. компанийн зарласан болон гаргасан хувьцааны тоо, тэдгээрийн төрөл, нэрлэсэн үнэ, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ;</p>	<p><b>Дүрмийн 7.2, 7.3 дугаар заалтууд</b></p> <p>7.2 Компанийн зарласан хувьцаа нь нэг бүр нь 1000 (нэг мянган) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 300,000,000 (гурван зуун сая) ширхэг энгийн хувьцаа байна.</p> <p>7.3 Компани нь нийт зарласан энгийн хувьцаанаас [.....] ([.....]) ширхэг энгийн хувьцааг гаргасан бөгөөд Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь [.....] ([.....]) төгрөгтэй тэнцүү байна.</p>
	<p><b>Хуулийн 16 дугаар зүйл</b></p> <p>16.2 Компанийн дүрэмд дараах зүйлийг заавал тусгана.</p> <p>16.2.3. компанийн дүрмээр давуу эрхийн хувьцааг зарласан нөхцөлд давуу эрхийн хувьцааны зарласан тоо, түүний эзэмшигчийн эрх;</p>	<p><b>Дүрмийн 7.4 дүгээр заалт</b></p> <p>7.4 Компани хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр давуу эрхийн хувьцааг гаргаж болно.</p> <p><i>Тайлбар: Одоогоор давуу эрхийн хувьцаа гаргах шийдвэр гараагүй учраас зөвхөн дээрх зохицуулалтыг дүрэмд тусгав.</i></p>
	<p><b>Хуулийн 16 дугаар зүйл</b></p> <p>16.2 Компанийн дүрэмд дараах зүйлийг заавал тусгана.</p> <p>16.2.4. хэрэв төлөөлөн</p>	<p><b>Дүрмийн 11.1 дүгээр заалт</b></p> <p>11.1 Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт Компанийн эрх барих байгууллага нь 5 (таван) хүний бүрэлдэхүүнтэй ТУЗ байна. ТУЗ-</p>

<p>удирдах зөвлөлтэй байхаар шийдвэрлэсэн бол төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоо;</p>	<p>ийн үйл ажиллагаагаа явуулах хэлбэр нь ТУЗ-ийн хуралдаан байна.</p>
<p><b>Хуулийн 16 дугаар зүйл</b></p> <p>16.2 Компанийн дүрэмд дараах зүйлийг заавал тусгана. 16.2.5.хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөлийн энэ хуулиар тодорхойлсноос бусад бүрэн эрх;</p>	<p><b>Дүрмийн 11.8 дугаар заалт</b></p> <p>11.8 ТУЗ нь Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлд зааснаас гадна дараах бүрэн эрхийг эдэлнэ. Үүнд:</p> <p>11.8.1 Компанийн бүтэц, зохион байгуулалтыг хэлэлцэн батлах,</p> <p>11.8.2 Компанийн жил бүрийн бизнес төлөвлөгөө, төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг хэлэлцэн батлах,</p> <p>11.8.3 Шаардлагатай тохиолдолд Компанийн үндсэн үйл ажиллагаанд хамаарах дүрэм, журмыг хэлэлцэн батлах,</p> <p>11.8.4 Компанийн охин, хараат компани, салбар, төлөөлөгчийн газрыг байгуулах болон тэдгээрийг өөрчлөн байгуулах шийдвэр гаргах, дүрмийг батлах, ТУЗ-ийн гишүүдийг томилох, гүйцэтгэх захирлыг томилж, түүний эрх хэмжээг тогтоох,</p> <p>11.8.5 Компанийн охин, хараат компанийн хувьцааг нэмж гаргах, түүний тоог тогтоох, ногдол ашгийн хэмжээг батлах, хувьцаа эзэмшигчийг төлөөлж хуралд оролцох, хувьцаа эзэмшигчийн нэрийн өмнөөс шийдвэр гаргах,</p> <p>11.8.6 Компанийн тухай хуулийн 6 дугаар бүлэгт заасан журмын дагуу ногдол ашгийн хэмжээ, түүнийг төлөх журмыг тодорхойлж хуваарилах,</p> <p>11.8.7 ТУЗ-ийн үйл ажиллагааны журам батлан хэрэгжүүлэх,</p> <p>11.8.8 ТУЗ-ийн дэргэд Аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын</p>

		<p>хороо, Эрсдэлийн хороо байгуулан ажиллуулах,          11.8.9 ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогыг батлах,</p>
	<p><b>Хуулийн 16 дугаар зүйл</b>          16.2 Компанийн дүрэмд дараах зүйлийг заавал тусгана.          16.2.6. компанийн үйл ажиллагааны чиглэл;</p>	<p><b>Дүрмийн 3.3 дугаар заалт</b>          3.3 Компани нь дараах чиглэлээр үйл ажиллагаа эрхэлнэ. Үүнд:          3.3.1 Малын гаралтай бараа бүтээгдэхүүн, түүхий эдийг боловсруулах;          3.3.2 Нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх;          3.3.3 Гадаад дотоод худалдаа эрхлэх;</p>

**Хавсралт 4. Компанийн засаглалын кодексийн зохицуулалтууд**

<b>Д/Д</b>	<b>Компанийн засаглалын кодекс</b>	<b>Дүрэмд тусгасан хувилбар, тайлбар</b>
<b>1</b>	<b>Кодексийн үйлчлэх хүрээ</b> Үнэт цаасаа олон нийтэд арилждаггүй хаалттай компанийн хувьд кодексст заасан зарчмуудыг нэвтрүүлж хэрэгжүүлэхийг зөвлөж байна.	<b>Дүрмийн 5.2 дугаар заалт</b> 5.2 Компани нь төрийн эрх бүхий байгууллагын баталсан “Компанийн засаглалын кодекс”, “Тогтвортой хөгжлийн зарчмууд” баримт бичгүүдийг үйл ажиллагаандаа бүрэн эсвэл хэсэгчлэн нэвтрүүлэхийн төлөө хүчин чармайлт гаргана.
<b>2</b>	<b>Кодексийн 1 дүгээр зарчим</b> 1.6 ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар ТУЗ-ийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.	<b>Дүрмийн 11.2 дугаар заалт</b> 11.2 ТУЗ-ийн нарийн бичгийн даргын ажлын чиг үүрэгт ТУЗ болон түүний дэргэдэх хороодын засаглалын асуудлаар зөвөлгөө, мэдээлэл өгөх, дүрэм журмын хэрэгжилтэд хяналт тавих, ТУЗ-ийн бичиг хэрэг, хуралдааны тэмдэглэл хөтлөх, хуралдаан болон гишүүдийн сургалтыг тогтмол зохион байгуулах асуудал багтана.
<b>3</b>	<b>Кодексийн 2 дугаар зарчим</b> 2.1 ТУЗ-ийн дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.	<b>Дүрмийн 11.4 дүгээр заалт</b> 11.4 ТУЗ-ийн гишүүдийн олонх буюу 5 (тав)-аас доошгүй нь хараат бус гишүүн байна.
<b>4</b>	<b>Кодексийн 2 дугаар зарчим</b> 2.2 ТУЗ нь ... үйл ажиллагааны журамтай байна.	<b>Дүрмийн 11.8.7 дугаар заалт</b> 11.8. ТУЗ ... дараах бүрэн эрхтэй. Үүнд: 11.8.7 ТУЗ-ийн үйл ажиллагааны журам батлан хэрэгжүүлэх;
<b>5</b>	<b>Кодексийн 2 дугаар зарчим</b> 2. ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн	<b>Дүрмийн 11.8.8 дугаар заалт</b> 11.8. ТУЗ ... дараах бүрэн эрхтэй. Үүнд: 11.8.8 ТУЗ-ийн дэргэд Аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороо, Эрсдэлийн хороо



	хариуцлагыг хүлээнэ.	байгуулан ажиллуулах;
<b>6</b>	<b>Кодексийн 2 дугаар зарчим</b> 2.4 ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна.	<b>Дүрмийн 11.8.9 дүгээр заалт</b> 11.8. ТУЗ ... дараах бүрэн эрхтэй. Үүнд: 11.8.9 ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогыг батлах;
<b>7</b>	<b>Кодексийн 5 дугаар зарчим</b> 5.2 Тайлбар хэсэг: Эрсдэлийн хорооны чиг үүргийг Аудитын хороонд хариуцуулж болно.	<b>Дүрмийн 11.10 дугаар заалт</b> 11.10 ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн хорооны чиг үүргийг Аудитын хороонд хариуцуулж болно.
<b>8</b>	<b>Кодексийн 5 дугаар зарчим</b> 5.2 ТУЗ нь дэргэдээ эрсдэлийн хороотой байхыг зорих ба дарга гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна.	<b>Дүрмийн 11.11 дүгээр заалт</b> 11.11 ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны гишүүдийн олонх, түүнчлэн Аудитын хорооны дарга хараат бус гишүүн байна.
<b>9</b>	<b>Кодексийн 7 дугаар зарчим</b> 7.1 ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.	<b>Дүрмийн 14.3.13 дугаар заалт</b> 14.3 Гүйцэтгэх захирал дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ. Дор дурдсанаас бусад асуудлыг ТУЗ шийдвэрлэнэ. Үүнд: 14.3.13 Компанийн оролцогч талуудын ашиг сонирхол, хэрэгцээ шаардлагыг зөв тодорхойлж, харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх;
<b>10</b>	<b>Кодексийн 8 дугаар зарчим</b> 8.3 Компанийн ёс зүйн дүрмээр авлига албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, дэмжихгүй байх, хандив өргөх эсэх талаар зохицуулна.	<b>Дүрмийн 15.3 дугаар заалт</b> 15.3 Компанийн эрх бүхий албан тушаалтан нь авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх, аливаа улс төрийн намын эрх ашигт үйлчлэхгүй байх үүрэгтэй.
<b>11</b>	<b>Кодексийн 9 дүгээр зарчим</b>	<b>Дүрмийн 10.11 дүгээр заалт</b>

	<p>9.1 Компани хөрөнгө оруулагч болон бусад оролцогч талуудад зориулан өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнг цахим хуудсаараа дамжуулан тухай бүр хүргэнэ.</p>	<p>10.11 Компани нь хувьцаа эзэмшигч болон оролцогч талуудад Компанийн тухай үнэн зөв мэдээллийг цаг хугацаанд нь хүргэх зорилгоор Компанийн цахим хуудас нээн ажиллуулна.</p>
<p><b>12</b></p>	<p><b>Кодексийн 9 дүгээр зарчим</b></p> <p>9.3 Компани нь хувьцаа эзэмшигч бүр хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо нөхцөлийг бүрдүүлнэ.</p>	<p><b>Дүрмийн 10.12 дугаар заалт</b></p> <p>10.12 Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, шаардлагатай тохиолдолд саналын хуудас бөглүүлэн хуралд ирүүлэх үүргийг Говь-Алтай аймгийн баг тус бүрт ажиллах Компанийн төлөөлөгч бүрэн хариуцна.</p>

**Хавсралт 5. Компанийн дүрмийн зохицуулалтууд**

<b>Д/Д</b>	<b>Компанийн тухай хуулийн заалт</b>	<b>Дүрэмд тусгасан хувилбар, тайлбар</b>
<b>1</b>	<p><b>4 дүгээр зүйл. Хувьцаат компани</b></p> <p>4.3. Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол нээлттэй хувьцаат компани нь нээлттэй буюу хаалттай захиалгын үндсэн дээр хувьцаа болон бусад үнэт цаас гаргаж болно.</p>	<p><b>Дүрмийн заалт байхгүй</b></p> <p><i>Тайлбар: Хязгаарлагдмал хариуцлагатай компани учраас энэ заалт хамаарахгүй</i></p>
<b>2</b>	<p><b>5 дугаар зүйл. Хязгаарлагдмал хариуцлагатай компани</b></p> <p>5.3. Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигч нь компанийн болон бусад хувьцаа эзэмшигчийн худалдах хувьцаа, түүнийг худалдан авах эрхийн бичиг болон тэдгээрт хөрвөх үнэт цаасыг гуравдагч этгээдэд санал болгох үнээр өөрийн эзэмшлийн хувьцааныхаа тоонд хувь тэнцүүлэн энэ хууль болон компанийн дүрэмд заасны дагуу тэргүүн ээлжид худалдан авах эрхтэй.</p>	<p><b>Дүрмийн 9.2 дугаар заалт</b></p> <p>.</p> <p>9.2 Компанийн энгийн хувьцаа эзэмшигч нь Компаниас нэмж гаргаж байгаа хувьцаа болон Компанийн хувьцааг худалдан авах эрхийн опционыг өөрийн энгийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн тэргүүн ээлжинд худалдан авах эрхтэй ба уг эрх нь дараах тохиолдлуудад үл хэрэгжинэ. Үүнд:</p> <p>9.2.1 Тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ хувьцаа эзэмшигч хэрэгжүүлэхээс татгалзсан тохиолдолд;</p> <p>9.2.2 Стратегийн хөрөнгө оруулалт татахаар ТУЗ-өөс шийдвэрлэсний үндсэн дээр нэмж хувьцаа гаргаж байгаа тохиолдолд;</p> <p>9.2.3 Гүйцэтгэх удирдлага буюу менежментийн багт олгох зорилгоор опцион гаргах тохиолдолд;</p> <p><i>Тайлбар: Хуулиар олгогдсон эрхийн хүрээнд стратегийн хөрөнгө оруулагч шинээр хувьцаа худалдан авах болон гүйцэтгэх удирдлага буюу менежментийн багт опцион гэрээний эрх олгох тохиолдлуудад хувьцаа эзэмшигч тэдгээрийг тэргүүн ээлжинд худалдан авах эрхээсээ татгалзахаар дүрэмд</i></p>

		<i>тусгасан болно.</i>
<b>3</b>	<p><b>5 дугаар зүйл. Хязгаарлагдмал хариуцлагатай компани</b></p> <p>5.8. Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол хувьцаа эзэмшигч нь бусад хувьцаа эзэмшигчийн хувьцааг энэ хуулийн 5.3-т заасны дагуу тэргүүн ээлжид худалдан авах эрхээ бүхэлд нь буюу зарим хэсгийг нь хэрэгжүүлэх, эсхүл энэ эрхээ бүхэлд нь буюу зарим хэсгийг нь бусад хувьцаа эзэмшигчид шилжүүлэх эрхтэй.</p>	<p><b>Дүрмийн 9.2 дугаар заалт</b></p> <p>-</p> <p><i>Тайлбар: Дүрмийн 9.2 дугаар заалтаар хязгаарласан.</i></p>
<b>4</b>	<p><b>5 дугаар зүйл. Хязгаарлагдмал хариуцлагатай компани</b></p> <p>5.9. Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 5.3-т заасан эрхийг хувьцаа эзэмшигч тогтоосон хугацаанд бүрэн хэрэгжүүлээгүй тохиолдолд уг эрх компанид шилжих бөгөөд компани нь энэхүү эрхийг хэрэгжүүлэх эсэх тухай шийдвэрээ энэ хуулийн 5.4-т заасан мэдэгдэлд заасан хугацаа дууссанаас хойш ажлын таван өдрийн дотор гаргана.</p>	<p><b>Дүрмийн 9.2 дугаар заалт</b></p> <p>-</p> <p><i>Тайлбар: Дүрмийн 9.2 дугаар заалтаар хязгаарласан.</i></p>
<b>5</b>	<p><b>7 дугаар зүйл. Компанийн салбар, төлөөлөгчийн газар</b></p> <p>7.4. Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол компанийн салбар, төлөөлөгчийн газар байгуулах тухай шийдвэрийг компанийн төлөөлөн удирдах зөвлөл гаргана.</p>	<p><b>Дүрэмд өөрөөр заагаагүй</b></p> <p><i>Тайлбар: Компанийн тухай хуулийн зохицуулалт хангалттай гэж үзсэн</i></p>
<b>6</b>	<p><b>7 дугаар зүйл. Компанийн салбар, төлөөлөгчийн газар</b></p> <p>7.11. Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол компанийн салбар, төлөөлөгчийн газрын удирдлагыг төлөөлөн удирдах зөвлөл (байхгүй бол гүйцэтгэх удирдлага) томилох бөгөөд тэдгээр нь компаниас олгосон итгэмжлэлийн үндсэн дээр үйл</p>	<p><b>Дүрэмд өөрөөр заагаагүй</b></p> <p><i>Тайлбар: Компанийн тухай хуулийн зохицуулалт хангалттай гэж үзсэн</i></p>

	ажиллагаа явуулна.	
7	<b>8 дугаар зүйл. Компанийн үйл ажиллагааны чиглэл, хугацаа</b>  8.5. Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол компанийг тодорхой бус хугацаагаар үүсгэн байгуулна.	<b>Дүрэмд өөрөөр заагаагүй</b>  <i>Тайлбар: Компанийн тухай хуулийн зохицуулалт хангалттай гэж үзсэн</i>
8	<b>33 дугаар зүйл. Компанийн зарласан болон гаргасан хувьцаа</b>  33.3. Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол зарласан хувьцааны төрөл тус бүрээс гаргах хувьцааны тоо, гаргах хугацаа, нөхцөлийг төлөөлөн удирдах зөвлөл (байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал) тогтооно.	<b>Дүрэмд өөрөөр заагаагүй</b>  <i>Тайлбар: Компанийн тухай хуулийн зохицуулалт хангалттай гэж үзсэн</i>
9	<b>33 дугаар зүйл. Компанийн зарласан болон гаргасан хувьцаа</b>  33.8. Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол компани нь энэ хуулийн 33.7-д заасан хувьцааг дахин гаргаж болно.	<b>Дүрэмд өөрөөр заагаагүй</b>  <i>Тайлбар: Компанийн тухай хуулийн зохицуулалт хангалттай гэж үзсэн</i>
10	<b>34 дүгээр зүйл. Компанийн энгийн хувьцаа эзэмшигчийн эрх</b>  34.3. Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол хязгаарлагдмал хариуцлагатай компанийн энгийн хувьцаа эзэмшигч нь хувьцаанд хамаарах бусад үнэт цаасыг энэ зүйлд заасан бусад журмын дагуу тэргүүн ээлжинд худалдан авах эрхтэй.	<b>Дүрмийн 9.2.3 дугаар заалт</b>  9.2.3 Хувьцаанд хамаарах үнэт цаас буюу опционтой холбоотой зарим эрхийг хязгаарласан бөгөөд үндэслэлийг 9.2 дахь заалтын тайлбараас харна уу
11	<b>41 дүгээр зүйл. Компанийн өрийн бичиг</b>  41.2. Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 41.1-д заасны дагуу өрийн бичиг гаргах шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл гаргана.	<b>Дүрэмд өөрөөр заагаагүй</b>  <i>Тайлбар: Компанийн тухай хуулийн зохицуулалт хангалттай гэж үзсэн</i>
12	<b>42 дугаар зүйл. Үнэт цаас гаргах тухай шийдвэр</b>	<b>Дүрэмд өөрөөр заагаагүй</b>

	<p>42.1. Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол зарласан хувьцаанаас гүйлгээнд гаргах, компанийн дүрэмд заасан бусад төрлийн үнэт цаас болон өрийн бичиг гаргах тухай шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл (байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал) гаргах бөгөөд уг шийдвэрт үнэт цаасны төрөл, тоо, гаргах хугацаа, нөхцөлийг заана.</p>	<p><i>Тайлбар: Компанийн тухай хуулийн зохицуулалт хангалттай гэж үзсэн</i></p>
<p><b>13</b></p>	<p><b>44 дүгээр зүйл. Үнэт цаасны төлбөр</b></p> <p>44.1. Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол гаргасан үнэт цаасыг худалдан авч байгаа этгээд нь төлбөрөө мөнгө, үнэт цаас, эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийн хэлбэрээр хийж болно.</p>	<p><b>Дүрмийн 8.7 дугаар заалт</b></p> <p>8.7 Хувьцаа эзэмшигч нь дараах эрхийг эдэлж, үүрэг хүлээнэ. Үүнд:</p> <p>8.7.1 Заасан хугацааны дотор Компанид бэлэн мөнгөөр болон хувьцаа худалдах худалдан авах гэрээнд заасан эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн хэлбэрээр хөрөнгө оруулалт хийх,</p> <p><i>Тайлбар: Компанийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсэгт заасан хэлбэрүүдээс “үнэт цаас”-ны хэлбэрээр төлбөр хийх зохицуулалтыг хасч, харин түүхий эд эсвэл түүхий эдийн эрхийн хэлбэрээр төлбөр хийх боломжийг тусгасан.</i></p>
<p><b>14</b></p>	<p><b>44 дүгээр зүйл. Үнэт цаасны төлбөр</b></p> <p>44.4. Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол үнэт цаасны төлбөрийг дараах тохиолдолд мөнгөн бус хэлбэрээр хийж болно:</p> <p>44.4.1. үүсгэн байгуулах үед үүсгэн байгуулагчид хувьцааны төлбөрийг мөнгөн бус хэлбэрээр хийхийг энэ хуулийн 13.3-т заасан үүсгэн байгуулах гэрээнд зөвшөөрсөн бол;</p> <p>44.4.2. нэмж гаргаж байгаа үнэт цаасны төлбөрийг мөнгөн бус хэлбэрээр хийж болохоор эрх бүхий байгууллагын шийдвэрт заасан бол.</p>	<p><b>Дүрмийн 8.7 дугаар заалт</b></p> <p>8.7 Хувьцаа эзэмшигч нь дараах эрхийг эдэлж, үүрэг хүлээнэ. Үүнд:</p> <p>8.7.1 Заасан хугацааны дотор Компанид бэлэн мөнгөөр болон хувьцаа худалдах худалдан авах гэрээнд заасан эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн хэлбэрээр хөрөнгө оруулалт хийх,</p> <p><i>Тайлбар: Компанийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсэгт заасан хэлбэрүүдээс “үнэт цаас”-ны хэлбэрээр төлбөр хийх зохицуулалтыг хасч, харин түүхий эд эсвэл түүхий эдийн эрхийн хэлбэрээр төлбөр хийх боломжийг тусгасан.</i></p>

<p><b>15</b></p>	<p><b>46 дугаар зүйл. Ногдол ашиг хуваарилах</b></p> <p>46.1. Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөл (байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал) ногдол ашиг хуваарилах эсэх тухай шийдвэрийг гаргах бөгөөд уг шийдвэрт хувьцаа бүрд ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдөр болон ногдол ашиг төлөх өдөр зэргийг заана.</p>	<p><b>Дүрэмд өөрөөр заагаагүй</b></p> <p><i>Тайлбар: Компанийн тухай хуулийн зохицуулалт хангалттай гэж үзсэн</i></p>
<p><b>16</b></p>	<p><b>46 дугаар зүйл. Ногдол ашиг хуваарилах</b></p> <p>46.7. Ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр хуваарилах бөгөөд компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол ногдол ашгийг бэлэн мөнгө болон эд хөрөнгийн, эсхүл компанийн болон бусад этгээдийн үнэт цаасны хэлбэрээр төлж болно.</p>	<p><b>Дүрэмд өөрөөр заагаагүй</b></p> <p><i>Тайлбар: Компанийн тухай хуулийн зохицуулалт хангалттай гэж үзсэн</i></p>
<p><b>17</b></p>	<p><b>49 дүгээр зүйл. Үнэт цаас эргүүлэн худалдаж авах</b></p> <p>49.1. Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол компани нь төлөөлөн удирдах зөвлөл (байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал)-ийн шийдвэрээр өөрийн гаргасан үнэт цаасыг эзэмшигчтэй нь тохиролцсоны үндсэн дээр худалдан авч болно.</p>	<p><b>Дүрэмд өөрөөр заагаагүй</b></p> <p><i>Тайлбар: Компанийн тухай хуулийн зохицуулалт хангалттай гэж үзсэн</i></p>
<p><b>18</b></p>	<p><b>49 дүгээр зүйл. Үнэт цаас эргүүлэн худалдаж авах</b></p> <p>49.5. Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол компани нь үнэт цаас эргүүлэн худалдаж авахдаа худалдаж байгаа этгээдтэй тохиролцсоны дагуу түүний төлбөрийг бэлэн мөнгө, үнэт цаас буюу эд хөрөнгийн бусад хэлбэрээр хийж болно.</p>	<p><b>Дүрэмд өөрөөр заагаагүй</b></p> <p><i>Тайлбар: Компанийн тухай хуулийн зохицуулалт хангалттай гэж үзсэн</i></p>

<p>19</p>	<p><b>55 дугаар зүйл. Эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тодорхойлох</b></p> <p>55.2. Энэ хууль болон компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол компанийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг төлөөлөн удирдах зөвлөл (байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал) тогтооно.</p>	<p><b>Дүрэмд өөрөөр заагаагүй</b></p> <p><i>Тайлбар: Компанийн тухай хуулийн зохицуулалт хангалттай гэж үзсэн</i></p>
<p>20</p>	<p><b>60 дугаар зүйл. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэр гаргах</b></p> <p>60.3. Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол хувьцаа эзэмшигчдийн хурлыг энэ хуулийн 60.1-д заасан шийдвэр гарснаас хойш 40-өөс доошгүй хоногийн дараа хуралдуулна.</p>	<p><b>Дүрмийн 10.6 дугаар заалт</b></p> <p>10.6 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулахад хурал хуралдуулах шийдвэр гарснаас хойш 15-аас доошгүй хоногийн дараа, ээлжит бус хурлыг зарлан хуралдуулахад хурал хуралдуулах шийдвэр гарснаас хойш 5-аас доошгүй хоногийн дараа хурлыг хуралдуулна.</p> <p><i>Тайлбар: Зарим тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлыг богино хугацаанд зарлан хуралдуулах шаардлага үүсдэг тул ээлжит бус хурлын хугацааг уян хатан тогтоосон.</i></p>
<p>21</p>	<p><b>62 дугаар зүйл. Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрх</b></p> <p>62.1.13. компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох;</p>	<p><b>Дүрэмд өөрөөр заагаагүй</b></p> <p><i>Тайлбар: Компанийн тухай хуулийн зохицуулалт хангалттай гэж үзсэн</i></p>
<p>22</p>	<p><b>63 дугаар зүйл. Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр хүчин төгөлдөр болох</b></p> <p>63.6. Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөл (байхгүй бол гүйцэтгэх удирдлага)-ийн гишүүдийг сонгохдоо нэр дэвшигчдээс хамгийн олон санал авсан хүнийг сонгоно.</p>	<p><b>Дүрэмд өөрөөр заагаагүй</b></p> <p><i>Тайлбар: Компанийн тухай хуулийн зохицуулалт хангалттай гэж үзсэн</i></p>



<p><b>23</b></p>	<p><b>75 дугаар зүйл. Төлөөлөн удирдах зөвлөл</b></p> <p>75.2. Хувьцаат компани нь төлөөлөн удирдах зөвлөлтэй байх бөгөөд хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлгүй байж болно.</p>	<p><b>Дүрмийн 11.1 дүгээр заалт</b></p> <p>11.1 Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт Компанийн эрх барих байгууллага нь 9 (ес) хүний бүрэлдэхүүнтэй ТУЗ байна. ТУЗ-ийн үйл ажиллагаагаа явуулах хэлбэр нь ТУЗ-ийн хурал байна.</p> <p><i>Тайлбар: Олон мянган хувьцаа эзэмшигчтэй тул төлөөлөн удирдах зөвлөл байгуулах шаардлагатай.</i></p>
<p><b>24</b></p>	<p><b>76 дугаар зүйл. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх</b></p> <p>76.1.12. компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол ногдол ашгийн хэмжээ, түүнийг төлөх журмыг тодорхойлох;</p>	<p><b>Дүрэмд өөрөөр заагаагүй</b></p> <p><i>Тайлбар: Компанийн тухай хуулийн зохицуулалт хангалттай гэж үзсэн</i></p>
<p><b>25</b></p>	<p><b>77 дугаар зүйл. Төлөөлөн удирдах зөвлөлийг сонгох, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох</b></p> <p>77.2. Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа дараа жилийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах өдрөөр дуусгавар болох бөгөөд төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг улируулан сонгож болно.</p>	<p><b>Дүрмийн 11.4 дүгээр заалт</b></p> <p>11.4 ТУЗ-ийн гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн хурлаас 2 (хоёр) жилийн хугацаагаар сонгож томилох ба бүрэн эрхийн хугацаа дууссаны дараа улираан сонгож болно.</p> <p><i>Тайлбар: ТУЗ-ийн гишүүнийг мэргэшүүлэх, тогтвортой ажиллуулах зорилгоор 2 жилийн хугацаатай томилохоор тусгасан.</i></p>
<p><b>26</b></p>	<p><b>77 дугаар зүйл. Төлөөлөн удирдах зөвлөлийг сонгох, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох</b></p> <p>77.5. Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол удаан хугацаагаар үүргээ хэрэгжүүлэх боломжгүй болсон, чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан, эсхүл нас барсан төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг орлох этгээдийг нөхөн сонгууль хүртэл төлөөлөн</p>	<p><b>Дүрэмд өөрөөр заагаагүй</b></p> <p><i>Тайлбар: Компанийн тухай хуулийн зохицуулалт хангалттай гэж үзсэн</i></p>

	удирдах зөвлөл түр томилж болно.	
27	<b>78 дугаар зүйл. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга</b>  78.1. Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн дотроос нийт гишүүний олонхийн саналаар сонгоно.	<b>Дүрэмд өөрөөр заагаагүй</b>  <i>Тайлбар: Компанийн тухай хуулийн зохицуулалт хангалттай гэж үзсэн</i>
28	<b>78 дугаар зүйл. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга</b>  78.2. Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулж, түүний хурлыг хуралдуулах, хурал даргалах, хурлын тэмдэглэлийг хөтлүүлэх, хяналт тавих үүргийг гүйцэтгэнэ.	<b>Дүрэмд өөрөөр заагаагүй</b>  <i>Тайлбар: Компанийн тухай хуулийн зохицуулалт хангалттай гэж үзсэн</i>
29	<b>80 дугаар зүйл. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал</b>  80.1. Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг сард нэг удаа хуралдуулах бөгөөд шаардлагатай гэж үзвэл нэмэлт хурал хийж болно.	<b>Дүрэмд өөрөөр заагаагүй</b>  <i>Тайлбар: Компанийн тухай хуулийн зохицуулалт хангалттай гэж үзсэн</i>
30	<b>83 дугаар зүйл. Гүйцэтгэх удирдлага</b>  83.5. Хууль болон компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөл (байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал) зөвшөөрсөн тохиолдолд гүйцэтгэх захирал, эсхүл гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлэгч багийн гишүүн нь өөр компани, аж ахуйн нэгжийн удирдлагад давхар ажиллаж болно.	<b>Дүрэмд өөрөөр заагаагүй</b>  <i>Тайлбар: Компанийн тухай хуулийн зохицуулалт хангалттай гэж үзсэн</i>
31	<b>94 дүгээр зүйл. Компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд тавих аудиторын хяналт</b>  94.1. Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол компани санхүүгийн	<b>Дүрэмд өөрөөр заагаагүй</b>  <i>Тайлбар: Компанийн тухай хуулийн</i>

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЙЛАН

<p>тайлангаа шалгуулж баталгаажуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаандаа бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийлгэх зорилгоор гэрээний үндсэн дээр аудитын байгууллагыг томилон ажиллуулж болно.</p>	<p><i>зохицуулалт хангалттай гэж үзсэн</i></p>
--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	------------------------------------------------

**Хавсралт 6. Хууль тогтоомжтой зөрчилдөөгүй зохицуулалтууд**

<b>Д/Д</b>	<b>Компанийн тухай хуулийн заалт</b>	<b>Дүрэмд тусгасан хувилбар, тайлбар</b>
<p><b>1</b></p>	<p><b>16 дүгээр зүйл. Компанийн дүрэм</b></p> <p>16.3. Компанийн дүрэмд Иргэний хууль болон бусад хууль тогтоомжтой зөрчилдөөгүй зүйлийг тусгаж болно.</p>	<p><b>3 дугаар бүлэг</b></p> <p>3.6 Компани нь Монгол Улсад болон гадаад улсад өөрийн салбар, төлөөлөгчийн газартай байж болно. Компанийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу салбар, төлөөлөгчийн газраа байгуулан, бүртгэх байгууллагад бүртгүүлж, үйл ажиллагаагаа явуулна.</p> <p>3.7 Компанийн хувьцаа эзэмшигчдийн тархалт, байршлыг харгалзан Говь-Алтай аймгийн баг тус бүрт Компанийн төлөөлөгчийг ажиллуулна. Төлөөлөгчийн үүргийг Компанийн хувьцаа эзэмшигч, тухайн багийн аль нэг иргэн хариуцан гүйцэтгэнэ.</p> <p><b>5 дугаар бүлэг</b></p> <p>5.7 Компани нь гүйцэтгэх удирдлагын буюу менежментийн багийн ажлын үр дүнг урамшуулах, компанийн бүтээмжийг сайжруулах зорилгоор тодорхой нөхцөл бүхий опцион гаргаж болно.</p> <p><b>14 дүгээр бүлэг</b></p> <p>14.3 Гүйцэтгэх захирал дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ. Дор дурдсанаас бусад асуудлыг ТУЗ шийдвэрлэнэ. Үүнд:</p> <p>14.3.6 Говь-Алтай аймгийн баг бүрт Компанийн төлөөлөгчийг томилох, чөлөөлөх,</p>

**Хавсралт 7. Хувьцаа худалдах худалдан авах гэрээний төсөл**

[.....] ХХК  
(Компани)  
БОЛОН  
[.....]  
(Худалдан авагч)

**ХУВЬЦАА ХУДАЛДАХ, ХУДАЛДАХ АВАХ ГЭРЭЭ**

2023 оны ... дугаар сарын ...-ны өдөр  
Есөнбулаг сум

### **ХУВЬЦАА ХУДАЛДАХ, ХУДАЛДАХ АВАХ ГЭРЭЭ**

Энэхүү Хувьцаа худалдах, худалдан авах гэрээ (цаашид "Гэрээ" гэнэ)-г 2023 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Нэг талаас [.....] тоот хаягт байрлах [.....] ХХК, түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал [..... овогтой .....] (цаашид "Компани" гэх),

Нөгөө талаас [.....] тоот хаягт оршин суух [..... овогтой .....] (цаашид "Худалдан авагч" гэх) нар (цаашид хамтад нь "Талууд" гэх) дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

#### **Нэг. Нэр томъёоны тодорхойлолт**

Гэрээнд орсон дор дурдсан нэр томъёог дараах утгаар ойлгоно. Үүнд:

- 1.1. "Компани" гэж Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан, [.....] улсын бүртгэлийн дугаартай, [.....] регистрийн дугаартай [.....] ХХК-ийг,
- 1.2. "Менежментийн баг" гэж Компанийн Гүйцэтгэх захирлаар томилогдсон этгээд болон түүний бүрдүүлсэн Компанийн Гүйцэтгэх удирдлагын багийг,
- 1.3. "Хувьцаа" гэж нэг бүр нь 1000 төгрөгийн үнэтэй [.....] ширхэг энгийн хувьцааг,
- 1.4. "Опцион гэрээ" гэж энэхүү Гэрээний 1.3-д заасан Хувьцааг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.10 дахь хэсэгт заасны дагуу тодорхой тоо хэмжээ, хугацаа, үнийн нөхцөлөөр Менежментийн багт эзэмшүүлэхээр байгуулсан гэрээг,
- 1.5. "Хавсралтууд" гэж энэхүү гэрээний салшгүй хэсэг болох № 1, 2, 3, 4, 5 дугаар хавсралтуудыг.

#### **Хоёр. Нийтлэг үндэслэл**

- 2.1. Гэрээний зорилго нь Компани нь Хувьцааг Худалдан авагчид шилжүүлэх, Худалдан авагч нь Хувьцааны үнийг Компанид төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

#### **Гурав. Хувьцааг шилжүүлэх**

- 3.1. Компанийн хувьцаа эзэмшигчийн өөрчлөлтийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлснээр Хувьцааны өмчлөх эрх Компаниас Худалдан авагчид шилжинэ.
- 3.2. Гэрээний 4.2-т заасны дагуу Хувьцааны үнийг бүрэн төлсөн өдрөөс хойш ажлын 20 (хорин) өдрийн дотор Компани зохих баримт бичгийг бүрдүүлэн хувьцаа эзэмшигчийн өөрчлөлтийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт бүртгүүлнэ.
- 3.3. Гэрээ нь энэ зүйлийн 3.2-т заасны дагуу бүртгэгдсэнээр хүчин төгөлдөр болно.

#### **Дөрөв. Хувьцааны үнэ, түүнийг төлөх хэлбэр**

- 4.1. Хувьцааны үнэ нь нийт [.....] төгрөг байхаар Гэрээний талууд харилцан тохиролцов.

- 4.2. Худалдан авагч нь Гэрээ болон Хавсралтуудад гарын үсэг зурмагц Хувьцааны үнэ болох нийт [.....] төгрөгийг [.....] банк дахь Компанийн [.....] тоот дансанд шилжүүлнэ.
- 4.3. Худалдан авагч нь Гэрээ болон Хавсралтуудад гарын үсэг зурснаас хойш хуанлийн ... хоногийн дотор Хувьцааны үнийн төлбөрт ..... ширхэг/килограмм [.....]-ийг Компанид хүлээлгэн өгч бараа хүлээлцсэн акт үйлдэнэ.

**Тав. Талуудын нийтлэг эрх, үүрэг**

- 5.1. Гэрээний Талууд дараах нийтлэг үүрэг хүлээнэ. Үүнд:
- 5.1.1. Гэрээний үүргээ шударгаар, сайн дураар, биечлэн гүйцэтгэх ба нөгөө талын зөвшөөрөлгүйгээр Гэрээний эрх, үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй байх;
- 5.1.2. Гэрээний дагуу хувьцаа эзэмшигчийн өөрчлөлтийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт бүртгүүлэх талаар өөрөөс хамаарах бүхий л арга хэмжээг даруй авах;
- 5.1.3. Гэрээг байгуулахтай холбогдон өөрийн зүгээс гарсан аливаа зардлыг өөрсдөө хариуцах;
- 5.1.4. Гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдон гарч болох албан татвар төлөх асуудлыг хуулийн дагуу өөрсдөө тус тусдаа хариуцах.

**Зургаа. Худалдан авагчийн эрх, үүрэг**

- 6.1. Худалдан авагч дор дурдсан эрх, үүрэгтэй. Үүнд:
- 6.1.1. Энэ гэрээний 7.1.2-т заасан хугацаа өнгөрснөөс хойш Худалдан авагч Хувьцаагаа худалдах эрхтэй.
- 6.1.2. Энэ зүйлийн 6.1.1-т заасны дагуу Худалдан авагч хувьцаагаа худалдах тохиолдолд Хувьцаа худалдах саналаа Компанид бичгээр мэдэгдэж, уг саналыг тэргүүн ээлжинд бусад хувьцаа эзэмшигчдэд гаргах үүрэг хүлээнэ. Худалдан авагч энэхүү үүргээ баталгаажуулж Хавсралт №1-т гарын үсэг зурна.
- 6.1.3. Худалдан авагч нь Хувьцааны тоо, төрөл, Хувьцааны үнэ зэрэг энэхүү гэрээг байгуулах явцад олж мэдсэн Компани болон Хувьцаа талаар холбогдох бүхий л мэдээ, мэдээлэл, баримт бичгийн нууцыг чандлан хадгалах буюу энэ талаар гуравдагч этгээд, эсхүл нийтэд задруулахгүй байх үүрэгтэй.
- 6.1.4. Худалдан авагч Гэрээ, эсхүл бичмэл нотолгоог зөрчиж мэдээллийг задруулсан, тараасан, ашигласнаас үүссэн үр дагаврыг хариуцан арилгах үүрэгтэй.
- 6.2. Энэ зүйлийн 6.1.3, 6.1.4-т заасан үүрэг нь энэхүү гэрээ хүчин төгөлдөр байх хугацаанд болон гэрээ дуусгавар болсноос хойш 3 жилийн хугацаанд хүчинтэй хэвээр байна.

**Долоо. Худалдан авагчийн татгалзал**

- 7.1. Энэхүү гэрээнд гарын үсэг зурснаар Худалдан авагч дараах эрхээсээ татгалзаж байна. Үүнд:
- 7.1.1. Стратегийн хөрөнгө оруулалт татах зорилгоор Компани шинээр энгийн болон давуу эрхийн хувьцаа гаргасан тохиолдолд тэдгээрийг тэргүүнд ээлжинд худалдан авах эрхээсээ татгалзаж байна. Худалдан авагч энэхүү татгалзлыг баталгаажуулж Хавсралт №2-т гарын үсэг зурна.
  - 7.1.2. Энэхүү гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш гурван жилийн хугацаанд эсвэл Компани хувьцаагаа олон нийтэд санал болгох хүртэл энэхүү гэрээгээр худалдаж авсан Хувьцаагаа бусдад худалдах эрхээсээ татгалзаж байна. Худалдан авагч энэхүү татгалзлыг баталгаажуулж Хавсралт №3-т гарын үсэг зурна.
  - 7.1.3. Менежментийн багт олгохоор гаргасан опционыг тэргүүн ээлжинд худалдан авах эрхээсээ татгалзаж байна. Худалдан авагч энэхүү татгалзлыг баталгаажуулж Хавсралт №4-т гарын үсэг зурна.

**Найм. Гэрээ биелэгдэх урьдчилсан нөхцөл**

- 8.1. Компанийн энгийн хувьцааг худалдах, худалдан авах ажиллагаа энэ гэрээнд заасан нөхцөл, тохиролцооны дагуу хийгдэж биелэгдэнэ.
- 8.2. Гэрээ биелэгдэх урьдчилсан нөхцөл:
- 8.2.1. Компани дараах урьдчилсан нөхцөлийг хангасан байна. Үүнд:
    - I. Хэрэв энэ гэрээ биелэгдэхээс өмнө төрийн эрх бүхий байгууллагаас ямар нэгэн зөвшөөрөл авах шаардлагатай бол түүнийг авсан байх,
    - II. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар (i) энэ гэрээний 2.1-д заасан хувьцааг шинээр гаргасан тухай, (ii) энэ гэрээг байгуулах болон түүнийг дагалдан хийх баримт бичгийг гаргах этгээдэд эрх олгосон тухай, (iii) энэ гэрээг байгуулах эрх олгосон тухай, (iv) Компанийн дүрмийг шинээр баталсан тухай нотариатаар баталгаажуулсан хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолын хуулбар,
    - III. Худалдан авагчийн шаардсан бусад баримт бичиг, гэрчилгээний хуулбарыг гаргаж өгөх.
  - 8.2.2. Худалдан авагч дараах урьдчилсан нөхцөлийг хангасан байна:
    - I. Компанийн шаардсан бусад баримт бичиг, гэрчилгээний хуулбарыг гаргаж өгөх,
    - II. Энэхүү гэрээ болон Хавсралтуудыг хүлээн зөвшөөрч гарын үсэг зурсан байх.
    - III. Хувьцааны төлбөрийг бүрэн төлсөн байх, эд хөрөнгөөр төлөх тохиолдолд энэхүү гэрээний ххавсралт 5-ыг үйлдсэн байх.



### **Ес. Мэдэгдэл ба баталгаа**

9.1. Компани дараах байдлаар мэдэгдэл болон баталгааг гаргаж байна. Үүнд:

- 9.1.1. Компани нь Монгол Улсын хуулийн этгээд мөн.
- 9.1.2. Компани нь шинээр хувьцаа гаргах бүрэн эрхтэй бөгөөд энэ эрх нь ямарваа нэгэн шүүх болон төрийн байгууллагын шийдвэрээр хязгаарлагдаж, хориглогдоогүй болно.
- 9.1.3. Хувьцааг худалдахад ямар нэгэн гуравдагч этгээдийн зөвшөөрлийг авах шаардлагагүй болно.
- 9.1.4. Компани нь (i) энэ Гэрээнд заасан нөхцөлийн дагуу гэрээг байгуулах эрхтэй бөгөөд (ii) Гэрээ байгуулах бүх боломжит алхмыг хийсэн болно.
- 9.1.5. Компани эсхүл түүний төлөөлөгч нь энэхүү Гэрээг зохих журмын дагуу хийсэн бөгөөд энэ Гэрээгээр хүлээх түүний үүрэг нь хууль ёсны бөгөөд Компанид заавал биелүүлэх үүрэг хүлээлгэж байна.
- 9.1.6. Хувьцаа нь ямар нэгэн барьцаанд тавигдаагүй (энэхүү Гэрээний дагуу үүрэг хүлээснээс гадна), түүнийг барьцаа болгох ямар нэгэн гэрээ, хэлцэл, болзол хийгдээгүй, энэ талаар Компани ямар нэгэн үйлдэл хийгээгүй болно.
- 9.1.7. Компанийг (i) дампууруулах ямар нэгэн нэхэмжлэл гараагүй, энэ асуудлаар ямар нэгэн хугацаа, тов зарлагдаагүй, (ii) дампуурсан хэмээн зарлаж байгаагүй, (iii) хөрөнгө мөнгө хангалтгүй гэсэн үндэслэлээр дампууруулах нэхэмжлэл буцаагдаж байгаагүй, (iv) дампуураагүй бөгөөд дампуурах ямар нэгэн аюул занал байхгүй;
- 9.1.8. Энэхүү Гэрээ, түүнд орсон зүйл заалт нь Компани болон Хувьцаанд хамааралтай ямар нэгэн хууль тогтоомж, шүүхийн шийдвэр, зөвшөөрөл, тушаал, шийдвэрийг зөрчөөгүй болно;

9.2. Худалдан авагч нь энэ зүйлийн 9.1-д заасан мэдэгдэл болон баталгаанд үндэслэн энэхүү Гэрээг байгуулсан болохыг Компани ойлгож байна. Энэхүү Гэрээг байгуулах үед гаргасан мэдэгдэл ба баталгаа нь үнэн зөв болохыг Компани нотолж байна.

### **Арав. Нэмэлт тохиролцоо**

- 10.1. Компани уг гэрээнд гарын үсэг зурснаас хойш энэхүү Гэрээ хүчин төгөлдөр болох хүртэл дараах үйлдэл хийхийг хориглоно. Үүнд:
  - 10.1.1. Баримт бичигт өөрчлөлт оруулах;
  - 10.1.2. Монгол улсын хууль тогтоомжинд шаардсанаас бусад тохиолдолд Компанийн санхүүгийн бүртгэлийн арга, тогтсон практикт өөрчлөлт оруулах;
  - 10.1.3. Компанийн өөрийн хөрөнгийг бууруулах эсхүл үрэгдүүлэх;
- 10.2. Худалдан авагч уг гэрээнд гарын үсэг зурснаас хойш энэхүү Гэрээ хүчин төгөлдөр болох хүртэл дараах үйлдэл хийхийг хориглоно. Үүнд:

10.2.1. Энэхүү Гэрээний 7.1-т заасныг зөрчиж татгалзсан эрхээ хэрэгжүүлэх;

**Арван нэг. Гэрээний хариуцлага**

- 11.1. Компани нь хувьцааг Худалдан авагчид шилжүүлэх, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт зохих ёсоор бүртгүүлэхээс санаатайгаар зайлсхийсэн, хожимдуулсан тохиолдолд ийнхүү хожимдуулсан хоног тутам, нийт үнийн дүнгийн 0.01 хувийн алдангийг Худалдан авагчид төлнө.
- 11.2. Худалдан авагч нь Хувьцааны үнийг хугацаандаа төлөөгүй тохиолдолд ийнхүү хожимдуулсан төлбөрийн үнийн дүнгээс 0.01 хувийн алдангийг хугацаа хожимдуулсан хоног тутам Компанид төлнө.
- 11.3. Компани нь энэ Гэрээнд хавсаргасан баримт, мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцах ба хэрэв эдгээр баримт, мэдээллийг санаатайгаар буруу, хуурамчаар гаргасан бол үүний улмаас өөрт учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр Худалдан авагч шаардах эрхтэй.

**Арван хоёр. Гэрээг цуцлах, дуусгавар болох**

- 12.1. Гэрээний дагуу Хувьцааны үнэ бүрэн төлөгдсөний дараа гэрээний аль нэг талын санаачилгаар гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах эрхгүй.
- 12.2. Гэрээний талууд гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж, Гэрээний 7.1.2-т заасан хугацаа дууссанаар Гэрээ дуусгавар болно.

**Арван гурав. Маргаан шийдвэрлэх**

- 13.1. Гэрээний талууд нь гэрээг тайлбарлах, гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдон тэдний хооронд гарсан аливаа маргааныг харилцан бие биеээ хүндэтгэн, эв зүйгээр хэлэлцэн тохиролцож шийдвэрлэхийг эрмэлзэнэ.
- 13.2. Хэрэв Гэрээний талууд хэлэлцэн тохиролцож чадаагүй тохиолдолд энэхүү гэрээнээс үүссэн болон холбогдон гарсан түүнчлэн уг гэрээг зөрчих, дуусгавар болгох, хүчингүй болгохтой холбоотой бүх маргааныг Монгол улсын хуулийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 13.3. Маргааныг ийнхүү шүүхээр шийдвэрлүүлэх, шүүхийн шийдвэрийг гүйцэтгүүлэхтэй холбогдон гарсан аливаа зардлыг гэм буруутай тал хариуцан төлнө.
- 13.4. Гэрээнээс үүссэн маргааныг шийдвэрлэхдээ тэргүүн ээлжинд гэрээний зорилго, гэрээгээр тохиролцсон зүйлийг харгалзан үзнэ.

**Арван дөрөв. Бусад**

- 14.1. Гэрээний аль нэг зүйл заалт хүчин төгөлдөр бус болсон нь Гэрээг бүхэлд нь хүчин төгөлдөр бус болгох үндэслэл болохгүй.
- 14.2. Хэрэв энэхүү гэрээ нь хүчин төгөлдөр байх хуулийн шаардлагыг хангаагүй тохиолдол хожим илэрвэл тэрхүү шаардлагыг нөхөн хангахыг талууд бие биеээсээ шаардах эрхтэй.

14.3. Гэрээг монгол хэлээр 4 хувь үйлдэж, гэрээнд гарын үсэг зурсан этгээд бүрт тус бүр нэг хувийг, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт нэг хувийг, нотариатчид нэг хувийг тус тус хадгалуулах бөгөөд тэдгээр нь хууль зүйн хувьд ижил хүчинтэй байна.

Дор дурдсан талууд 2023 оны ... дугаар сарын ...-ны өдөр Есөнбулаг сумд энэхүү Гэрээг байгуулав.

**ГЭРЭЭНИЙ ТАЛУУД:**

Компанийг төлөөлж:  
Гүйцэтгэх захирал

\_\_\_\_\_  
(гарын үсэг)

[.....]

Худалдан авагч талыг төлөөлж:  
Иргэн

\_\_\_\_\_  
(гарын үсэг)

[.....]

2023 оны ...-р сарын ...-ны өдрийн  
Хувьцаа худалдах, худалдан авах  
гэрээний Хавсралт №1

### ХУДАЛДАН АВАГЧИЙН БАТАЛГАА

2023 оны ...-р сарын ...-ны өдөр

Есөнбулаг сум

Тус компанитай байгуулсан Хувьцаа худалдах, худалдан авах гэрээний дагуу нийт [.....] ширхэг энгийн хувьцааг худалдан авсан [.....] би Компани хувьцаат компанийн хэлбэрт шилжсэнээс бусад тохиолдолд Хувьцаагаа энэхүү гэрээний 7.1.2-т заасан хугацаа өнгөрснөөс хойш бүхэлд нь эсвэл хэсэгчлэн бусдад худалдах тохиолдолд энэ тухай саналаа Компанид бичгээр мэдэгдэнэ.  
Мөн түүнчлэн худалдан авсан Хувьцаагаа бүхэлд нь эсвэл хэсэгчлэн худалдах саналаа нэн тэргүүнд Компанийн бусад хувьцаа эзэмшигчдэд гаргахаа үүгээр баталж байна.

Хувьцаа эзэмшигч \_\_\_\_\_ [.....]

(гарын үсэг)

2023 оны ...-р сарын ...-ны өдрийн  
Хувьцаа худалдах, худалдан авах  
гэрээний Хавсралт №2

### ХУДАЛДАН АВАГЧИЙН ТАТГАЛЗАЛ

2023 оны ...-р сарын ...-ны өдөр

Есөнбулаг сум

Тус компанитай байгуулсан Хувьцаа худалдах, худалдан авах гэрээний дагуу нийт [.....] ширхэг энгийн хувьцааг худалдан авсан [.....] би, стратегийн хөрөнгө оруулалт татах зорилгоор Компани шинээр энгийн болон давуу эрхийн хувьцаа гаргасан тохиолдолд тэдгээрийг тэргүүнд ээлжинд худалдан авах эрхээсээ үүгээр татгалзаж байна.

Стратегийн хөрөнгө оруулалт татах зорилгоор Компани шинээр энгийн болон давуу эрхийн хувьцаа гаргасан тохиолдолд тэдгээрийг тэргүүнд ээлжинд худалдан авах эрхээсээ татгалзсантай холбоотойгоор Компани болон бусад Хувьцаа эзэмшигчдийн эсрэг аливаа шаардлага, нэхэмжлэл гаргахгүй, маргаан үүсгэхгүй болохоо үүгээр баталж байна.

Хувьцаа эзэмшигч \_\_\_\_\_ [.....]

(гарын үсэг)

2023 оны ...-р сарын ...-ны өдрийн  
Хувьцаа худалдах, худалдан авах  
гэрээний Хавсралт №3

### ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ТАТГАЛЗАЛ

2023 оны ...-р сарын ...-ны өдөр

Есөнбулаг сум

Тус компанитай байгуулсан Хувьцаа худалдах, худалдан авах гэрээний дагуу нийт [.....] ширхэг энгийн хувьцааг худалдан авсан [.....] би Хувьцаагаа нэг жилийн хугацаанд эсвэл Компани хувьцаагаа нийтэд санал болгох хүртэл бүхэлд нь эсвэл хэсэгчлэн худалдахгүй болохоо үүгээр баталж байна.

Гурван жилийн хугацаанд эсвэл Компани хувьцаагаа нийтэд санал болгох хүртэл өөрийн эзэмшлийн хувьцаагаа худалдахгүй байх татгалзал гаргасантай холбогдуулан Компани болон бусад Хувьцаа эзэмшигчдийн эсрэг аливаа шаардлага, нэхэмжлэл гаргахгүй, маргаан үүсгэхгүй болохоо үүгээр мэдэгдэж байна.

Хувьцаа эзэмшигч \_\_\_\_\_ [.....]

(гарын үсэг)

2023 оны ...-р сарын ...-ны өдрийн  
Хувьцаа худалдах, худалдан авах  
гэрээний Хавсралт №4

### ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ТАТГАЛЗАЛ

2023 оны ...-р сарын ...-ны өдөр

Есөнбулаг сум

Тус компанитай байгуулсан Хувьцаа худалдах, худалдан авах гэрээний дагуу нийт [.....] ширхэг энгийн хувьцааг худалдан авсан [.....] би Менежментийн багт олгохоор гаргасан опционыг тэргүүн ээлжинд худалдан авах эрхээсээ үүгээр татгалзаж байна.

Менежментийн багт олгохоор гаргасан опционыг тэргүүн ээлжинд худалдан авах эрхээсээ татгалзсантай холбогдуулан Компани болон бусад Хувьцаа эзэмшигчдийн эсрэг аливаа шаардлага, нэхэмжлэл гаргахгүй, маргаан үүсгэхгүй болохоо үүгээр мэдэгдэж байна.

Хувьцаа эзэмшигч \_\_\_\_\_ [.....]

(гарын үсэг)

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2023 оны ...-р сарын ...-ны өдрийн  
Хувьцаа худалдах, худалдан авах  
гэрээний Хавсралт №5

**БАРАА ХҮЛЭЭЛЦСЭН АКТ**

2023 оны ...-р сарын ...-ны өдөр

Есөнбулаг сум

Тус компанитай байгуулсан Хувьцаа худалдах, худалдан авах гэрээний дагуу нийт [.....]  
ширхэг/килограмм [.....]-ийг дараах хуваарийн дагуу шалгаж хүлээн авав.

	Нэр	Тоо ширхэг	Огноо	Тайлбар
1			2023/.../...	Чанарын доголдолгүй
2			2023/.../...	Чанарын доголдолгүй
	Нийт	24		

Компанийг төлөөлж:

.....

\_\_\_\_\_  
(гарын үсэг)

[.....]

Худалдан авагч талыг төлөөлж:

Иргэн

\_\_\_\_\_  
(гарын үсэг)

[.....]



**Хавсралт 8. ТУЗ-ийн үйл ажиллагааны журам**

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ  
АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ**

**Нэг. Ерөнхий зүйл**

- 1.1. Энэхүү журмын зорилго нь "[.....]" ХХК-ийн (цаашид "Компани" гэх) Төлөөлөн удирдах зөвлөлийн (цаашид "ТУЗ" гэх) бүрэн эрх, бүрэлдэхүүн, гишүүдэд тавих шаардлага, гишүүнд нэр дэвшүүлэх, сонгох, хугацаанаас өмнө чөлөөлөх, дарга, гишүүд, нарийн бичгийн даргын эрх үүрэг хариуцлага, ТУЗ-ийн хороодын чиг үүрэг, ТУЗ-ийн хуралд бэлдэх, хурал зарлах, хуралдуулахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

**Хоёр. ТУЗ-ийн бүрэн эрх**

- 2.1. Компанийн ТУЗ нь Компанийн тухай хууль, Компанийн дүрэмд зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:
  - 2.1.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын (цаашид "ХЭХ" гэх) зөвшөөрлөөр компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох, түүнд өөрчлөлт оруулах;
  - 2.1.2. Компанийн дунд хугацааны стратеги төлөвлөгөө, жил бүрийн бизнес төлөвлөгөө, төсвийг батлах;
  - 2.1.3. Компанийн гүйцэтгэх захирлыг томилох, өөрчлөх, түүнтэй байгуулах гэрээний нөхцөл, бүрэн эрх, шагнал урамшуулал, хариуцлагын хэмжээг тогтоох;
  - 2.1.4. Компанийн төлөөлөгчийн газар байгуулах, татан буулгах, шилжүүлэх, түүний үйл ажиллагааны дүрэм журмыг батлах, удирдлагыг томилох, бүрэн эрхийг тогтоох, түүнтэй байгуулах гэрээний нөхцөлийг батлах, төлөөлөгчийн газрын үйл ажиллагаанд дүгнэлт өгөх;
  - 2.1.5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах, эчнээ санал хураалт явуулах шийдвэр гаргах;
  - 2.1.6. Үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг улирал бүр тогтмол хэлэлцэж, шаардлагатай тохиолдолд цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар шийдвэр гаргах;
  - 2.1.7. Гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээний нөхцөлийг тодорхойлж, Гүйцэтгэх захирлыг сонгох талаар ТУЗ-ийн даргын саналыг хэлэлцэж, сонгох, гэрээ байгуулах эрх олгох;
  - 2.1.8. Хөндлөнгийн аудитын байгууллагыг томилох, уг байгууллагатай байгуулах гэрээний нөхцөлийг тодорхойлж, гэрээ байгуулах эрх олгох;

- 2.1.9. Компанийн санхүү, аж ахуйн үйл ажиллагаа, тодорхой төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн чиглэлээр аудитын шалгалт хийлгэх шийдвэр гаргах, аудиторыг томилох;
- 2.1.10. Компанийн эрх бүхий албан тушаалтнуудаас тодорхой асуудлаар мэдээлэл авах, тайлан, дүгнэлт гаргуулах, хэлэлцэх;
- 2.1.11. Эрх бүхий албан тушаалтны компанид учруулсан хохирлын талаар шүүхэд нэхэмжлэл гаргах шийдвэр гаргах, төлөөлөх этгээдийг томилох;
- 2.1.12. Компанийн ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар гүйцэтгэх захиралд эрх олгох;
- 2.1.13. Компанийн эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын тогтолцоог оновчтой зохион байгуулах, санхүүгийн үйл ажиллагаа, тодорхой төсөл, хөтөлбөрийн төсвийн гүйцэтгэлд мониторинг хийх тогтолцоо бүрдүүлэх;
- 2.1.14. Компанийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн үнэн зөв, бүрэн бүтэн байдлыг хангах, нягтлан бодох бүртгэл, аудитын олон улсын стандартыг нэвтрүүлэх ажиллагаанд хяналт тавих;
- 2.1.15. Компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавих;
- 2.1.16. Бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичгийг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;
- 2.1.17. Хувьцаа эзэмшигчдийн зүгээс Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хэт нөлөөлөхгүй байх зарчмыг мөрдүүлэх;
- 2.1.18. Бизнес төлөвлөгөө, бусад шийдвэрийн хэм хэмжээг тасралтгүй дагаж мөрдүүлэх, компани төлбөрийн чадваргүй болохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;
- 2.1.19. Компанийн тухай хуулийн 81.2-т заасан аудитын, цалин урамшууллын, нэр дэвшүүлэх хороодыг байгуулан, чиг үүргийг хэрэгжүүлэх;
- 2.1.20. Гүйцэтгэх удирдлага чиг үүргээ зохих ёсоор хэрэгжүүлж чадахгүй байна гэж дүгнэсэн бол ажлаас нь чөлөөлөх, шинэ удирдлагыг сонгох арга хэмжээ авна.

#### **Гурав. ТУЗ-ийн бүрэлдэхүүн, гишүүдэд тавих шаардлага**

- 3.1. Компанийн дүрэмд заасны дагуу компанийн ТУЗ нь 5 гишүүнтэй, бүрэн эрхийн хугацаа нь 3 жил байна. ТУЗ-ийн гишүүдийн 3-аас доошгүй нь хараат бус гишүүн байна.
- 3.2. ТУЗ-ийн ердийн гишүүн дараах шаардлага, шалгуурыг хангасан байна. Үүнд:
  - 3.2.1. Зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хугацаа хэтэрсэн аливаа өргүй;

- 3.2.2. Ял шийтгэл хүлээж байгаагүй;
- 3.2.3. Ёс зүйн болон ажил хэргийн нэр хүнд нь компанийг удирдахад харшлахгүй;
- 3.2.4. Дээд боловсролтой;
- 3.2.5. Дампуурсан, төлбөрийн чадваргүй болсон хуулийн этгээдийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан байгаагүй;
- 3.2.6. Өмнө нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуулиар тогтоосон хугацаанд хуралдуулаагүйгээс бүрэн эрх нь дуусгавар болсон компанийн ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх захирал байгаагүй;
- 3.3. ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигч нь энэ журмын 3.2-т зааснаас гадна дараах шалгуур, шаардлагыг хангасан байна. Үүнд:
  - 3.3.1. Өөрөө эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь компанийн хувьцаа эзэмшдэггүй;
  - 3.3.2. Компанийн ТУЗ-ийн бусад гишүүн, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтны нэгдмэл сонирхолтой этгээд биш;
  - 3.3.3. Санхүү, эдийн засаг, инженер, хууль эрх зүйн аль нэг чиглэлээр мэргэшсэн;
  - 3.3.4. Өөрөө болон нэгдмэл сонирхолтой этгээд нь улс төрийн намын удирдах албан тушаал хашдаггүй;
  - 3.3.5. Компанитай бизнесийн аливаа холбоогүй.
- 3.4. Компанийн ТУЗ-д сонгогдсон хүмүүс дахин хэдэн удаа ч нэр дэвшин сонгогдож болно.
- 3.5. Компанийн ТУЗ-д 6-аас дээш жил ажилласан хүнийг хараат бус гэж үзэхгүй.
- 3.6. Эдийн засгийн гэмт хэрэг үйлдсэн, бизнес, санхүү, татвар, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаатай холбоотой зөрчил гаргаж, захиргааны шийтгэл хүлээсэн этгээдийг ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэхгүй.
- 3.7. ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар ажиллаж байгаа хүнийг ТУЗ-ийн гишүүнээр сонгохгүй.

#### **Дөрөв. ТУЗ-ийн бүрэн эрхийн хугацаа**

- 4.1. ТУЗ-ийн бүрэн эрхийн хугацаа 3 жил байна.
- 4.2. Жил бүрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг заавал хэлэлцэнэ.
- 4.3. ТУЗ-ийн сонгууль явуулах хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн гишүүн нэг бүрийн үйл ажиллагаанд энэ журмын дагуу үнэлэлт дүгнэлт өгөх бөгөөд энэ дүгнэлтээр "хангалтгүй" үнэлгээ авсан гишүүнийг ТУЗ-д дахин нэр дэвшүүлэхгүй.

- 4.4. Жил бүрийн ТУЗ-ийн үйл ажиллагааны дүгнэлтээр “хангалтгүй” үнэлгээ авсан, Компанийн дүрэм болон энэ журмаар тогтоосон үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, ТУЗ-ийн гишүүнийг чөлөөлөх шийдвэрийг ТУЗ-ийн дарга гаргаж болно.
- 4.5. ТУЗ-өөс чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан, чөлөөлөгдсөн, нас барсан зэргээр ТУЗ-ийн гишүүний орон тоо гарсан бол ТУЗ-ийн даргын саналаар хувьцаа эзэмшигчдийн хурал хүртэл ТУЗ-ийн гишүүнийг түр томилно.

#### **Тав. ТУЗ-ийн хороодын чиг үүрэг**

- 5.1. Энэхүү журмын 2.1.19-д заасан бүрэн эрхийн дагуу ТУЗ-ийн Аудитын хороо дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
  - 5.1.1. Дотоод хяналтын тогтолцоог сайжруулах, санхүүгийн тайлагналын үнэн зөв ил тод байдлыг хангуулах, аудитын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах;
  - 5.1.2. Хөндлөнгийн аудиторыг сонгох, хөндлөнгийн аудиторыг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах;
- 5.2. Энэхүү журмын 2.1.19-д заасан бүрэн эрхийн дагуу ТУЗ-ийн Цалин урамшууллын хороо дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
  - 5.2.1. Компанийн эрх бүхий албан тушаалтны цалин урамшууллын бодлогыг тухайн ажилтны ажил үүргийн хуваарьт заасан ажлын гүйцэтгэл, хэрэгжилт болон бүтээмжтэй уялдуулан боловсруулах;
  - 5.2.2. Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ компанийн эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлд тохирсон шударга, ил тод байх боломжийг хангах;
- 5.3. Энэхүү журмын 2.1.19-д заасан бүрэн эрхийн дагуу ТУЗ-ийн Нэр дэвшүүлэх хороо дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
  - 5.3.1. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчийг бүртгэх, энэхүү журмаар тогтоосон шаардлагыг хангаж байгаа эсэхийг хянах, нэр дэвшигчийг жагсаалтад бүртгэх эсэхийг шийдвэрлэх асуудлыг хариуцан хэрэгжүүлэх;
  - 5.3.2. Компанийн нийт хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшигч компанийн ТУЗ-ийн гишүүнд өөрийгөө болон шаардлага хангасан гэж үзсэн бусад этгээдийг нэр дэвшүүлэх;
  - 5.3.3. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчийг дараах журмаар бүртгэнэ:
    - 5.3.3.1. Эрх бүхий этгээдээс ирүүлсэн нэр дэвшүүлэх санал, хавсаргасан баримтуудыг ТУЗ-ийн нарийн дарга хүлээн авч, бүрдлийг шалгаад ТУЗ-ийн гишүүдэд танилцуулна.

5.3.3.2. ТУЗ-ийн хурлаар нэр дэвшигч бүрийн асуудлыг хэлэлцэж, гишүүдийн олонхийн саналаар нэр дэвшигчийг бүртгэх эсэх тухай шийдвэр гаргана.

5.3.4. ТУЗ-ийн гишүүдийг санал хураах энгийн аргаар сонгоно.

### **Зургаа. ТУЗ-ийн гишүүдийн үүрэг хариуцлага**

- 6.1. ТУЗ-ийн гишүүн нь энэхүү журам болон “Компанийн дүрэм”-ээр тогтоосон үүргийг хэрэгжүүлэх талаар дээд зэргийн хүчин чармайлт гаргаж ажиллана.
- 6.2. ТУЗ-ийн хуралдаанд биеэр эсвэл хэлэлцэх асуудал бүрт тодорхой санал тайлбартай бичгээр саналаа өгөх замаар оролцоно.
- 6.3. ТУЗ-ийн гишүүн нь өөрийн цахим шуудангийн хаягийг ТУЗ-ийн нарийн бичгийн даргад албан ёсоор мэдэгдэж, хүргүүлсэн мэдээллийг хаягаараа тогтмол хүлээн авч, хариу өгнө.
- 6.4. ТУЗ-ийн гишүүд сонирхлын зөрчлийг зохицуулах талаар хуулиар хүлээсэн үүргээ дараах байдлаар хэрэгжүүлнэ. Үүнд:
  - 6.4.1. Компанийн үйл ажиллагааны явцад хийж буй гэрээ хэлцэлд өөрөө болон нэгдмэл сонирхолтой этгээд нь хэлцлийн нөгөө тал болж байгаа, төлөөлөгч, зуучлагчаар оролцож байгаа бол энэ тухайгаа ТУЗ-д мэдэгдэн уг хэлцлийг хийх тухай шийдвэр гаргахад оролцохгүй.
  - 6.4.2. Тухайн асуудлаар сонирхлын зөрчилтэй болох тухайгаа болон сонирхлын зөрчил үүсч буй шалтгаанаа ТУЗ-ийн даргад бичгээр мэдэгдэнэ.
  - 6.4.3. Сонирхлын зөрчилтэй асуудлаа шийдвэрлүүлэх зорилгоор бусад гишүүдэд нөлөөлөхийг хориглоно.
  - 6.4.4. ТУЗ-ийн гишүүний хувьд гаргасан шийдвэр, үйл ажиллагааны төлөө аливаа этгээдээс ямар нэг шагнал, шагналд тооцогдохоор үйлчилгээ, урамшуулал, хөнгөлөлт авахгүй.
  - 6.4.5. Гишүүний хувьд олж мэдсэн нууц, дотоод болон албан мэдээллийг ажиллах хугацаандаа болон өөрчлөгдсөнөөс хойш 5 жилийн хугацаанд ашиг олох зорилгоор ашиглахгүй, бусдад задруулахгүй.
  - 6.4.6. Компанийн нууц болон дотоод мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллана.
- 6.5. ТУЗ-ийн хараат бус гишүүд хараат бус байдалд нь нөлөөлөх аливаа үйл ажиллагаанаас татгалзана. Нөхцөл байдал өөрчлөгдсөний улмаас хараат бус байх шалгуурыг хангахаа больсон бол энэ тухай ТУЗ-д мэдэгдэнэ.
- 6.6. Өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэх явцад олж тогтоосон хууль болон Компанийн дүрэм, энэ журмаар тогтоосон хэм хэмжээ зөрчигдөж болохуйц нөхцөл байдал үүссэнээс компанийн бизнест эрсдэл учруулж болно гэж үзсэн бол

энэ тухайгаа ТУЗ-д мэдэгдэх бөгөөд үүний шалтгаан, арилгах талаар арга хэмжээ авах саналаа тусгасан байна.

- 6.7. Энэ журмын 6.4-д заасныг зөрчсөнөөс компанид хохирол учруулсан бол өөрийн хөрөнгөөр нөхөн төлөх үүрэгтэй.
- 6.8. ТУЗ-ийн нийт хуралдааны 30-аас дээш хувьд нь аль нэг хэлбэрээр оролцож чадаагүй бол уг гишүүнийг ТУЗ-д дахин нэр дэвшүүлэхийг хориглоно.
- 6.9. ТУЗ-ийн гишүүн шийдвэр гаргахдаа холбогдох мэдээллийг бүрэн хүлээн авч, сайтар судалсан байх үүрэгтэй.
- 6.10. ТУЗ-ийн гишүүдэд мэдээлэл хүргэх асуудлыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хариуцах бөгөөд ТУЗ-ийн дарга хяналт тавина.

#### **Долоо. ТУЗ-ийн хараат бус гишүүдийн үүрэг хариуцлага**

- 7.1. ТУЗ-ийн хараат бус гишүүд нь энэ журмын 6 дугаар бүлэгт зааснаас гадна дараах чиг үүрэгтэй байна. Үүнд:
  - 7.1.1. ТУЗ-ийн болон гүйцэтгэх удирдлагын гаргаж буй шийдвэр, ялангуяа их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх тухай шийдвэр нь компанийн ашиг сонирхол болон хууль тогтоомж дүрэм журамд нийцэж байгаа эсэхэд хяналт тавих, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх;
  - 7.1.2. Гүйцэтгэх удирдлага нь хувьцаа эзэмшигчид болон бусад эрх бүхий сонирхогч талуудыг мэдээллээр хангах үүргээ хэрхэн хэрэгжүүлж байгаад хяналт тавих;
  - 7.1.3. Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын зохистой тогтолцоо бүрдсэн эсэхэд хяналт тавих;
  - 7.1.4. ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын шийдвэр компанийн эрх ашигт сөргөөр нөлөөлөхөөр байна гэж үзвэл энэ талаар бичгээр дүгнэлт хүргүүлэх, дүгнэлтийн талаар үндэслэл бүхий тайлбар ирүүлээгүй, ирүүлсэн ч тайлбар, үндэслэл нь бодит байдалд нийцэхгүй гэж үзвэл залруулахыг шаардах;
  - 7.1.5. ТУЗ-ийн хараат бус гишүүн нь Компанийн тухай хуулийн 61 дүгээр зүйлд заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулахыг шаардах, ТУЗ уг шаардлагыг үндэслэлгүйгээр хүлээн аваагүй тохиолдолд өөрсдөө хурал зарлан хуралдуулах;
- 7.2. ТУЗ-ийн хараат бус гишүүн нь хувьцаа эзэмшигчдийг мэдээллээр хэрхэн хангаж байгаа, Компанийн засаглалын кодекст заасан мэдээллийг хэрхэн хүргэж байгаад хяналт тавих үүрэгтэй.
- 7.3. ТУЗ-ийн хараат бус гишүүн нь компанийн үйл ажиллагааны ил тод байдлыг ханган ажиллаагүй эрх бүхий албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх болон

цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх саналаа ТУЗ-д оруулан хэлэлцүүлнэ.

**Найм. ТУЗ-ийн гишүүдийн үйл ажиллагаанд дүгнэлт өгөх**

- 8.1. ТУЗ-ийн гишүүдийн үйл ажиллагаанд Хувьцаа эзэмшигчдийн хурал (ХЭХ) дүгнэлт өгнө.
- 8.2. ХЭХ нь ТУЗ-ийн гишүүний хувьд ТУЗ-ийн хурал болон ТУЗ-өөс урилга хүргүүлсэн хурал, зөвлөгөөн, семинарт оролцсон байдал, ТУЗ-өөс болон ХЭХ-аас өгсөн үүрэг даалгаврыг хэрхэн биелүүлсэн зэрэг үзүүлэлтийг харгалзан дүгнэлт өгнө.
- 8.3. ТУЗ-ийн гишүүн бүрээр ТУЗ-ийн нарийн бичгийн даргын гаргаж өгсөн бүртгэл, ТУЗ-ийн даргын тодорхойлолтыг үндэслэн гаргасан дүгнэлтийг жил бүрийн ХЭХ-д танилцуулж байна.
- 8.4. ТУЗ-ийн гишүүнд “хангалтгүй ажилласан” гэсэн дүгнэлт өгсөн бол үндэслэлээ бичгээр тайлбарласан байх бөгөөд тухайн гишүүний тайлбарыг авсан байна.
- 8.5. “Хангалтгүй” гэсэн үнэлэлт авсан гишүүний нэрийг дахин ТУЗ-д дэвшүүлэхгүй байх тухай болон “хангалтгүй” үнэлэлт авсан үндэслэлийг тайлбарласан албан тоотыг тухайн гишүүнд хүргүүлнэ.

**Ес. ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үүрэг, хариуцлага**

- 9.1. Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь Компанийн засаглалын асуудлыг хариуцна.
- 9.2. Нарийн бичгийн даргыг компанийн ТУЗ-ийн даргын санал болгосноор ТУЗ-ийн нийт гишүүдийн олонхийн саналаар томилно.
- 9.3. Нарийн бичгийн даргад нэр дэвшигч дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
  - 9.3.1. Дээд боловсролтой;
  - 9.3.2. Санхүү, эдийн засаг, хууль эрх зүйн чиглэлээр 1-ээс доошгүй жил ажилласан туршлага болон мэргэжлийн ур чадвартай байх;
  - 9.3.3. Дээрх чиглэлээр бакалавраас доошгүй зэрэгтэй байх.
- 9.4. Нарийн бичгийн даргатай хийх хөдөлмөрийн гэрээний нөхцөлийг ТУЗ батлах бөгөөд ТУЗ-ийг төлөөлж, ТУЗ-ийн дарга гарын үсэг зурна.
- 9.5. ТУЗ-ийн дарга нь нарийн бичгийн даргын эзгүйд түүнийг орлох этгээдийг томилно.

- 9.6. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөний болон гүйцэтгэлийн тайлангийн төсөл бэлдэхээс гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:
- 9.6.1. ТУЗ-д засаглалын асуудлаар зөвлөгөө, мэдээлэл өгөх;
- 9.6.2. Бодлогын баримт бичиг, дотоод журмын хэрэгжилтэд хяналт тавих;
- 9.6.3. ТУЗ-ийн бичиг хэрэг, хуралдааны тэмдэглэл хөтлөх;
- 9.6.4. ТУЗ-ийн хурал, гишүүдийн сургалтыг тогтмол зохион байгуулах.
- 9.7. Нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг үр дүнтэй явуулах асуудлаар ТУЗ-ийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.

**Арав. ТУЗ-ийн даргын эрх, үүрэг, хариуцлага**

- 10.1. ТУЗ-ийн дарга нь дараах эрх, үүрэгтэй байна:
- 10.1.1. Компанийн үйл ажиллагаанд анхаарал хандуулан ажиллах;
- 10.1.2. ТУЗ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах ажиллагааг чиглэл удирдамжаар хангаж, төлөвлөгөөнд компанийг стратегийн удирдлагаар хангах, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын зохистой тогтолцоо бүрдүүлэхтэй холбоотой чухал асуудал бүрэн тусгагдсан эсэхийг хянаж, шаардлагатай тохиолдолд төлөвлөгөөнд нэмэлт оруулах санал боловсруулах, ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланд төлөвлөгөөний биелэлтийг бүрэн тусгах, төлөвлөгөө, тайланг ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлж, батлуулах;
- 10.1.3. ТУЗ-ийн өөрийн үйл ажиллагааны тайлан болон гишүүдийн ажлын үр дүнг хэлэлцэн батлахад шийдвэрлэх санал гаргах, өөрөөр хэлбэл гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд ТУЗ-ийн даргын саналаар шийдвэрлэх;
- 10.1.4. ТУЗ-ийн хурлыг төлөвлөгөөнд тусгагдсан цаг тухайд нь хуралдуулах, бэлтгэлийг бүрэн хангуулах, гишүүдийг мэдээллээр хангах, удирдах, хурлын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах;
- 10.1.5. ТУЗ-ийн гишүүдийг компанийн засаглалын талаар сургалт семинарт оролцуулах, хэлэлцүүлэг зохион байгуулах зэргээр компанийн сайн засаглалын зарчмуудын талаар сайн мэдлэг, мэдээлэлтэй болгох, ТУЗ-ийн ажиллагаанд гишүүдийн үр дүнтэй оролцоог хангахад анхаарал хандуулан ажиллах;
- 10.1.6. ТУЗ-ийн үйл ажиллагааны үр дүн, төлөвлөгөөний биелэлтийг хариуцах;
- 10.2. ТУЗ-ийн дарга нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуулиар тогтоосон хугацаанд бүрэн бэлтгэлтэй хуралдуулж, жилийн үйл ажиллагааны тайланг хэлэлцүүлэх, гарсан шийдвэрийн хэрэгжилтийг хангах асуудлыг зохион байгуулж, хянах үүрэг хүлээнэ.



**Арваннэг. ТУЗ-ийн хурал**

- 11.1. ТУЗ-ийн хурлыг улиралд нэгээс доошгүй удаа хуралдуулна.
- 11.2. ТУЗ-ийн ээлжит хурлын тов, хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээллийг ТУЗ-ийн гишүүн бүрт хурал хуралдахаас 2-оос доошгүй хоногийн өмнө хүргүүлнэ.
- 11.3. Шаардлагатай тохиолдолд ТУЗ-ийн ээлжит бус хуралдааныг дор дурьсан этгээдийн санал, шаардлагаар хэдийд ч зарлан хуралдуулж болно.
  - 11.3.1. ТУЗ-ийн дарга;
  - 11.3.2. ТУЗ-ийн аль нэг гишүүн;
  - 11.3.3. Гүйцэтгэх захирал;
  - 11.3.4. Дотоод хяналтын асуудал хариуцсан албан тушаалтан;
  - 11.3.5. Санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргасан хөндлөнгийн аудитын байгууллага.
- 11.4. 11.3-т заасан этгээд ТУЗ-ийн хурал хуралдуулах саналыг ТУЗ-ийн гишүүдэд бичгээр эсхүл цахим шуудангаар хүргүүлнэ.
- 11.5. Хурал хуралдуулах саналд дараах асуудлыг тусгана:
  - 11.5.1. Хурлаар хэлэлцүүлэхээр санал гаргаж буй хүний нэр, албан тушаал;
  - 11.5.2. Хэлэлцүүлэхээр санал болгож буй асуудал, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээлэл, өөрт нь байгаа мэдээлэл шийдвэр гаргахад хангалттай бус гэж үзэж байгаа бол ямар мэдээллийг хэрхэн толилуулах талаарх санал.
- 11.6. Хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 10 хоногоос хэтрэхгүй хугацаанд ТУЗ-ийн дарга хурлыг зарлан хуралдуулна.
- 11.7. Хуралд ТУЗ-ийн гишүүдийн 2/3 нь биеэр, саналын хуудсаар, онлайнаар оролцсон тохиолдолд хүчин төгөлдөр болох ирц бүрдэнэ.
- 11.8. Хурлын явцад тэмдэглэл хөтөлнө.
- 11.9. Хурал дээр хэлэлцэж буй асуудлаар санал хураахад гишүүн бүр нэг саналын эрх эдэлнэ.
- 11.10. Хуралд санал өгөх эрхээ бусад гишүүнд болон өөр этгээдэд итгэмжлэх замаар хэрэгжүүлэхийг хориглоно.
- 11.11. ТУЗ-ийн хурлын шийдвэр нь хуралд оролцсон гишүүдийн дийлэнх олонхийн (2/3) саналаар хүчин төгөлдөр болох бөгөөд шийдвэр нь тогтоол хэлбэртэй байна. Тогтоолд хурал даргалсан ТУЗ-ийн гишүүн гарын үсэг зурж баталгаажуулна. Харин их хэмжээний хэлцэл хийх шийдвэр гаргаж байгаа бол ТУЗ-ийн гишүүд бүгд зөвшөөрсөн тохиолдолд шийдвэр гарна.

- 11.12. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх асуудлыг шийдвэрлэж байгаа бол уг хэлцлээс ямар нэг хэлбэрээр орлого хүртэх боломжтой эсхүл өөрөө болон нэгдмэл сонирхолтой этгээд нь хэлцлийн нөгөө тал болж байгаа, эсхүл хэлцэл зуучлагч, төлөөлөгчөөр оролцож байгаа ТУЗ-ийн гишүүн уг асуудлаар болон хэлцлийн зүйлийн үнийг тогтоох асуудлаар санал өгөх эрхгүй байна. Энэ тохиолдолд шийдвэрийг саналын эрхтэй гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ. Санал тэнцсэн тохиолдолд шийдвэрийг ТУЗ-ийн даргын саналаар гаргана.
- 11.13. ТУЗ-ийн хурлын тэмдэглэлд дараах асуудлыг заавал тусгасан байна:
- 11.13.1. хурал хуралдсан газар, өдөр, цаг;
- 11.13.2. хуралд оролцсон гишүүдийн нэр;
- 11.13.3. хурлаар хэлэлцсэн асуудал;
- 11.13.4. санал хураалтаар шийдвэрлэсэн асуудал болон саналын хураалтын дүн;
- 11.13.5. тухайн асуудлаар эсрэг саналтай байсан гишүүдийн нэр, эсрэг саналтай байсан үндэслэл;
- 11.13.6. гаргасан шийдвэр.
- 11.14. ТУЗ-ийн хурлын тэмдэглэлд оролцсон гишүүд гарын үсэг зурах бөгөөд тэмдэглэлийн үнэн зөвийг тухайн хурлын дарга хариуцна.
- 11.15. ТУЗ-ийн хурлын тэмдэглэлийг буруу хөтөлсөн нь уг хурлын шийдвэрийг хүчингүйд тооцох үндэслэл болохгүй.

#### **Арванхоёр. Хариуцлага**

- 12.1. ТУЗ-ийн гишүүн Компанийн тухай хууль, Компанийн дүрэм болон энэ журмаар тогтоосон үүргээ биелүүлээгүй, эрхээ хэтрүүлсэн тохиолдолд түүнд хариуцлага хүлээлгэх асуудлыг хувьцаа эзэмшигчийн хурлын дүгнэлтийг үндэслэн ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ.
- 12.2. ТУЗ-ийн гишүүнд дараах хариуцлага хүлээлгэнэ. Үүнд:
- 12.2.1. Энэ журмаар тогтоосон үүргээ биелүүлээгүй, эрхээ хэтрүүлснээс компанийн ашиг сонирхолд ноцтой хохирол учруулаагүй гэж үзвэл анхааруулна.
- 12.2.2. Дээрх зөрчлийн улмаас компанид хохирол учруулсан бол ТУЗ-ийн гишүүнээс чөлөөлж, хохирлыг нөхөн төлүүлэх талаар холбогдох арга хэмжээ авна.

----ooOoo----

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИЙН  
ЗӨВШӨӨРӨЛ, БАТЛАМЖ**

2023 оны ... дугаар сарын ...-ний өдөр

Монгол Улсын иргэн ..... тоот регистрийн дугаартай ..... овогтой ..... миний бие ..... ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн энгийн /хараат бус гишүүнээр сонгогдохоор нэрээ дэвшүүлж байна.

Миний бие Компанийн эрхэм зорилго, үйл ажиллагааны үндсэн чиглэл, хэтийн зорилтыг сайтар ойлгож байгаа бөгөөд өөрийн нэрийг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд дэвшүүлж байгаатай холбогдуулан:

1. Компанийн дүрэм, "Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам" болон холбогдох бусад журмуудтай сайтар танилцсан болохоо;
2. Монгол Улсын Компанийн тухай хууль, Компанийн дүрэм, "Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ын 3.2 болон (хараат бус гишүүний хувьд 3.3-т заасан) Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд тавигдах шалгуур, шаардлагыг бүрэн хангаж холбогдох баримт бичгүүдийг энэхүү баталгаанд хавсаргасан болохоо;
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн анкетыг үнэн зөв бөглөсөн болохоо;
4. Монгол Улсын компанийн тухай хуулийн 99.1-д тодорхойлсон нэгдмэл сонирхолтой этгээдийн мэдээллийг үнэн зөв гаргаж өгсөн болохоо;
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдсон тохиолдолд компанийн болон хувь хүний нууцыг чандлан хадгалж, зөвхөн компани болон нийслэлийн иргэдийн эрх ашгийг эрхэмлэн, үнэнч шударгаар, тууштай ажиллахаа, цаг завьн хувьд ийнхүү ажиллах боломжтой болохоо;
6. Энэхүү баталгааг хууран мэхлэх замаар болон хуурамч бичиг баримт бүрдүүлэн гаргасан бол хуулийн хариуцлага хүлээхээ тус тус баталж байна.

ЗӨВШӨӨРӨЛ, БАТЛАМЖ ГАРГАСАН

ТУЗ-ИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧ .....

"ТУЗ-ийн үйл ажиллагааны журам"-ын Хавсралт № 2

**"....." ХХК-ийн төлөөлөн удирдах  
зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн анкет**

1.Овог ..... 2. Нэр .....

2. Одоо хаана ямар ажилтай .....

3. Эрэгтэй эмэгтэй ( зурах) Зураг

4.Төрсөн ... оны .. дүгээр сар ..-ны өдөр

5.Төрсөн аймаг, хот ....., Төрсөн газар .....

6.Одоогийн захиргаа .....

10. Ам бүлийн байдал ( зөвхөн ам бүлд байгаа хүмүүсийг бичнэ)

№	Таны юу болох (эцэг,эх, ах дүү, хүүхэд, гэр бүл)	Овог нэр (хэний хэн)	Хаана ямар ажилтай	Регистер

11. Боловсрол

№	Хаана ямар сургууль төгссөн	Суралцсан он	Эзэмшсэн мэргэжил	Диплом №

12. Ажилласан байдал

№	Хаана ямар байгууллагад	Ажилласан он	Албан тушаал	Гарсан шалтгаан

13. ТУЗ-ийн гишүүнээр ажилласан байдал

№	Хаана ямар компанид	Сонгогдсон,	Ердийн болон хараат бус	Тайлбар

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЙЛАН

		гарсан он	гишүүний ал нь болох	

14. Мэргэжил дээшлүүлсэн байдал

№	Хаана ямар байгууллагад	Хэдийд ямар хугацаатай	Мэргэжил дээшлүүлсэн чиглэл

15. Бүтээл:

А.	Эрдэм шинжилгээний бүтээл /илтгэл, судалгааны тайлан г.м/	Хэдийд	Хаана хэвлэгдсэн
Б	Боловсруулсан төсөл, бичиг баримт		
В	Бичсэн ном товхимол		

16. Ур чадвар

Хэрэглээний програмууд:			
Гадаад хэл:			

17. Гавьяа, шагнал: .....

18. Өөрийн иргэний үнэмлэх, регистрийн дугаар, оршин суугаа хаяг, ажлын ба гэрийн утасны дугаар: .....

19. Онц яаралтай тохиолдолд танд мэдээ дамжуулах , холбоо барих хоёр хүний овог нэр, гэрийн хаяг, утасны дугаар (таны юу болох)

.....

АНКЕТ ҮНЭН ЗӨВ БИЧСЭН ..... ( )

**Хавсралт 9. Опцион эрхийг хэрэгжүүлэх журам**

**ОПЦИОН ЭРХИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ**

**Нэг. Ерөнхий зүйл**

- 1.1 [.....] ХХК (цаашид “Компани” гэх)-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны ... сарын ...-ний өдрийн ... тоот тогтоолын дагуу Компанийн ... ширхэг энгийн хувьцааг худалдаж авах эрхийг баталгаажуулсан опцион (цаашид “Опцион эрх” гэх) эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг энэхүү журам (цаашид “Журам” гэх)-аар зохицуулна.
- 1.2 Опцион эрхийг хэрэгжүүлэх ажиллагаанд Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл хяналт тавина.

**Хоёр. Опционы хэрэгжих хугацаа, опцион эзэмшигч**

- 2.1 Энэ журамд заасны дагуу Компанийн гаргасан ... ширхэг энгийн хувьцааг ... ([.....]) төгрөгөөр худалдан авах эрх бүхий Опционыг Компанийн Гүйцэтгэх удирдлага буюу менежментийн баг эзэмшинэ. Опцион эрхийн хэрэгжих хугацаа нь 2026 оны 12 сарын 31-ний өдөр дуусгавар болно.
- 2.2 Опцион эрх эзэмшигч нь Опцион эрхийг гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориоглоно.
- 2.3 Опцион эрх эзэмшигч нь Журмын 2.1-т заасан хугацаанаас өмнө Опцион эрхээ хэрэгжүүлээгүй тохиолдолд Опционы эрх дуусгавар болно.

**Гурав. Опцион эрхийн хэрэгжих нөхцөл**

- 3.1 Компанийн дунд хугацааны стратеги төлөвлөгөө, 2023-2025 онуудын бизнес төлөвлөгөөний зорилтуудыг 95-аас багагүй хувиар амжилттай хэрэгжүүлсэн нөхцөлд Опцион эрх хэрэгжинэ.
- 3.2 Журмын 3.1-т заасны дагуу Опцион эрх хэрэгжих нөхцөл бүрдээгүй эсхүл хувьцааны үнийг тогтоосон хугацаанд Опцион эзэмшигч төлөөгүй тохиолдолд Опционы эрх дуусгавар болно.
- 3.3 Опцион эзэмшигч нь энэхүү эрхээсээ татгалзах эрхтэй.

**Дөрөв. Бусад**

- 4.1. Энэ журмаар зохицуулаагүй бусад харилцааг Компани болон Опцион эзэмшигч нарын хооронд байгуулах гэрээгээр зохицуулна.

----ooOoo----

**Хавсралт 10. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах журам**

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ ЖУРАМ**

**Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

- 1.1. Энэхүү журмын зорилго нь “.....” компани (цаашид “Компани” гэх)-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурал хуралдуулах тухай шийдвэр гаргах, хувьцаа эзэмшигчдэд хурлын зар хүргэх, хурлыг танхимаар болон цахим хэлбэрээр зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Энэхүү журам болон түүнд оруулах нэмэлт өөрчлөлтийг Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн шийдвэрээр батална.

**Хоёр. ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ ШИЙДВЭР ГАРГАХ**

- 2.1. Компанийн ТУЗ хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Компанийн тухай хуулийн 59.4-т заасан хугацаанд, ээлжит бус хурлыг Компанийн дүрэмд заасан хугацаанд тус тус зарлан хуралдуулна.
- 2.2. Компанийн тухай хуульд заасан хурал зарлах эрх бүхий этгээд шаардлагатай тохиолдолд компанийн ээлжит бус хурлыг хэдийд ч зарлан хуралдуулж болно.
- 2.3. Хурал хуралдуулах шийдвэр гаргаснаас хойш хурлыг Компанийн дүрмийн 10.6-д заасан хугацаанд хуралдуулна.
- 2.4. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах өдрөөр тогтооно.

**Гурав. ХУРЛЫН ЗАР ХҮРГЭХ**

- 3.1 Хурал хуралдуулах тухай шийдвэр гаргаснаас хойш нэг хоногийн дотор хурал зарлагч этгээд нь хурлын зарыг Говь-Алтай аймгийн 88 баг дахь Компанийн төлөөлөгчид, Компанийн төлөөлөгч хурлын зарыг хүлээн авснаас хойш нэг хоногийн дотор хурлын зарыг тухай багийн хувьцаа эзэмшигчдэд тус тус цахим хэлбэрээр хүргэнэ.
- 3.2 Энэ журмын 3.1-д заасан цахим хэлбэрт утас, мессэж, мессенжер, и-мэйл зэрэг мэдээлэх дамжуулах боломжтой цахим хэрэгслийг ойлгоно.
- 3.3 Хувьцаа эзэмшигчдийн хурлын зард дараах мэдээллийг заавал тусгана.  
Үүнд:
  - 3.3.1 Компанийн оноосон нэр, байршил, хурал хийх өдөр, цаг,



байршил;

- 3.3.2 хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт;
- 3.3.3 хурал хуралдуулах хэлбэр;
- 3.3.4 цахим хэлбэрээр хуралдуулах бол холбогдох линк;
- 3.3.5 хурал зохион байгуулах комиссын даргын нэр, утас;
- 3.4 Компанийн тухай хууль болон компанийн дүрэмд заасан хурлын ирц хүрээгүй тохиолдолд энэ тухай тэмдэглэл үйлдэж, хойшлогдсон хурлын товыг тогтоон, хурлыг хойшлуулна.
- 3.5 Хойшлогдсон хурлыг Компанийн дүрмийн ... заалтын дагуу .. хоногийн дотор хуралдуулах бөгөөд зарыг энэ журмын 3.1-д заасан аргаар дахин хүргэнэ.

#### **Дөрөв. ХУРЛЫГ ЦАХИМ ХЭЛБЭРЭЭР ЗОХИОН БАЙГУУЛАХ**

- 4.1 Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг мэдээллийн технологийн шийдэл ашиглан зайнаас оролцох боломжтой цахим хэлбэрээр зохион байгуулж болно.
- 4.2 Цахим хурал зохион байгуулах үед дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна. Үүнд:
  - 4.2.1 хурлын материалтай танилцах боломжтой байх;
  - 4.2.2 цахимаар бүртгүүлэх боломжтой байх;
  - 4.2.3 асуулт асуух, саналаа илэрхийлэх боломжтой байх;
  - 4.2.4 санал хураалтад оролцох боломжтой байх;
- 4.3 Компани нь хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулах тохиолдолд дор дурдсан үүргийг хүлээнэ. Үүнд:
  - 4.3.1 хуралд оролцохоор бүртгүүлэх хүсэлт гаргагчийн биеийн байцаалт, итгэмжлэлээр оролцох этгээдийн итгэмжлэлийг хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалттай тулган баталгаажуулах;
  - 4.3.2 мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангасан байх;
- 4.4 Хурал хуралдуулах боломжгүй техникийн нөхцөл үүссэн тохиолдолд хурлыг хүчин төгөлдөр бус гэж үзэн хойшлуулж, дахин хуралдах өдрийг ТУЗ товлон.

#### **Тав. БУСАД**

- 5.1 Хувьцаа эзэмшигч хуралд өөрийн биеэр оролцох боломжгүй тохиолдолд хурлаар хэлэлцэж буй асуудлаар саналын хуудас ашиглан

саналаа өгч болно.

- 5.2 Хувьцаа эзэмшигчдийн хурлын саналын хуудасны загварыг хурал зохион байгуулах комисс батална.
- 5.3 Саналын хуудсаар санал өгөх хувьцаа эзэмшигч саналын хуудсыг бөглөн гарын үсгээр баталгаажуулна.
- 5.4 Хувьцаа эзэмшигч өөрийн баталгаажуулсан саналыг хуудсыг битүүмжилж Компанийн төлөөлөгчид хүргүүлэх эсвэл бөглөсөн саналын хуудасны зургийг авч, цахим хэлбэрээр хурал зохион байгуулах комисст илгээнэ.
- 5.5 Хурал хүчин төгөлдөр болох ирцийг Компанийн тухай хууль, Компанийн дүрмийн холбогдох заалтаар зохицуулна.
- 5.6 Хурлын дэлгэрэнгүй баримт материалыг Компани архивлан хадгална.

-oOo-

## Хавсралт 11. Ногдол ашгийн бодлого

### КОМПАНИЙН НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО

#### Нэг. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1 Энэхүү баримт бичгийн зорилго нь [.....] компанийн дунд болон урт хугацаанд баримтлах ногдол ашгийн бодлогыг тодорхойлоход оршино.
- 1.2 Ногдол ашгийн бодлогыг тодорхойлохдоо Компанийн тухай хуулийн 6 дугаар бүлэг, Компанийн дүрмийн холбогдох заалтуудыг баримтлахаас гадна Компани болон Компанийн хувьцаа эзэмшигчийн эрх ашгийг хамгаалах зарчим баримтална.
- 1.3 Энэхүү баримт бичиг болон түүнд орох нэмэлт өөрчлөлтийг Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид ТУЗ гэх) батална.

#### Хоёр. НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО

- 2.1 Компанийн үйл ажиллагаа тогтворжин Компанийн тухай хуулийн 6 дугаар бүлгийн 47 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаж ашигтай ажилласан тохиолдолд Компанийн ТУЗ-ийн шийдвэрээр ногдол ашиг хуваарилж болно.
- 2.2 Компанийн ногдол ашиг хуваарилахдаа дараах жил бүрийн цэвэр ашгийн 50 хүртэл хувьтай тэнцэх мөнгөн хөрөнгийг хувьцаа эзэмшигчдэд тогтмол буюу жил бүр хуваарилах ногдол ашгийн бодлого баримтална.
- 2.3 Компанийн цэвэр ашгийн хэмжээ өмнөх оноос өндөр гарсан тохиолдолд өмнөх онд хуваарилсан ногдол ашигтай тэнцэх хэмжээний мөнгөн дүнг тухай жилийн инфляцийн хувь хэмжээгээр нэмэгдүүлсэн дүнгээр ногдол ашиг хуваарилна.
- 2.4 Компани бизнесээ өргөжүүлэх зорилгоор эсвэл ногдол ашиг хуваарилснаар Компанийн бизнесийн хэвийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх нөхцөл байдал үүссэн тохиолдолд тухай жил ногдол ашиг хуваарилахгүй тухай шийдвэрийг хувьцаа эзэмшигчдийн хурлаас гаргаж болно.

#### Гурав. НОГДОЛ АШИГ ОЛГОХ ХЭЛБЭР

- 3.1 Компани ногдол ашгийг дараах хэлбэрээр олгоно. Үүнд:
  - 3.1.1 Мөнгөн хэлбэрээр
  - 3.1.2 Компанийн нэмж гаргасан хувьцаа хэлбэрээр
- 3.2 Мөнгөн хэлбэрээр олгох ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрт заасан хугацаанд хувьцаа эзэмшигчийн арилжааны банк дахь дансанд шилжүүлэх байдлаар олгоно.

- 3.3 Хувьцаа хэлбэрээр олгох ногдол ашгийг Компанийн зарласан хувьцаанаас нэмж гарган хувьцаа эзэмшигчид эзэмшүүлэх хэлбэрээр олгоно.

**Хавсралт 12. Гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээний төсөл**

**[.....] КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛТАЙ БАЙГУУЛАХ КОНТРАКТ**

2023 оны .. сарын ..ны өдөр

Дугаар ...

Есөнбулаг сум

Энэхүү контрактыг нэг талаас [.....] компани, түүнийг төлөөлж Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга [.....] (цаашид “Компани” гэх), нөгөө талаас [.....] компанийн Гүйцэтгэх захирал [.....] (цаашид “Гүйцэтгэх захирал” гэх), нар (цаашид хамтад нь “талууд” гэх) Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8, 76.1.9, Компанийн дүрмийн 11 дүгээр бүлгийн 11.8.4, 14 дүгээр бүлгийн 14.2, 14.3 дэх заалтуудыг тус тус үндэслэн дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

**Нэг. Нийтлэг үндэслэл**

- 1.1. Энэхүү контрактын зорилго нь [.....] компанийг үүсгэн байгуулах, Компанийн үндсэн үйл ажиллагаа эхлүүлэхэд шаардлагатай үйлдвэрийн барилга байгууламжийг ашиглалтад оруулах, техник тоног төхөөрөмжийг суурилуулах, хүний нөөц бүрдүүлэх, аюулгүй байдлыг хангах, цаашид үйлдвэрлэл, үйлчилгээ, борлуулалт, санхүү эдийн засгийн үр ашгийг тогтмол өсгөн нэмэгдүүлэх, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулах, Талуудын эрх үүрэг, хариуцлагыг тодорхойлоход оршино.
- 1.2. Энэхүү контракт нь 2023 оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн 2024 оны ... дугаар сарын ... -ны өдрийг дуустал 1 жилийн хугацаанд хүчинтэй байна.
- 1.3. [.....] компанийн санхүүгийн тайланд тусгагдсан [.....] (.....) төгрөгийн үндсэн, [.....] (.....) төгрөгийн эргэлтийн, нийт [.....] (.....) төгрөгийн хөрөнгийг контракт байгуулсан өдөр хүлээлгэн өгөв.
- 1.4. Компанийн 2023 оны бизнес төлөвлөгөө, зорилто зорилт, санхүүгийн болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөө нь энэхүү контрактын салшгүй хэсэг бөгөөд Гүйцэтгэх захирлын хийх ажлын хүрэх үр дүн болно.
- 1.5. Төлөөлөн удирдах зөвлөл контрактын биелэлтийг жилийн эцсийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан хэлэлцэхэд эсвэл контрактын хугацаа дуусгавар болох үед дүгнэнэ.

- 1.6. Конрактыг сунгахаар шийдвэрлэсэн нөхцөлд аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан тэнцэлд тусгагдсан үндсэн болон эргэлтийн хөрөнгийг сүүлийн байдлаар хүлээлгэн өгнө.

### **Хоёр. Компанийн хүлээх эрх үүрэг**

- 2.1 Гүйцэтгэх захиралд цалин хөлс, ажлын үр дүнд нь тохирсон шагнал, урамшууллыг энэхүү контрактад заасан нөхцөлийн дагуу олгох;
- 2.2 Компанийн стратеги болон бизнес төлөвлөгөө, зорилго зорилт, санхүүгийн болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;
- 2.3 Компанийн удирдлага зохион байгуулалтын бүтэц, албан тушаалын жагсаалт, орон тоо, цалингийн сангийн хэмжээг батлах;
- 2.4 Гүйцэтгэх захирал 30-аас дээш хоногийн хугацаагаар эзгүй байх (контрактаар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх боломжгүй) тохиолдолд захиралтай зөвшилцөн захирлын үүрэг гүйцэтгэгчийг томилж, эрх үүргийг нь тогтоох;
- 2.5 Компанийн үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан гүйцэтгэх захирлын зарцуулах зардлын хэмжээг батлах;
- 2.6 Гүйцэтгэх захирлыг мэдлэг, мэргэжлээ дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх, удирдах ажилд мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах;
- 2.7 Гүйцэтгэх захирлын контрактаар хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэхтэй холбогдуулж тавьсан саналд тухай бүр хариу өгөх, холбогдох мэдээллээр хангах;
- 2.8 Компанийн жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцэл, аудитын дүгнэлт, гүйцэтгэх захирлын ажлын тайлан, контрактын биелэлтийг хэлэлцэн үнэлэлт, дүгнэлт өгөх, гүйцэтгэх захиралд олгох урамшууллын хэмжээ, эсвэл хүлээлгэх хариуцлагын талаарх саналаа Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэх;
- 2.9 Ажлын явц, гүйцэтгэлтэй улирал бүр танилцаж санал, зөвлөгөө өгөх, шаардлага тавих;
- 2.10 Гүйцэтгэх захирал контрактаар хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй бол хууль тогтоомж, энэхүү контрактад заасны дагуу арга хэмжээ авах, сахилгын шийтгэл ногдуулах;
- 2.11 Шаардлагатай гэж үзвэл Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр Компанийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх;
- 2.12 Гүйцэтгэх удирдлага болон компанийн эрх бүхий албан тушаалтнуудын

буруутай үйл ажиллагааны улмаас байгууллагад хохирол учруулсан, байгууллагын зорилго, зорилт, эрх ашгийн төлөө шударгаар ажиллах эрх үүргээ хэрэгжүүлээгүй, хамт олны дотор уур амьсгалыг эвдэж, үл ойлголцох байдал үүсгэсэн, үйл ажиллагаа явуулахад хүндрэл учруулсан нөхцөлд гүйцэтгэх удирдлага болон компанийн эрх бүхий албан тушаалтнуудад холбогдох хууль тогтоомж, энэхүү контрактад заасны дагуу арга хэмжээ авах, сахилгын шийтгэл ногдуулах;

- 2.13 Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр оролцоогүй, жилийн ажлын төлөвлөлт хангалтгүй, бизнес төлөвлөгөөний үндсэн үзүүлэлтүүдийг тодорхойлж чадаагүй гүйцэтгэх захирлыг ажлаас чөлөөлөх хүртэл арга хэмжээ авах;
- 2.14 Гүйцэтгэх удирдлага нь хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх үедээ байгууллагад хохирол учруулахгүй буюу ажилтныг хууль зүйн үндэслэлгүй ажлаас халахгүй байх үүрэг хүлээх;
- 2.15 Байгууллагад хохирол учруулсан, ажилтныг ажлаас үндэслэлгүй халсан нь шүүхийн шийдвэрээр тогтоогдож ажилд эргүүлэн томилж, байгууллагаас ажилгүй байсан хугацааны цалин хөлсийг нөхөн олгож, нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалд нөхөн төлөлт хийсэн тохиолдолд уг хохирлыг өөрийн хувийн эд хөрөнгөөр хариуцах;
- 2.16 Хөдөлмөрийн хуулийн 135 дугаар зүйлийн 135.3-т заасны дагуу "Эд хөрөнгийн бүрэн хариуцлагын тухай гэрээ"-г байгуулж, контрактын гэрээнд хавсаргах;
- 2.17 Хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

### **Гурав. Гүйцэтгэх захирлын хүлээх эрх үүрэг**

- 3.1 Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг Иргэний хууль, Компанийн тухай хууль, Хөдөлмөрийн хууль холбогдох бусад хууль тогтоомж, дүрмийн хүрээнд удирдан зохион байгуулах;
- 3.2 Компанийн менежментийг боловсронгуй болгох, техник технологийг шинэчлэх, бизнес төлөвлөгөө, зорилго зорилт, санхүүгийн төлөвлөгөөг үзүүлэлт бүрээр биелүүлэх. хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангах, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний чанарыг өндөр түвшинд хүргэх, өртөг, зардлыг хямдруулах, өр авлагыг бууруулах, ажилтнуудын нийгмийн асуудлыг оновчтой шийдвэрлэж ажиллах;
- 3.3 Компанийг итгэмжлэлгүйгээр гадаад, дотоодод төлөөлөх, итгэмжлэл олгох;

- 3.4 Өөрт олгогдсон эрх хэмжээний хүрээнд бусад хуулийн этгээд, иргэдтэй гэрээ, хэлцэл байгуулах;
- 3.5 Хүний нөөцийн бодлого боловсруулж батлах;
- 3.6 Ажилтнуудын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж батлах;
- 3.7 Компанийн хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу эзэмших, ашиглах;
- 3.8 Гүйцэтгэх захирал нь өмч эзэмшүүлэх гэрээг зохих журмын дагуу байгуулах, дүгнүүлэх;
- 3.9 Компанийн үйлдвэрлэл, технологи, бизнесийн нууцад хамаарах мэдээллийн зэрэглэлийг тогтоох, хамгаалах;
- 3.10 Холбогдох хууль тогтоомж, журмын дагуу ажилтныг ажилд томилох, чөлөөлөх, сахилгын шийтгэл ногдуулах, хөдөлмөрийн гэрээ байгуулах, дуусгавар болгох, батлагдсан цалингийн санд багтаан ажилтнуудын цалинг тогтоох;
- 3.11 Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийн дагуу анхан шатны бүртгэл хөтлөх, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын баталсан маягт. аргачлалын дагуу зохих мэдээ, тайланг цаг тухайд нь гаргаж өгөх;
- 3.12 Контрактаар хүлээсэн эрх, үүргээ гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэхгүй бөгөөд бусад этгээдийн өмнө ажил, үүрэг гүйцэтгэхгүй байж, контрактын биелэлтийг Төлөөлөн удирдах зөвлөлийн өмнө биечлэн хариуцах;
- 3.13 Компанийн хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад өдөр тутам хяналт тавьж, эд хөрөнгийн тооллогыг жил бүрийн эцэс зохион байгуулах;
- 3.14 Үйл ажиллагаандаа Компанийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг мөрдөж ажиллах;
- 3.15 Эрх хэмжээнийхээ асуудлаар хууль тогтоомжид нийцүүлэн тухайн компанийн хэмжээнд дагаж мөрдөх тушаал, заавар гаргах;
- 3.16 Маргаантай асуудлаар Компанийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргах;
- 3.17 Компанийн хамт олныг нэгдсэн удирдлагаар хангах, хамт олны дотор эерэг уур амьсгалыг бүрдүүлэн ажиллах;
- 3.18 Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд зайлшгүй хүндэтгэн үзэх шалтгаанаас бусад тохиолдолд хуралд оролцох, компанийн бизнес төлөвлөгөө, зорилго зорилт, санхүүгийн болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг оновчтой



тодорхойлох;

- 3.19 Хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх үедээ байгууллагад хохирол учруулсан буюу ажилтныг хууль зүйн үндэслэлгүй ажлаас халсны улмаас шүүхийн шийдвэрээр ажилд эргүүлэн томилж, байгууллагаас ажилгүй байсан хугацааны цалин хөлсийг нөхөн олгож, нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалд нөхөн төлөлт хийсэн тохиолдолд уг хохирлыг өөрийн хувийн эд хөрөнгөөр хариуцах;
- 3.20 Албан ажлаар гадаад улсад зорчих, ээлжийн амралт эдлэхэд Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад тус тус мэдэгдэж, зөвшөөрөл авах;
- 3.21 Хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг;
- 3.22 Гүйцэтгэх захирал дараах асуудлыг зөвхөн Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оруулж хэлэлцүүлэх замаар холбогдох шийдвэр гаргуулах үүрэгтэй.  
Үүнд:
- 3.22.1 холбогдох хуульд өөрөөр заагаагүй бол үйл ажиллагааны үндсэн чиглэлээс өөр төрлийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх;
- 3.22.2 хууль тогтоомжид нийцүүлэн компанийн үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөрөнгө олж авах, данснаас хасах, захиалах, шинээр авах;
- 3.22.3 Компанийн барилга байгууламжийг зохих журмын дагуу түрээслүүлэх, түүнд хөрөнгө оруулалт хийх зөвшөөрөл өгөх;
- 3.22.4 Салбар, төлөөлөгчийн газар байгуулах санал оруулж хэлэлцүүлэх;
- 3.22.5 Бизнесийн үйл ажиллагаатай холбоотой зардлын төсөв батлах,
- 3.22.6 Компанийн дүрэмд заасан эрх бүхий албан тушаалтныг томилох, чөлөөлөх, хөдөлмөрийн гэрээ байгуулах, цуцлах;
- 3.22.7 Их хэмжээний хэлцэл хийх, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох (Аливаа гэрээ хэлцлийн хугацаа нь энэхүү контрактын хугацаанаас илүү байж болохгүй)
- 3.22.8 Үйлдвэрийн газарт осол аваар гарч онцгой нөхцөл байдал үүссэн үед зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмж, сэлбэг материал худалдан авах;

**Дөрөв. Цалин хөлс, урамшуулал, ажлын нөхцөл**

- 4.1 Гүйцэтгэх захирлын албан тушаалын сарын үндсэн цалин нь [.....]

(.....) төгрөг болно.

- 4.2 Гүйцэтгэх захирал болон менежментийн багт Компанийн бизнес төлөвлөгөө, зорилго зорилтын хэрэгжилт, ашгийн үзүүлэлтийг харгалзан холбогдох журмын дагуу урамшуулал олгоно. Урамшууллыг мөнгөн хэлбэрээр болон опцион эрхийн хэлбэрээр хэрэгжүүлнэ.
- 4.3 Гүйцэтгэх захирлын ээлжийн амралт болон хөдөлмөрийн харилцаатай холбогдон үүсэх, энэхүү контрактаар зохицуулагдаагүй бусад асуудлыг Хөдөлмөрийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, дотоод журмаар зохицуулна.
- 4.4 Гүйцэтгэх захирлыг албан үүргээ гүйцэтгэхэд шаардагдах ажлын байр, суудлын автомашин, үүрэн телефон, техник хэрэгслээр хангана.

**Тав. Контрактад нэмэлт, өөрчлөлт оруулах, дуусгавар болгох**

- 5.1 Контрактад талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Контрактын нэмэлт, өөрчлөлтийг бичгээр үйлдэн зохих журмын дагуу баталгаажуулах бөгөөд энэхүү контрактын салшгүй хэсэг байна.
- 5.2 Контракт нь дор дурдсан үндэслэлээр дуусгавар болно. Үүнд:
  - 5.2.1. Талууд харилцан тохиролцсон;
  - 5.2.2. Контрактын хугацаа дуусаж, цаашид сунгагдахгүй болсон;
  - 5.2.3. Гүйцэтгэх захирал тэтгэвэр авах эрх үүссэн;
  - 5.2.7 Компани санаачилсан
  - 5.2.9 Гүйцэтгэх захирал санаачилсан
- 5.3 Компани дараах тохиолдолд контрактыг хугацаанаас нь өмнө цуцлах эрхтэй. Үүнд:
  - 5.3.1 Хувьцаа эзэмшигчдийн хурлаас контрактыг цуцлах талаар Төлөөлөн удирдах зөвлөлд удирдамж, чиглэл өгсөн;
  - 5.3.2 компани татан буугдсан, дампуурсан;
  - 5.3.3 гүйцэтгэх захирал контрактаар хулээсэн үүргээ биелүүлээгүй;
  - 5.3.4 гүйцэтгэх захирлын буруу шийдвэр, үйл ажиллагаагаар компанид их хэмжээний хохирол учирсан, алдагдалд орсон;
  - 5.3.5 гүйцэтгэх захирал хууль тогтоомж зөрчсөн, компанийг удирдан зохион байгуулах үүргээ биелүүлээгүй;
  - 5.3.6 хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангах үүргээ биелүүлээгүйгээс компанид ноцтой осол аваар гарсны улмаас хүний амь нас хохирсон,

- эрүүл мэндэд хүнд гэмтэл учирсан, компанид их хэмжээний хохирол учирсан;
- 5.3.7 өөр ажил олгогчтой хөдөлмөрийн зэрэгцсэн гэрээ буюу контракт байгуулсан;
- 5.3.8 гүйцэтгэх захиралд хүлээлгэн өгсөн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, үрэгдүүлсэн, өмчлөгчөөс олгосон эрх мэдлийг хэтрүүлсэн нь нотлогдсон;
- 5.3.9 хуульд заасан бусад үндэслэл.
- 5.4 Хөдөлмөрийн хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1.3 дахь заалтад заасан үндэслэлээр контрактыг цуцалж байгаа тохиолдолд 41.2 дахь хэсэгт заасны дагуу энэ тухайгаа Гүйцэтгэх захиралд хоёр сар, түүнээс дээш хугацааны өмнө мэдэгдэх үүрэгтэй бөгөөд гурван сар, түүнээс дээш хугацааны дундаж цалин хөлстэй тэнцэх тэтгэмж олгоно.

### **Зургаа. БУСАД**

- 6.1 Талууд контрактаар хүлээсэн үүргээ бүрэн буюу зохих ёсоор биелүүлээгүйгээс үүсэх үр дагаврыг бүрэн хариуцна.
- 6.2 Гүйцэтгэх захирал нь энэхүү контракт, холбогдох журмыг зөрчсөн нөхцөлд Төлөөлөн удирдах зөвлөл нь Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу сахилгын шийтгэл ногдуулж болно.
- 6.3 Гүйцэтгэх захирал нь хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх үедээ өөрийн буруугаас компанид учруулсан эд хөрөнгийн хохирлыг эд хөрөнгийн бүрэн хариуцлага хүлээхээс бусад тохиолдолд Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу зургаан сарын дундаж цалин хөлснөөс хэтрэхгүй хэмжээгээр хариуцан арилгах үүрэгтэй.
- 6.4 Эд хөрөнгийн бүрэн хариуцлага хүлээлгэхээр Хөдөлмөрийн тухай хуульд заасан тохиолдолд гүйцэтгэх захирал нь эд хөрөнгийн бүрэн хариуцлага хүлээнэ.
- 6.5 Гүйцэтгэх захирал нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Хөдөлмөрийн хууль, Иргэний хууль, бусад хууль тогтоомж, компанийн дүрэм, энэ контракттад заасан хөрөнгө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хэтрүүлэх, урвуулан ашиглах зэргээр тухайн компанид хохирол учруулсан бол уг хохирлыг өөрийн хөрөнгөөр бүрэн хариуцаж арилгана.
- 6.6 Контрактад талууд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж, баталгаажуулснаар хүчин төгөлдөр болж, контрактын хугацаа дууссанаар дуусгавар болно.
- 6.7 Энэхүү контрактыг Монгол хэл дээр 2 (хоёр) хувь үйлдэж, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал тус бүр 1 хувийг хадгална. Контрактын эх хувь тус бүр нь хууль зүйн адил хүчинтэй байна.

6.8 Талууд контрактад тусгагдаагүй асуудлыг шийдвэрлэхдээ Иргэний хууль, Компанийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг мөрдөнө.

**КОНТРАКТ БАЙГУУЛСАН:**

ТУЗ-ийн дарга

.....  
[.....]

Гүйцэтгэх захирал

.....  
[.....]

**Хавсралт 13. Зөвлөх үйлчилгээний компани, зөвлөхийн тухай мэдээлэл****Файнкон ХХК-ийн тухай**

Файнкон ХХК нь менежментийн зөвөлгөө өгөх чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх зорилготой 2021 онд Улаанбаатар хотод байгуулагдсан.

Өнгөрсөн хугацаанд Сод ассет менежмент ҮЦК, Чингис хаан хөрөнгийн бирж, Өлзий энд ко ҮЦК зэрэг санхүүгийн зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудад зөвлөх үйлчилгээ үзүүлж ирсэн туршлагатай.

Тухайлбал Сод ассет менежмент ҮЦК-ийг үүсгэн байгуулах, Санхүүгийн зохицуулах хорооноос үнэт цаасны зах зээлд “хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа” эрхлэх тусгай зөвшөөрөл авах, тус компанийн дэргэд хувийн хөрөнгө оруулалтын сан үүсгэн байгуулах, холбогдох зөвшөөрлийг авах, хөрөнгө оруулалтын санд 6.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт зуучлан татах, менежментийн компани болон хөрөнгө оруулалтын сангийн удирдах үйл ажиллагааг хэрэгжүүлэх, Чингис хаан хөрөнгийн биржийг үүсгэн байгуулах, компанийн дүрэм, үндсэн үйл ажиллагааны журмуудыг боловсруулахад зөвлөх үйлчилгээ үзүүлэх, Өлзий энд ко компанид хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлэх зэрэг ажлуудыг гэрээгээр хариуцан амжилттай гүйцэтгэсэн туршлагатай.

**Зөвлөхийн тухай**

Файнкон ХК-ийг үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх захирал Сандуйжавын Даваасамбуу нь Шинжлэх ухаан технологийн их сургуулийг инженер-эдийн засагч мэргэжлээр бакалавр цолтой, Монгол улсын их сургуулийн Эдийн засгийн сургуулийг бизнесийн удирдлагын мэргэжлээр магистр цолтой, Австрали Улсын Central Queensland University-ийг санхүүгийн менежмент мэргэжлээр мастер цолтой тус тус дүүргэсэн.

Монголын хөрөнгийн бирж, Мосдак, Улаанбаатарын үнэт цаасны бирж, Монголын үнэт цаасны клирингийн төв, Сод ассет менежмент ҮЦК зэрэг санхүү хөрөнгийн захын мэргэжлийн байгууллагуудад мэргэжилтэн, зөвлөх, албаны захирал, дэд захирал, гүйцэтгэх захирлын албан тушаалыг 30 гаруй жил хашсан.

Түүнчлэн Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй Багануур ХК, Гутал ХК, Улаанбаатарын үнэт цаасны биржид бүртгэлтэй Анд энерги ХК, Монголын хөдөө аж ахуйн бирж, Нийслэлийн орон сууцны корпорацийн НОСК-3 ТЗК, Гал сэнтий зэрэг 10 гаруй компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны дарга гишүүнээр ажиллаж байсан туршлагатай.

Мөн Үнэт цаасны хорооны хяналтын улсын байцаагч, Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны бодлогын зөвлөлийн гишүүн, нийслэлийн Чингэлтэй дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Төсөв санхүү эдийн засгийн хорооны дарга, Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны Удирдах зөвлөлийн гишүүн, Бүртгэлийн хорооны гишүүнээр ажиллаж байсан.

Дээрх ажил үүрэг, албан тушаалыг гүйцэтгэх хугацаандаа Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хэсгийн дэд бүрэлдэхүүнд ажилласан туршлагатай.

## Ашигласан материалын жагсаалт

1. Иргэний хууль
2. Компанийн тухай хууль
3. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль
4. [www.frc.mn](http://www.frc.mn)
5. [www.nasdaq.com](http://www.nasdaq.com)
6. Ross. S. A., Westerfield. R. W., Fundamentals of Corporate Finance, 2007
7. De Jongh. M., Shareholder activism at the Dutch East India Company, 2010
8. Ганзориг. Ө., Менежментийн психологи, 2019
9. Наранхүү. М., Процессын хүч, 2021
10. Санхүүгийн зохицуулах хороо, Компанийн засаглалын кодекс, 2022

